

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
“ТЭСРЭЛТ” ХӨГЖИЛД ХҮРГЭХ ҮҮ?


Хөдөө аж ахуйн шинэ бодлого

ТАВАНТОЛГОЙН АСУУДАЛ ТОЛГОЙ  
ЭРГҮҮЛСЭЭР...

2011. Дөрөвдүгээр сар. №003

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

## Мөнгөний байцаа Монголд сайн ургана



# EMONGOLIAN ECONOMY

4-р сарын ШИНЭ ДУГААР



Сэтгүүлийн захиалгыг редакцид авч байна.

Утас: 70110064, 88800825, 99015476  
Хаяг: Улаанбаатар, СБД VI хороо, Бага-Тойруу  
37Б, Байр - 206 тоот

## Эрхлэгчийн зурвас



Гаднынхан манай улсыг яагаад ингэтлээ сонирхох болов оо. Шил дараалан болох хурал семнарт оролцогчдын ихэнх нь гадаадынхан байх. Саяхан болсон нүүрсний тухай уулзалтын төлөөлөгчдийн дотор монгол хүн тун цөөхөн байлаа. Монгол Улс дэлхийн анхаарлын төвд хэдийнэ оржээ. Дэлхийн хөрөнгө санхүүгийн ахуулууд бүгд хөл тавилаа. Хонгконг, Лондоны хөрөнгийн биржийнхэн зэрэгцэн ирлээ. БНСУ-ын том топ компаниуд ч төмөр замын төслөө танилцууллаа. Манай авиакомпаниудын гадаад нислэгийн суудал дүүргэлтийг гаднынхан эзлэх болжээ. Монгол Улс үнэхээр хөрөнгө оруулагч болсныг харуулах бус уу. Албаны тоо баримт ч гадаадын

шууд хөрөнгө оруулалтын хэмжээ гэрлийн хурдаар өсөж байгааг харуулна.

“Invest Mongolia” ямар сонсогдож байна. Тэгвэл бид Монгол дахь хөрөнгө оруулалтын орчин хэр байгаа, давуу болон сул тал, онцлог, тулгамдсан асуудлуудын талаар тодорхой цогц ойлголт өгөхөд анхаарлаа хандууллаа. “Хөрөнгө оруулалтын тэсрэлт хөгжилд хүргэх үү?”, “Мөнгөний байцаа Монголд сайн ургана” зэрэг гарчиг бүхий сонирхол татсан нийтлэлүүд таныг хүлээж байна.

2011 оны нэгдсэн төсөв, тэр дундаа Төсвийн хөрөнгө оруулалтын “гажиг”-ийн талаар ч асуудал хөндлөө. Эрүүл мэндийн салбарт ердөө 54.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийхээр төлөвлөсөн бол улс төрийн амлалт биелүүлэхэд үүнээс 16 дахин их буюу 805.2 тэрбум төгрөг төсөвлөжээ. Гэтэл иргэдийн өвчлөл тухайлбал, хорт хавдар, зүрхний шигдээс, элэгний хавдар, гаж төрөлт зэрэг өвчлөл улам л ихэссээр байгаа нь манай улстөрчдийн ур ухааныг бэлхнээ харуулах тоон үзүүлэлт бус гэж үү.

За тэгээд Монгол орны гол салбар хөдөө аж ахуйн хөгжлийг цаг үетэй хөл нийлүүлэн алхуулах, улс орны ирээдүйн хөгжлийг тодорхойлохуйц шинэ эриний шинэ бодлого боловсруулж, амьдралд хэрэгжүүлэх санааг дэвшүүлсэн өгүүлэл энэ дугаарыг чимж өглөө. ХХААХҮЯ-ны дэд сайд Х.Золжаргалын хэлснээр хөдөө аж ахуй бол Монголын нэрийг дэлхийд гаргах боломжит салбар, мөн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж чадвал олон мянган ажлын байр бий болох юм. Мөн түүнчлэн “Усан цахилгаан станц хөгжил авчрах уу” нийтлэлээ хүргэж байна. Ирээдүйн өсөн нэмэгдэх хөгжлийн хурдыг гүйцэх эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох, мөн эрчим хүчээр хараат бус орон болох, дээр нь нийслэлийн гамшиг болсон агаарын бохидлыг томоохон чадлын усан цахилгаан станц барьж байгуулснаар шийдэх боломж буй талаар энэ нийтлэлээс уншаарай.

“Голомт” банкны гүйцэтгэх захирал Жон Фенаган манай сэтгүүлийн зочноор уригдаж, Монголын хөгжил, санхүү, хөрөнгийн зах зээлийн талаар ярилаа.

Ийн бид улс орны хөгжлийн томоохон гол бодлогыг хөндсөн нийтлэл, ярилцлага бүхий гурав дахь дугаараа танд хүргэж байна. Харин дөрөв дэх дугаартаа манай хөгжлийн бас нэг гарц болсон Монголын аялал жуулчлалын салбарын хөгжил дэвшлийн талаар бичих болно.

Д.Бэхбаяр

MONGOLIAN  
ECONOMY

Үүсгэн байгуулагч,  
Эрхлэгч: Д.Бэхбаяр  
9999 4248

Үүсгэн байгуулагч,  
Орлогч Эрхлэгч:  
И.Отгонжаргал  
8800 6228

Англи хэлний редактор:  
J.ltofo

Сэтгүүлч:  
Д.Мөнхчимэг  
9191 3154

Дизайнер:  
Э.Чингүүн

Маркетингийн менежер:  
Д.Бариянжав  
8880 0825  
Б.Энхцэцэг  
9901 5476

Утас/Факс: 976 - 7011 0064

Вэб: [www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)  
И-мэйл: [info@mongolianeconomy.mn](mailto:info@mongolianeconomy.mn)

Хаяг:  
Улаанбаатар, СБД VI хороо,  
Бага-Тойруу  
37Б, Байр - 206 тоот

Борлуулах цэгүүд:

“Интер ном”  
“Majestic” их дэлгүүр  
“Цэцэг төв”  
“Зиг за” автосервис  
“Мир” номын дэлгүүрийн  
“Grand plaza” дахь салбар  
“Мир” номын дэлгүүрийн  
“Metro mall” дахь салбар  
“Минж плаза”

“Улаанбаатар принт”  
ХХК-д хэвлэв


# headstart®




focus plus

Sharpens your senses.  
Not your pulse!

- ✓ Improves Concentration!
- ✓ Reduces stress!
- ✓ Vitamin containing!
- ✓ Optimal dosed!
- ✓ For Sport!
- ✓ At school!
- ✓ In business!



Developed by  
**Dr. med. Ernst Jakob**  
Head of department Sport Medicine  
at Hellersen Hospital of Sport Injuries.  
Inter al. since 1984 Team doctor Nordic  
Team of the German Ski Federation.  
Principal duties: biathlon, cross-  
country skiing and ski jumping  
[www.sportkrankenhaus.de](http://www.sportkrankenhaus.de)



**RIKA Sport GmbH & CoKG**  
Müllerviertel 19  
A-4563 Micheldorf, Austria

**headstart focus plus improves the power of concentration and reduces stress!**

## Refreshingly different!

**headstart focus plus** – the concentration supporting, stress reducing and refreshing drink for those who want to perform better: **in sports, business, school and everyday life.**

## What is different?

Drinks with high levels of refined sugar already contain high doses of glucose. The glucose is rapidly absorbed and leads to a fast rise of the level of blood sugar. After such „sugar-injections“ the human pancreas increases the production of the hormone insulin to neutralize the abruptly elevated level of blood sugar. The glucose then is taken out of the blood circuit and stored for a later use. This process causes in the following to this short-term “glucose high” to a reduced availability of glucose, which affects the brain as well (hypoglycaemia) with symptoms like reduced attention and/or nervousness and a lack of concentration.

“**headstart focus plus**” is different! A constant supply of energy for body and mind is granted through the balanced dosage, leading to better ability of concentration and a reduced level of stress.

## Tested for you!

In field tests, a performance improvement of 12 % was proven! The test persons felt more relaxed, more attentive and more determined to the tasks. Furthermore they could keep up their improved concentration over a longer period of time.

## Consumption!

To achieve the best possible performance of headstart focus plus, drink 100-120ml every 15-20 minutes. For 1,5 hours of increased “brain performance” one pack of headstart focus plus (500ml) is ideal.

**Concentration is the key to success – anywhere!**



Orderable on the internet-shop:

[www.headstart.at](http://www.headstart.at)

## 6-15 Invest mongolia

- 6 Мөнгөний байцаа Монголд сайн ургана
- 7 Хөрөнгө оруулалтын “тэсрэлт” хөгжилд хүргэх үү?
- 9 З.Баттүшиг: Монгол компаниуд тун удахгүй гадаадад хөрөнгө оруулж эхэлнэ
- 11 Хууль санаачилна гэдэг хүүхдийн тоглоом биш
- 13 Хөрөнгө оруулалт-ухаалаг бодлого
- 14 Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд

## 18-29 Эдийн засаг

- 18 “Өглөгч аав”, өвчинд нэрвэгдсэн ард түмэн...
- 20 Шидэт дохиур ба Хөгжлийн банк
- 22 Хөдөө аж ахуйн шинэ бодлого
- 25 Идээний дээж сүү юу, архи уу?
- 26 “Чөлөөт худалдааны боломжит зах зээлийг нээх хэрэгтэй”
- 28 Далайд гарцгүй орнуудын төв Улаанбаатар хотноо нээгдэх нь

## 30-33 Ногоон эдийн засаг

- 30 Усан цахилгаан станц хөгжил авчрах уу?
- 32 Ургаж буй цэцгийг бэлгэнд сонгоё

## 34-40 Хөрөнгийн зах зээл

- 34 Тавантолгойн асуудал толгой эргүүлсээр...
- 36 Хөрөнгийн биржийг хөгжүүлэх ажил эхэллээ
- Алишер Али: Монголчууд Казахстаны алдааг битгий давтаасай


## 41-53 Бизнес

- 41 Тэвчээр хатуужлын цараа шалгасан үйлдвэрлэл
- 42 Жон П.Финиган: Монголын банкууд өөрийнхөө хөрөнгөөр томрох магадлал тун бага
- 46 Бизнесийн орчин сайжирсан гэв үү?
- 47 Зээл хүртээмжтэй байна уу
- 49 “Цус сорогчдод зай байхгүй”
- 52 Өнгөрснийг ирээдүйтэй холбох гүүр

## 54-57 Market Data



...Манай эдийн засаг хурдтай хөгжиж, шинэ үзэгдлүүд элбэг гарах боллоо...(9)



...Гэрийнхээ ханыг ч дугуйлж амжаагүй санхүүгийн шинэ тоглогч дааж ядсан их ачаа үүрчээ...(20)



...Нобелийн шагналт Мохаммад Юнус өөрийн үүсгэн байгуулсан банкнаас хөөгдөв... (49)



Онцлох сэдэв

## Мөнгөний байцаа Монголд сайн ургана

**Т**өв Азийн зүрхэнд орших Монгол нутаг ашигт малтмалын арвин нөөцөөрөө бөмбөрцгийн өнцөг булан бүрээс хөрөнгө оруулагчдыг даллаж буй өнөө үед “Mongolian Economy” сэтгүүл гурав дахь дугаараа “Invest Mongolia” уриатай гаргаж байна. Дэлхийд толгой цохих Оюутолгой, Тавантолгойн орд маань эдийн засгийн эргэлтэд орж, нүүдэлчин монголчууд их бүтээн байгуулалтын шан татаж, нөр их ажлын өмнө нүүр тулаад буй. 2010 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 1.6 тэрбум ам.доллараас давсан бол гадаад худалдааны нийт эргэлт ДНБ-тэйгээ дүйцэж иржээ. Үүний хажуугаар үндэсний компаниуд өсөн томорч, олон улсын зах зээлд хөл тавих нь хэвийн үзэгдэл боллоо. Энэ бол Монголын түүхэнд байгаагүй сонирхолтой цаг үе...

“Ашигт малтмалын нөөцөөрөө Австралийг Казахстантай нийлүүлсэн юм шиг баян хэрнээ Монгол орон эдийн засгийн хэмжээгээрээ Молдав улсаас 25 хувиар бага. Гэвч одоо тус улс хөрөнгө оруулагчдын ертөнцийн хувьд өөрийгөө нээж байна. Монголын эдийн засаг ойрын арван жилд дэлхийн хамгийн өндөр өсөлтийг үзүүлэх боломжтой” хэмээн “Ренессанс капитал”-ын Судалгаа, шинжилгээний удирдлагын захирал, ерөнхий стратегич Роланд Нэш онцолж байв. Тийм ээ, бид Азийн дараагийн бар, “Монголын чоно” эдийн засагтай болох боломжтой. Гагцхүү уул уурхай даган орж ирж буй энэ их мөнгийг төр, засаг хэрхэн зөв зүйтэй хуваарилах вэ гэдэгт л гол асуудал бий.

Их мөнгө дандаа сайн сайхныг авчирдаг уу гэвэл үгүй. Конго, Нигери, Зимбабве, Уганда, Эквадор зэрэг баялгаасаа болж баларсан орны жишээ мундахгүй. Эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ огцом нэмэгдэж буйгаас болж Голланд өвчин, “халуун мөнгө” гээд олон асуудал бидний хаалгыг тогшиж байна. Гэвч Чили, Австрали, Канад, Арабын нэгдсэн Эмират гээд баялгаа зөв удирдан хөгжилд хүрсэн орны жишээ олон байгааг дурдах нь зүйтэй болов уу. Бусдын алдаанаас суралцаж, туршлагаас судлах аятай боломж

байгаа учир монголчууд бид азтай.

“Ухаантай хөрөнгө оруулагчийн хувьд Монгол Улс чухал зах зээл мөн” хэмээн “Айвенхоу Майнз” компанийн захирал Роберт Фрийдланд хэлж байв. Гэхдээ манай эрдэс баялгийн салбарт хэтэрхий их мөнгө ороод ирлээ, одоо хангалттай. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 гаруй хувь нь зөвхөн ашигт малтмалын бизнест шингэж байхад аялал жуулчлалын салбарт нэг хүрэхгүй хувь нь ногдож буйгаас ийм дүгнэлтэд хүрч болно. Тиймээс эрдэс баялгаас бусад салбартаа хөрөнгө оруулалт хэрхэн татах вэ гэдэг дээр л манай эрх баригчид ухаан бодлоо уралдуулах цаг иржээ.

“Хөрөнгө оруулагчдад зөвлөхөд Монгол орон бол цагаан цаас юм. Манайд байхгүй салбар олон учир хөрөнгө оруулалтын асар их боломж бий” хэмээн “Ньюком” группийн гүйцэтгэх захирал Б.Болд тэмдэглэж байв. Манай нутгийн үржил шимтэй хөрсөнд мөнгөний байцаа тарихад маш сайн ургах боломжтойг мэргэжилтнүүд онцолж буй. Энэ боломж зөвхөн уул уурхайгаар хязгаарлагдахгүй ээ. Аялал жуулчлал, мал аж ахуй, дэд бүтэц гээд олон ирээдүйтэй салбар байгааг бид хөрөнгө оруулагчдад нээхийг зорьж байна.

Монголын бизнесийн орчин нэг үеэ бодвол нэлээд сайжирч байгаа ч хөрөнгө оруулагчдад мэдээлэл олдоцгүй байдаг гэх санал, шүүмжлэл бишгүй гардаг. Тиймээс “Mongolian Economy” сэтгүүл энэ дугаартаа Монголын эдийн засгийн байдал, хөрөнгө оруулалтын орчин ямар байгааг тодорхой таниулах үүднээс олон нийтлэл, ярилцлага бэлтгэсэн нь үр дүнгээ өгөх биз ээ.

За тэгээд хөрөнгө оруулалт гэхээр л гадаадаас орж ирж буй валютыг тоолоод суух нь учир дутагдалтай буюу. Тиймээс бид дотоодын аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж буй асуудлууд, нээгдэж байгаа боломжуудын талаар хангалттай мэдээлэл хүргэхийн тулд хууль эрх зүйн орчин, банк санхүү, зэрэг асуудлыг хөндлөө. Эдийн засгийн гол зүтгүүр болох хувийн хэвшлийнхэндээ ээлтэй орчин бүрдүүлэхийн тулд “Mongolian Economy” сэтгүүл байнга анхаарал тавихаа мөн дуулгая. ■

# Хөрөнгө оруулалтын “тэсрэлт” хөгжилд хүргэх үү?

Д.Мөнхчимэг

Монголд орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ гэрлийн хурдаар нэмэгдэж байна. Үүнийг батлах баримт, статистикийн мэдээлэл хөвөрсөөр. Өнгөрсөн онд манайд гадаадаас 1.5 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэж рекорд тогтоосон бол энэ жил уг үзүүлэлт хоёр дахин өсч мэдэхийг мэргэжилтнүүд тооцоолжээ. Энэ их мөнгөний урсгал эдийн засгийн салбарт маань юу авчрах бол оо? Гадаад валютын нөөц 2.4 тэрбум ам.долларт дөхөж очсон, гадаад худалдааны нийт эргэлт ДНБ-тэй тэнцсэн, эдийн засгийн өсөлт 10 хувьд хүрэх таамаглал гарсан гээд макро түвшинд сайн мэдээ бишгүй дуулдана. Гэвч энэ бүхэн микро түвшинд буюу монголчуудын бодит амьжиргаанд хэрхэн нөлөөлөх вэ, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдээс эхлээд өрх гэрийн амьдралд яаж тусах вэ гэдгийг бид хамгийн түрүүнд бодолцох хэрэгтэй болов уу.

## Энэ бол зөвхөн доллар биш

Эдүгээ манай эрдэс баялгийн салбарт “Vale”, “Rio Tinto”, “Peabody Energy”, “Leighton” зэрэг уул уурхайн “акулууд” ажиллаж байгаагийн зэрэгцээ дэлхийн хэмжээний Оюутолгой, Тавантолгойн төсөл хоёул ашиглалтад орлоо. Уурхайчид мэдээж хоол иднэ, хувцас өмсөнө, банкаар үйлчлүүлнэ. Ерөөсөө тэдний хэрэгцээ мундахгүй их гарна. Тиймээс зөвхөн уурхайчдын хэрэгцээг хангаад байхад л олон тооны үндэсний компани хөлжих боломж нээгдээд буй. Гэхдээ дэлхийн хэмжээний томоохон төслүүд олон улсын стандартад нийцсэн бараа, үйлчилгээг биднээс шаардана. Үүнийг монголчууд одооноос бодолцож, үйл

ажиллагаагаа идэвхжүүлж, өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр анхаарах цаг иржээ.


Ер нь үндэстэн дамнасан томоохон корпорациуд зөвхөн доллар тээж ирэхгүй ээ, Монголын нутагт. Тэдний оруулж ирэх техник технологи тав, арван тэрбум ам.доллараар ч хэмжигдэхгүй хөрөнгө оруулалт болох юм. Зөвхөн мөнгөний биш оюуны, технологийн хөрөнгө оруулалтын давалгаа айсуу. Уурхайн ажилчдаас эхлээд ханган нийлүүлэгчид маань мөнгөнөөс гадна мэдлэг шүүрч авбал жинхэнэ хожил болох юм. Томоохон компаниудаас үлгэр дуурайл авч, Европын стандартыг нутагшуулж, компанийн засаглал, менежментийн соёл зэргийг нэвтрүүлэх аятай боломж бүрдэж байна. Хувийн хэвшлийнхэн энэ тал дээр санаачилгатай байснаараа хожим нь өөрсдөө л хожиж үлдэх билээ. Ингэж чадвал бид ирээдүйгээ гартаа атгана. Монгол хүн жинхэнэ утгаараа баян болж, Монголын компаниуд өөрсдөө стратегийн хөрөнгө оруулагч болж ч мэднэ. Энэ бүхэн зөвхөн бидний хичээл, зүтгэлээс л шалтгаалах юм.

## Уул уурхай улам томорсоор

“Айвенхоу майнз” компани ирэх онд Оюутолгойн уурхайн барилгын ажилд 2.3 тэрбум ам.доллар зарцуулахаар төсөвлөсөн тухайгаа зарласан билээ. Энэ бол зөвхөн ганц төсөлд орж ирэх мөнгөний хэмжээ. Хажуугаар нь Тавантолгойн ажил юу юугүй шуудрах гэж байна. Нүүрсний энэ асар том уурхай ашиглалтад орсноор түүнийг даган бий болох дэд бүтэц, төмөр замын хөрөнгө оруулалтын асуудал босоод ирнэ. Энэ бүхнээс үзэхэд Монголд орж ирэх хөрөнгө оруулалтын хэмжээ гурван тэрбум ам.доллараар ч хязгаарлагдахгүй байж мэднэ. Гэхдээ их мөнгө дандаа сайныг дагуулдаг уу гэвэл бас үгүй. Баялгаасаа болоод баларсан орны жишээ ч мундахгүй.

Нидерланд, Саудын Араб, Нигер, Мексик зэрэг орныг нэрвэж дөнгөсөн Голланд өвчин гэх “чимээгүй тахал”, их мөнгөний урсгалыг даган сэмхэн орж ирээд, гэнэт гарч явахдаа гайчирч мэдэх “халуун мөнгө”... Энэ мэтийн томоохон сорилтын өмнө Монгол Улс нүүр тулаад байгааг олон улсын байгууллагууд анхааруулж буй. Үндэсний мөнгөн тэмдэгтийн

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын дүрмийн санд үндэслэж гаргасан ГШХО (сая ам.доллараар)



Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалтын газар


ханш хэт чангарч, уул уурхайгаас бусад салбар өрсөлдөх чадвараа алдах нь Голланд өвчний шинж тэмдэг гэдэг. Тэгвэл 2010 онд манай төгрөг америк долларын эсрэг дэлхийд хамгийн ихээр өссөн валют болсныг сануулах юун. Түүнчлэн уул уурхайн салбар Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 гаруй хувийг дангаараа “залгиж” байхад аялал жуулчлал, мэдээллийн технологийн салбарт ганц хувь нь ч шингээгүй байгааг юу гэж ойлгох вэ? Манай ДНБ-ий 30, экспортын 85 гаруй хувийг зөвхөн ашигт малтмал бүрдүүлэх боллоо. Гэтэл төр, засгийн эрхмүүд эрдэс баялгийн орлогоороо уул уурхайн бус салбаруудаа босгож ирэхийн оронд бэлэн мөнгө тарааж, ДНБ-ийхээ 10 хувьтай дүйцэх хэмжээний алдагдалтай төсөв баталчихаад сууж байна шүү дээ.

**Эцэст нь...**


Тундахгүй Монголын компаниуд гадаадад хөрөнгө оруулах хэмжээний чадалтай болохыг Гадаадын хөрөнгө оруулалтын газрын орлогч дарга З.Баттушиг тэмдэглэж байна. Үнэхээр ч манай үндэсний компаниуд өсөн томорч байгааг харах юутай сайхан. “Petro Matad”, “Mongolian mining corporation”, “Hunnu Coal”, “Naranga resources” зэрэг үндэсний болон хамтарсан компани Лондон, Хонконг, Австралийн хөрөнгийн биржээс их хэмжээний хөрөнгө татан төвлөрүүлж чадлаа. Хэдхэн жилийн өмнө монголчуудын хувьд мөрөөдөл төдий байсан олон улсын зах зээл өнөөдөр бидний өмнө үүд хаалгаа нээлээ. Гадаадын хөрөнгө оруулалтаар бий болсон томоохон компаниудыг хөлжсөн хойно нь дотоодын аж ахуйн нэгжүүд өөрийн болгох үзэгдэл ч мэр сэр гарах болов. Тухайлбал, “Skytel” компанийн солонгос эздийн хувьцааг өнгөрсөн өвөл “Шунхлай” групп худалдаж авсан билээ.

Хөрөнгө оруулалтын “тэсрэлт” шинэ үеийг даллаж байна. Гэвч энэ шинэ орчин биднээс шинэ сэтгэлгээ, шинэ бодлого шаардах аж. Манай урд хөршийн компаниуд

Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт 2010 оны IV улиралд (салбараар)



Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт 2010 оны IV улиралд (улс орноор)



гадаадад хөрөнгө оруулалт хийж, бизнес эрхлэхийг төрөөс нь дэмждэг байна. Гэтэл Монголд дотоодын хөрөнгө оруулалтын тухай тусгайлан мөрдөж буй хууль тогтоомж хүртэл алга байх жишээтэй. АНУ болон Европын зарим орон банк, хэвлэл мэдээлэл, эрчим хүч, даатгал зэрэг салбарт хийгдэх гадаадын хөрөнгө оруулалтад өндөр шалгуур тавьсан байдаг. Харин манайд энэ мэтийн зохицуулалт огт байхгүй байгаа юм. Үүний хажуугаар Голланд өвчин, “халуун мөнгө” зэрэг эрсдэлийг бид хэрхэн тойрч гарах вэ, яаж даван туулах вэ гэдэг тал дээр ч төрийн бодлого үгүйлэгдэж буй. Уул уурхайн хөрөнгө оруулалтын “тэсрэлт” болох гэж буй өнөө үед төр, засгийн

эрхмүүд бодлогын түвшинд ихээхэн зүйл эргэж харах хэрэгтэй нь үүнээс харагдах биз ээ.

Олон арван жилийн турш гадаадын хөрөнгө оруулагчид Монголын баялаг говьд нүдээ унагаж ирсэн. Гэхдээ авлига, улс төрийн тогтворгүй байдал зэргээс болж зайгаа барьж байсан болов уу. Харин одоо Монголыг чиглэх хөрөнгө оруулалтын урсгал нэгэнт эрчимжжээ. Энэ их мөнгөнөөс аль болох ихийг эх орныхоо эдийн засагт шингээж чадах, эсэх нь манай эрх баригчдын бодлого, хувийн хэвшлийнхний санаачилга, иргэдийн идэвх зүтгэлээс хамаарах буй за. ■

## 3. Баттушиг: Монгол компаниуд тун удахгүй гадаадад хөрөнгө оруулж эхэлнэ

*Гадаадын хөрөнгө оруулалтын газрын орлогч дарга 3.Баттушигтэй ярилцлаа.*



ФотомэINET

**-Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ гэрлийн хурдаар нэмэгдэж байна. Энэ жил бүр гурван тэрбум ам.долларт хүрч магадгүй гэсэн таамаглал ч бий. Та Монголын хөрөнгө оруулалтын орчныг хэрхэн үнэлж, дүгнэдэг вэ?**

-Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн эхэн үед гадаадын хөрөнгө оруулалтыг аль болох их хэмжээгээр татах бодлого явуулж байсан. Энэ бодлогын хүрээнд зарим салбарт гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг тодорхой хугацаанд татвараас чөлөөлөх хууль ч үйлчилж байсан шүү дээ. Жишээ нь гадаадын хөрөнгө оруулалттай байгуулагдсан оёдлын үйлдвэрүүдээс 3-5 жилийн хугацаанд татвар авдаггүй байлаа. Гэвч энэ нь сайны хажуугаар саарыг ч дагуулсан. Ажлын байр ихээр бий болсон боловч энэ хуулийг буруугаар ашиглах тохиолдол ихээр гарч байлаа. Харин үүний дараа гадаад, дотоодын хөрөнгө оруулагч гэж ялгалгүйгээр ижил тэнцвэртэй

нөхцөл бололцоог олгох бодлогыг баримталж эхэлсэн бөгөөд энэ нь одоо хүртэл явагдаж байна. Өнөөдөр Монгол Улсыг дэлхий даяар мэддэг боллоо. Ашигт малтмалаар баян манай орныг уул уурхайн түүхий эдийн хамгийн том зах зээл болох Хятадтай хил залгаа оршиж байгаагаар нь гаднынхан мэдэж, сонирхож байна. Тийм ч болохоор эрдэс баялгийн салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирэх болсон.

**-Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 гаруй хувийг ашигт малтмалын салбар дангаараа эзэлж байна. Энэ нь Голланд өвчин дагуулах, уул уурхайгаас бусад салбарын өрсөлдөх чадварыг үгүй хийх аюултай юу?**

-Голланд өвчнөөс урьдчилан сэргийлэх үндсэн гарц нь эдийн засгаа төрөлжүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, уул уурхайгаас бусад салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татаж эрчимтэй хөгжүүлэх хэрэгтэй. Үүний тулд ямар бодлого баримтлах талаар

өргөн цар хүрээтэй судалгаа хиймээр байна. Ер нь сүүлийн үед уул уурхайн салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирж байгаа тул бид гадаадын хөрөнгө оруулалтын бодлогодоо дүн шинжилгээ хийж, эргэж харах шаардлага гарч байна. Иймд гадаадын хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулах ажлын хэсгийг Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, Гадаад харилцааны яамны хамтарсан тушаалаар байгуулсан бөгөөд одоо ажлаа эхлэх гэж байна. Уг стратегийг боловсруулахад манай улсын шилдэг эдийн засагчид, судлаачдын хувь нэмэр маш их хэрэгтэй гэж үзэж байгаа.

**-Гэхдээ стратеги бэлэн болохыг хүлээгээд л байх гэж үү. Яг одоо уул уурхайн бус салбартаа хөрөнгө оруулалт татах төрийн бодлого байна уу?**

-Засгийн газраас тодорхой ажлуудыг хийсээр ирсэн. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 700 орчим тоног төхөөрөмжийг гаалийн албан

» татвар болон НӨАТ-аас чөлөөлсөн. Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авсан. Тухайлбал, зөвшөөрөл авах олон шат дамжлагыг цөөлсөн. Мөн Концессын тухай хууль батлагдсан учир төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох төслүүдийн жагсаалт гарсан нь гадаадын хөрөнгө оруулагчдын гар дээр очиж байна. Энэ мэтээр уул уурхайн бус салбараа дэмжих ажил урагшилж л байна.

**-Нэгэнт л стратеги ярьж эхэлсэн болохоор үндэсний аюулгүй байдлын тухай сэдэв хөндөгдөх байх. Одоо бол манайд орж ирэх хөрөнгө оруулалт жилдээ хоёр дахин нэмэгдэх нь энгийн үзэгдэл болж байх шиг байна. Цаашдаа бид зарим салбарынхаа гадаадын хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээгээр хязгаарлах хэрэгтэй гэж Та боддог уу?**

-Аливаа асуудалд судалгаа, дүн шинжилгээтэй хандах нь их чухал гэж би үздэг. Зарим салбарын хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээгээр хязгаарлах тал дээр ч мөн бусад орны туршлагаас суралцахын зэрэгцээ Монголын нөхцөл байдалд тохируулж, өөрийн орны онцлогийг харгалзан үзэх ёстой. Тэгж байж зайлшгүй хамгаалах салбаруудаа тогтоох учиртай болов уу. Тухайлбал харилцаа холбооны салбар ихэнх улс оронд стратегийн ач холбогдолтойд тооцогддог бөгөөд тэр салбарт орох хөрөнгө оруулалтад нэлээд өндөр шалгуур тавих нь элбэг. Мөн Австралийн уул уурхайн салбарт 250 сая ам.доллараас давсан хөрөнгө оруулахын тулд Засгийн газрынх нь дэргэд байдаг зөвлөлөөс зөвшөөрөл авдаг журам байх жишээтэй.

**-Хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүртээмжгүй байдаг гэх голдол нэлээд гардаг шүү дээ. Гадаадын хөрөнгө оруулалтын тоон мэдээлэл л гэхэд их зөрүүтэй байгаа нь хүмүүсийг төөрөгдөлд хүргэж байна. Тухайлбал, Монголбанк 2010 онд манайд 1.5 тэрбум гаруй ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн**

**гэж байхад танай агентлагийн тооцоогоор энэ үзүүлэлт нэг тэрбум гаруй ам.доллар байна. Яагаад иймэрхүү зөрүү байна вэ?**

-Энэ бол үнэхээр чухал асуудал. Гадаадын хөрөнгө оруулалтын газар бол Монгол Улсад бүртгэгдэж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн дүрмийн сан дээр үндэслэсэн мэдээллийг гаргаж байгаа юм. Харин Монголбанкны төлбөрийн тэнцлийн хувьд тухайн компанийн дансаар орж гарч байгаа хөрөнгийг давхар тайлагнадаг байх жишээтэй. Мөн сүүлийн үед дотоодын компаниуд олон улсын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгож байна шүү дээ. Тийм учраас бид цаашдаа гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэл, мэдээллийн системийг зайлшгүй сайжруулах хэрэгтэй байна. Энэ тал дээр манай газраас тодорхой ажлуудыг ч хийж эхэлсэн.

Тун удахгүй дотоодын компаниуд гадагшаа хөрөнгө оруулалт хийдэг болох байх. Үүнд бид бас бэлтгэлтэй байж, боловсронгуй системтэй болох хэрэгтэй. Жишээ нь гадаадын хөрөнгө оруулалттай нэг компани байгуулагдлаа гэхэд манай агентлагт дүрмийн сангийн хэмжээгээ бүртгүүлдэг, харин нээсэн дансаар нь орж гарч байгаа хөрөнгийн урсгалын мэдээлэл Монголбанк дээр байдаг бол хэдэн монгол хүн авч ажиллуулсан тухай мэдээлэл нь Нийгмийн даатгалын ерөнхий газарт байх ёстой. Эдгээр мэдээллийг нийлүүлж байж цогц үзүүлэлт гарч ирэх юм. Үүний тулд бид уялдаа холбоогоо сайжруулж, аль болох дэвшилт технологи ашигласан нэгдсэн системтэй болох хэрэгтэй. Ер нь энэ их том ажил болох юм. Их чухал ч асуудал шүү дээ. Яагаад гэвэл энэ тоондээр л үндэслэж хөрөнгө оруулагчид тооцоогоо хийж, шийдвэрээ гаргадаг юм. Жишээ татахад манай урд хөрш хөрөнгө оруулалтын орж гарч байгаа урсгалыг маш сайн бүртгэн зарлаж байна.

**-Тун удахгүй манай компаниуд гадаадад хөрөнгө оруулалт хийж эхэлнэ гэж Та хэллээ. Үнэхээр үндэсний компаниуд маань өсөн томорч байна. Гэтэл тэд гадаадад хөрөнгө оруулалт хийлээ гэхэд**

**тодорхой хэмжээгээр дэмжих төрийн бодлого байна уу? Хятадын дотоодын аж ахуйн нэгжүүд гадаадад хөрөнгө оруулалт хийж, бизнес явуулахыг төрөөс нь нэлээд урамшуулдаг гэсэн...**

-Манай эдийн засаг хурдтай хөгжиж, шинэ үзэгдлүүд элбэг гарах боллоо. Гадаадад хувьцаа гаргана гэдэг санаанд багтахааргүй хэцүү зүйл мэт санагддаг байсан нь саяхан даа. Гэтэл сүүлийн хэдхэн жилийн дотор олон улсын хөрөнгийн биржээс хөрөнгө оруулалт татах явдал эрчимтэй хөгжиж байна.

Ер нь улс орнуудын туршлагаас харахад гадаадын хөрөнгө оруулалтаар анх босч, цаашдаа биеэ дааж гадагшаа хөрөнгө оруулах нь элбэг байдаг. Одоо Монголд анх гадаадын хөрөнгө оруулалтаар бий болж хөл дээрээ тогтсон бизнесийг эргүүлээд монголчууд худалдаж авч байна шүү дээ. Дотоодын хөрөнгө оруулагчид чадалтай, мэдлэг туршлагатай болж байна гэсэн үг. Үүнээс үзэхэд хэдхэн жилийн дараа монгол компаниуд гадаадад хөрөнгө оруулж эхлэх байх. Ний нуугүй хэлэхэд одоогоор гадаадад хөрөнгө оруулсан нөхцөлд тодорхой дэмжсэн, эсвэл урамшуулсан хууль эрх зүйн орчин алга.

Гэхдээ өнөөдрийн байдлаар Монгол Улс Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хоёр талын хэлэлцээрийг 44 оронтой, Давхар татварын хэлэлцээрийг 34 улстай байгуулаад байна. Мөн Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх Вашингтоны конвенци, Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай Сөүлийн конвенци зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон байгаа. Энэ хүрээнд Монголын компаниуд гадагшаа хөрөнгө оруулах бололцоо бий л дээ. Тодорхой хэмжээгээр эрх зүйн орчин бүрдсэн гэж ойлгож болно. Цаашдаа нарийвчлан судлаад, дотоодын компаниудаа хэрхэн дэмжихээ тодорхойлох хэрэгтэй болов уу.

**-Одоогоор манайд орж ирж буй мөнгөний дийлэнх хэсэг нь уул уурхайн салбарыг л чиглэж байна. Үүнээс монголчууд, Монголын компаниуд чадах чинээгээрээ өндөр ашиг хүртэж,**

► **эх орныхоо эдийн засагт аль болох их мөнгө шингээхийн тулд яах ёстой вэ?**

-Мэдээж эхний ээлжинд уул уурхай дагасан бусад салбараа л хөгжүүлэх хэрэгтэй. Эрдэс баялгийн томоохон төслийг сэлбэг хэрэгсэл, хоол хүнсээр хангахаас эхлээд дагалдах бизнес хөгжих өргөн боломжтой. Гэхдээ дэлхийн

хэмжээний компанид нийлүүлэлт хийхийн тулд дотоодын аж ахуйн нэгжүүд маань ч олон улсын стандарт хангах шаардлагатай болно. Ер нь гадаадын хөрөнгө оруулалт гэхээр л зөвхөн мөнгө бодох нь учир дутагдалтай л даа. Үүнтэй хамт мэдлэг, техник, технологи мөн соёл орж ирдэг. Компанийн засаглал, хувийн

бизнесийн соёл зэрэг ойлголтыг ч Монголын хөрсөн дээр буулгах хэрэгтэй болж байна. Энэ бүхний эцэст үндэсний компаниуд маань дэлхийн тавцанд гарахад ямар ч асуудалгүй болох учиртай. Тэгж байж л уул уурхайд орж ирж буй хөрөнгө манай эдийн засагт бодитойгоор шингэнэ шүү дээ. ■

**Бизнес эрхлэгч бичиж байна**

## Хууль санаачилна гэдэг хүүхдийн тоглоом биш

**Ц.Цэцэг**

(“Мон цахилгаан утас” компанийн ерөнхий захирал)

**М**анай хууль тогтоогчдын сүүлийн үед “үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүд” амьдралд буухдаа сөрөг үр дагавар үүсгэж, нийгэм, олон нийтийн дунд бухимдал төрүүлэх нь элбэг боллоо. Аливаа хууль богино настайгаар эргэн засварлагдаж байгаа нь үр өгөөж гэхээсээ илүү цаг зав барсан, хөрөнгө мөнгө үрсэн ажил болж байна.

Миний бие хуульч мэргэжилтэй, бизнес эрхэлж байгаа хүний хувьд хууль эрх зүйн орчныг хэрхэн бодит амьдралтай нийцүүлэх талаар саналаа хэлэхэд буруудахгүй болов уу. Эдийн засгийн 80 хувийг хувийн хэвшлийнхэн бүтээж байгаа бөгөөд бизнес өргөжин цэцэглэх нь улсын хөгжлийн хөшүүрэг билээ. Тэгвэл гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн хувьд хууль эрх зүйн тогтвортой орчин хамгийн чухал байдаг. Тийм ч болохоор хууль тогтоох ажил ил тод байх, аливаа хууль журмыг бий болгохдоо ард иргэд, бизнес эрхлэгчдээсээ санал авах тухай асуудал байнга сөхөгддөг биз ээ. Монгол Улс шиг нэг өглөө босоод ирэхэд л хууль өөрчлөгдсөн байдаг оронд бизнес эрхлэх нь ямар хэцүү болохыг идэвхтэй үйл ажиллагаа



явуулж буй 40 гаруй мянган аж ахуйн нэгжийн эзэд мэдэх буй за.

Аливаа хууль бий болохдоо тухайн улсын нийгэм, эдийн засгийн байдалд тулгуурлан амьдралын бодит хэрэгцээнд нөхцөлдөн ирж байгаашинэтгэлийг зөвтүсгах ёстой. Олон улсын туршлагыг өөрийн амьдралтай харьцуулан түүхэн судалгаанд үндэслэн ард түмний нийтлэг хүсэл зорилгоос урган гарч ирж байгаа харилцаа бол хууль юм. Үүнийг УИХ баталгаажуулан хэлбэрт оруулдаг. Гэтэл УИХ-ын дурын гишүүн мэргэжлийн бус атлаа хууль санаачлах эрхтэй байгааг юу гэж ойлгох вэ? Уг нь

УИХ хууль санаачлах бус, батлах ёстой баймаар.

Яагаад Монголд амьгүй хууль төрөөд байна вэ? УИХ-ын дурын гишүүн өөрийн үзэмжээр хууль санаачлах эрхээ эдэлж, түүнийхээ төлөө шагнал авч байна. Тухайн хуульд холбогдох судалгаа дутуу, санаачлагчийн хууль эрх зүйн талаар онолын болон мэргэжлийн түвшин доогуур байгаатай холбоотой гэж үзэж байна. Хууль санаачлагч өөрийн хувийн бизнесийг бодох, ивээн тэтгэгчийнхээ даалгаврыг биелүүлэх, авлигаа нуун бүрхэгдүүлэх зэрэг олон ►

шалтгаанаар эрхээ эдэлж, лоббийдох нөхцөл нь бүрдсэн байна. Энэ хаврын чуулганаар эхний ээлжинд 22 хуулийн төсөл хэлэлцэх дарааллыг тогтоосон бөгөөд үүнтэй холбогдуулан хууль санаачлагчид нийт 194 орчим хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хэлэлцүүлэхээр саналаа ирүүлсэн гэжээ. Үүнээс үзэхэд хууль санаачлах эрх бүхий дурын хүн энэхүү ажилд хүүхдийн тоглоом мэт хандах болсон байна. Товчхондоо, УИХ-ын хэлэлцэх хуулийн төслийн тоо тоймоо алдав.

Өнгөрсөн намар парламентын 20 жилийн ой болоход энэ хугацаанд 500 гаруй хуулийн төсөл хэлэлцэж баталснаараа сайрхаж байсан нь гайхалтай. Уг нь хэчнээн хууль баталснаараа биш, тэдгээр хууль нь амьдралд хэр зэрэг хэрэгжиж байгаагаар л ажлаа дүгнэмээр юм. Ер нь хууль аль болох цөөхөн, чадалтай байж гэмээнэ амьдралд хэрэгжих баталгаа бий болно. Эдүгээ Монгол Улсад 450 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ тоо цаашид хэрхэн нэмэгдэхийг хэлэхэд бэрх болжээ. Олон хуультай болсноор хоорондоо зөрчилдөж, эмх замбараагүй байдал үүсгэх болов. Мөн аливаа хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь энгийн үзэгдэл болсон бөгөөд “будаг нь үнэртсэн” хуулиудыг хүмүүс хүлээж авахад ойлголтын зөрүү даанч их гарч байна.

Тухайлбал, Улс төрийн намын тухай хууль Үндсэн хуультайгаа зөрчилдөж байгааг МАХН-ыг бүртгэж болно, болохгүй гэсэн маргаан харуулна. Засгийн газрыг бүрдүүлэхдээ УИХ-д суудалтай, суудалгүй хүн байна гэж талцаж байна. “Уртнэртэй хууль” буруу, зөв, Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ Үндсэн хуульд нийцсэн, нийцээгүй, Лиценз тэмдэгтийн хураамж зөв буруу, их бага зэрэг олон маргаан ар араасаа хөвөрнө. Гэтэл одоо бүр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах бололтой.

Үндсэн хуульд 2000 онд өөрчлөлт оруулснаас одоо үүсээд буй сөрөг үр дагаврын талаар ШУА-ийн жинхэнэ гишүүн (академич) С.Нарангэрэл багш хэлж л байсан. Мөн Үндсэн хуулийн “эх баригч”, гавьяат хуульч Б.Чимэд энэхүү бичиг баримтад гар хүрэх нь улс төрийн намуудын онцгой эрх ч

## 2011 оны УИХ-ын Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг дор дурдсанаар тогтоосон байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)
2. Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөл
3. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн төсөл
4. Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)
5. Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)
6. Төсвийн тухай хуулийн төсөл
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
8. “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай” УИХ-ын тогтоолын төсөл
9. “Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлан батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл
10. “Төсвийн хүрээний мэдэгдэл зөвшөөрөх тухай” УИХ-ын тогтоолын төсөл
11. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл
12. Компанийн тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)
13. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
14. Иргэний эрүүл мэндийн датгалын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/
15. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл
16. Алслагдсан болон говийн бүсийн нэмэгдлийн тухай хуулийн төсөл
17. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын цалин, тэтгэлэг, тэтгэмж, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл,
18. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төсөл
19. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
20. “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” УИХ-ын тогтоолын төсөл
21. “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл
22. “Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл
23. Бусад.

биш гэдгийг тэмдэглэсэн удаатай. Үүний тулд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй бүх нам зөвшилцөх хэрэгтэйг сануулснаараа тэрбээр цаанаа ард түмний хүсэл зорилгыг төлөөлсөн олон намыг хэлсэн болов уу.

Хэрэв Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар бол УИХ-ын гишүүн хууль санаачлах эрхийг л хязгаарламаар байгаа юм. Харин хуулийг иргэдийн төлөөлөгчдийн хурал санаачилж байж л илүү амьдралд ойр болох буюу. Яагаад гэвэл хууль өөрөө хэрэгжих хөрснөөсөө ургах ёстой. Гэтэл Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн нэгдүгээр заалтад “Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ” гэсэн байдаг.

Эртний Ромд өндөр урчадвартай мэргэжлийн цөөн хүн л хууль санаачлах, өөрчлөх, тайлбарлах эрхтэй байсан. Үүний адилаар хуулийг мэргэжлийн байгууллага нь нийгэм, ард олныхоо хэрэгцээнд үндэслээд судлан, санаачлах эрхтэй байвал амьдралд ойрхон

хууль гарна гэж бодож байна. Түүнчлэн ядахдаа УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны гишүүд нь зөвхөн мэргэжлийн хуульчид байх хэрэгтэй болов уу. Гэтэл өнөөдөр тус хорооны дарга Х.Жекей гэхэд л цэргийн команд, удирдлагын мэргэжилтэй хүн байх жишээтэй. Хууль зүйн байнгын хороо нийт 20 хүнээс бүрдэж байгаагийн бараг тал хувь нь мэргэжлийн бус хүн байгааг сануулах юун.

Эцэст нь, хууль амьдралаас ургаж гардаг байх ёстой. Нөхөн засдаг олон хууль үйлдвэрлэхгүй байх нь зөв агаад хууль тогтоогчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг сайжруулахад анхаарах цаг болжээ. СЭЗДС-ийн захирал Д.Батжаргал төрийн нууцаас бусад бүх асуудлыг ил тод хэлэлцэх хэрэгтэйг Монголын эдийн засгийн форумын үеэр тэмдэглэж байсан. Ялангуяа хуулийн хэлэлцүүлэг ард иргэд, аж ахуйн нэгжүүдийн хүсэл сонирхлыг тусгасан судалгаан дээр үндэслэн ил тод явагдаж байж бодит амьдралын хөрсөн дээр бууж хэрэгжих хууль төрөх биз ээ. ■

*“Mongolian Economy” сэтгүүл эдийн засагчийн булан нээлээ. Манай энэ буланг Ч.Отгочулуу хөтлөн явуулна. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал тэрбээр Монголд эдийн засгийн чиглэлээр сургууль дүүргэснээс гадна 2000-2006 онуудад ХБНГУ-д хоёр ч их сургууль төгсөж, эдийн засагчийн мэргэжил эзэмшсэн нэгэн.*



## Хөрөнгө оруулалт-ухаалаг бодлого

### Бид гаднынхны нүдээр...

Өнөөдөр Монгол Улс гаднын томоохон хөрөнгө оруулагчдын нүдэнд ямаршуу харагддаг бол оо? Тэдний Монголын талаар хэвлэлд өгсөн ярилцлага, бас уулзаж ярилцаж байхад төрж байсан бодол сэтгэгдэл дээрээ үндэслэн доорх төсөөллийг бий болголоо. Өөдрөг үзэлтэй хөрөнгө оруулагч нэгэн яагаад Монголд хөрөнгө оруулахаар сонирхож байгаа тухайгаа дараах маягаар илэрхийлэх болов уу.

“...-Монголын говь нутаг бол тэр чигээрээ урт хугацаатай, өндөр чанартай, хямд өртөгтэй хөрөнгө оруулалтын “бүтээгдэхүүн” юм. Учир нь, энергиэр өлсөж буй Хятадын ар нуруун дээр байгаа учир Африк, Австралитай харьцуулахад тээврийн зардал хямд гэсэн маш том давуу талтай. Өөрөөр хэлбэл, Монголын түүхий эд Хятадад хамгийн хямд өртгөөр тээвэрлэгдэн хүрэх боломжтой. Оюутолгой, Тавантолгой ашиглалтад ороод, том компаниудын санхүүгийн гүйлгээ, хувьцаа зэрэг нь Монголын банк, Монголын хөрөнгийн биржээр дамжаад эхэлбэл энэ орны санхүүгийн зах зээл асар хурдтай томорно. Монголын өсөлтөөс хувь хүртэх гэсэн компаниуд ч ихэснэ. Энэ бялуунаас хүртэх сонирхол бидэнд байна...” Харин Монголтой, Монголын улс төр, эдийн засаг, эрх зүйн орчинтой нэлээд гүнзгий танилцсаны дараа дараах маягаар шүүмж, гомдол хэлэх нь олонтаа. Жишээ нь, -Монголчууд зам тээврийн асуудлаа өөрсдөө шийдэх мөнгөгүй. Баялгаа тээвэрлэж чадахгүй бол борлуулж чадахгүй бөгөөд хэчнээн их нүүрс, зэстэй байгаад ч үнэ цэнэгүй. Магадгүй хөрш орнуудынхаа хэлсэн үнээр (дэлхийн түвшнээс хамаагүй доогуур) бага хэмжээнд өгөхөөс өөр аргагүйд хүрнэ.

-Байгалийн асар их баялагтай ч эндээс орж ирэх мөнгөө зөв удирдах эсэх, ер нь Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө үндэслэлтэй эсэх нь тодорхойгүй, хаашаа явах гээд байгаа, яг юуг эхэлж хөгжүүлэх гээд байна гэдэг нь ч тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, Монголын бодлого яг хөдөөгийн шороон зам шигээ газрын зураг үгүй.

-Монгол найдвартай, мэдлэгтэй ажиллах хүч тэр бүр олдохгүй юм.

-Танайд хөрөнгө оруулалтын орчныг хамгаалсан өмчийн эрх зүй, бизнесийн эрх зүйн орчин сул хэвээр

байна. Жишээ нь бид зээлдэгчийн хувиар Монголын аль нэг компанид зээл өглөө гэж бодье. Ямар нэг асуудал гарвал бидэнд барьцаагаа борлуулаад, зээлийн алдагдлаа нөхөх боломж хомс. Шүүх дээр яг ямар зарчмаар хэний талд шийдвэр гарах нь ч үзэмжийн асуудал болсон байдаг санагдсан. Товчхондоо өмчийн эрх зүй баталгаажуулаагүй.

-Монголтой ажиллахад хамгийн хэцүү нь ямар улстөрч ямар албан тушаалд байна гэдгээс их зүйл хамаардаг. Тэд бидний бизнесийн талаар юу бодож байгааг мэдэхэд цаг зав их гарзаддаг. Бодлого нь тогтвортой байх эсэх нь ч бас тодорхойгүй.

-Компаниудынх нь тайлан балансад итгэх аргагүй. Монголд капиталын өртөг их өндөр, жишээ нь зээлийн хүү, дээр нь инфляци болон төгрөгийн ханш тогтворгүй учир хөрөнгө оруулалтын далд нэмэлт зардал өндөр. Банкуудыг хянах тогтолцоо сул, банкуудад болон тэднийг хянадаг тогтолцоонд итгэхэд хэцүү...зэргээр Монголд хөрөнгө оруулсан хойноо толгой өвдөх, шаналах асуудлууд хэтэрхий олон гэж үглэх болов уу. Дээр нь монголчууд их бардам, “Монголтой Монголгүй дэлхий эргэдгээрээ эргэнэ” гэдгийг ойлгодоггүй гэж толгой сэгсрэх биз ээ.

Дээрхийг базаад үзвэл байгалийн асар их баялагтай Монгол оронд дэд бүтцийн хэрэгцээ, бодлогын тогтворгүй орчин, чадварлаг хүний нөөцийн хомсдол, банк санхүүгийн жижиг, дорой зах зээл, компанийн засаглал, ханшийн эрсдэл зэрэг бэрхшээл, сорилт тоочсоныг харж болно.

### Юу хийх шаардлагатай вэ?

Гаднын хөрөнгө оруулагчид мэдээж Монголыг хөгжүүлбэ гэж орж ирээгүй нь ойлгомжтой. Тэд их мөнгөний эзний хувьд зарим талаар хэт цэмцэгнүүр гэмээр шаардлага тавих нь ч зүй ёсны хэрэг.

Гэсэн хэдий ч дэлхийн аж үйлдвэрт хэрэгцээтэй түүхий эд нь манайд байна. Үнэ нь ч олон улсын зах зээл дээр өсч байна. Тэгэхээр тэд голж, шилэлгүй манай уул уурхайн салбарт хөрөнгө оруулж л таарна. Гэвч бодох юм байна. Манай экспортын 80 орчим хувийг нүүрс, зэс тэргүүтэй уул уурхайн түүхий эд бүрдүүлэх боллоо. Төсвийн орлого ч тэр уул уурхайгаас асар их хараат болж байна. Баян чинээлэг уул уурхайн компаниуд бусад салбарт

» ажиллаж буй шилдэг боловсон хүчнийг хуу хамж, цалингийн дундаж түвшний хүлээлтийг өндөр болгож байна. Төгрөгийн ханш чангарсны улмаас экспортоор амь зуудаг худалдаа, үйлчилгээ, аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарын компаниудын орлого хумигдаж, бусад зардал нь өсөх болов. Үүнийг Голланд өвчин гэх бөгөөд, гарах арга зам нь эдийн засгийн төрөлжилт болой. Өөрөөр хэлбэл, ноос ноолуур, банк санхүү, аялал жуулчлал, транзит тээвэр зэрэг ажлын байр олноор бий болгох чадавхитай салбаруудаа хөгжүүлж, экспорт болон төсвийн орлогод эзлэх хувийг нь зэгсэн нэмэгдүүлэх ёстой.

Мэдээж бид гаднын хөрөнгө оруулагчдыг шууд энэ салбаруудад хөрөнгө оруул гэж тулгаж чадахгүй нь тодорхой. Тийм учир уул уурхайд орж буй хөрөнгө оруулалтын үр ашгийг үндэсний эдийн засагтаа шингээх авхаалж, самбааг манай үеийнхэн гаргах учиртай. Үүний

тулд гурван түвшинд зэрэг анхаарах хэрэгтэй болов уу. Нэгдүгээрт, Монгол Улсын хөрөнгө оруулалтын ерөнхий орчныг бэхжүүлэх, хоёрдугаарт, мөнгө-санхүүгийн орчныг хөгжүүлэх, гуравдугаарт, тодорхой салбар (кластер)-т дотоод, гадаадын хөрөнгө оруулалт татахыг хөхиүлэн дэмжих зэрэг болно. Хөрөнгө оруулалтын орчин ялангуяа хууль, эрх зүйн орчныг шинэтгэхэд цаг хугацаа их орно. Харин үүний зэрэгцээ даруй хийж эхлэх хоёр, гурван зүйл байгаа юм.

-Монголын Засгийн газар өрийн бичиг гаргаснаар хувийн хэвшлийнхэн, ялангуяа банк санхүүгийнхэн “гаднаас мөнгө босгох” зам нь илүү дардан болох юм. Учир нь, Засгийн газрын олон улсын бонд нь “бенчмарк” өөрөөр хэлбэл, Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагч хүмүүст суурь, босго болж өгнө. Өнөөдөр гаднын санхүүгийн хөрөнгө оруулагчдын хувьд

Монгол Улс түнэр харанхуй шөнө адил харагдаж байгаа юм байна. Засгийн газар бондоо борлуулаад, суурь хүүгээ зах зээлийн жамаар тодорхойлуулах нь харанхуй гэрт лаа асаасантай адил ач холбогдолтой болох билээ.


Индонез улс жишээ нь гаднаас мөнгө босгох тал дээр сүүлийн үед оройхон гараад ширүүхэн дайрч байна. Байгалийн баялаг их, аялал жуулчлал хөгжүүлсэн энэ орон өөрсдийн боломжоо багцалж барьцаалах замаар санхүүжилт их сайн олж байна.

-Монгол Улс цаашдаа Чилийн сан юм уу Хятадын Хөрөнгө оруулалтын корпораци шиг эсвэл Сингапурын Темасек шиг өөрсдийн хөрөнгө оруулалтын сантай болох ёстой. Энэ сан нь уул уурхайн бус салбаруудад инноваци болон экспортыг дэмжсэн санхүүжилт хийх бөгөөд гаднынхны хөрөнгө оруулалтыг шууд бусаар төрөлжүүлэх үндсэн хэрэгсэл болох боломжтой. ■

### Гаднынхны нүдээр

*“Reuters” агентлагийн тусгай сурвалжлагч Дэвид Стэнэви өнгөрсөн онд “Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд” гэдэг нийтлэл гаргасныг манай өдөр тутмын зарим сонинд хөрвүүлэн хэвлүүлсэн байдаг. Тэгвэл “Reuters” энэ оны дөрөвдүгээр сард уг нийтлэлээ*

*шинэчлэн гаргасан нь ихэд сонирхолтой болжээ. Гаднынхны нүдээр харахад Монголын хөрөнгө оруулалтын орчин ямар байдгийг бид эндээс мэдэж болох юм. “Mongolian Economy” сэтгүүл энэхүү нийтлэлийн шинэчилсэн хувилбарыг уншигчдадаа хүргэж байна.*



## Монголд хөрөнгө оруулахад учирч болох улс төрийн эрсдэлүүд

Далайд гарцгүй Монгол орон нь эрдэс баялгийн арвин нөөцтэй. Уул уурхайн томоохон төслүүдэд орж ирж буй асар их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалтын буянаар үсрэнгүй хөгжилд хүрнэ хэмээн монголчууд итгэдэг. “Rio Tinto”, “Rea-body Energy” зэрэг ашигт малтмалын “акул”-ын хөрөнгө оруулалтын бай болоод буй энэ орны эдийн засаг өсөлтөөрөө дэлхийд толгой цохиж

мэдэхийг шинжээчид ч хэлдэг.

Дэлхийд дээгүүрт жагсах Тавантолгойн төсөл хэрэгжиж эхэлснээр Монгол Улс нүүрсний тал дээр бүс нутгийнхаа гол тоглогч болох хандлагатай. Уг ордын Цанхийн баруун хэсэгт үйл ажиллагаа явуулах уралдаант шалгаруулалтын хураангуй жагсаалт гарчихсан байгаа юм. Түүнчлэн “Эрдэнэс МГЛ” компани “Эрдэнэс Тавантолгой”-н IPO-г хийх

» хөрөнгө оруулалтын банкуудаа шалгаруулчихлаа. Үүний зэрэгцээ зургаан тэрбум ам.долларын Оюутолгойн уурхай 2013 онд ашиглалтад орсноор Монгол орон Чилийн дараа орох зэсийн томоохон үйлдвэрлэгч болох төлөвтэй. Гэвч гаднын хөрөнгө оруулагчид энэ оронд ажиллахаар сэтгэл шулуудахаасаа өмнө бодолцох зүйл их бий. Ардчиллын “ангаахай” гэж болох Засгийн газар нь шаардлагатай дэд бүтцийг бий болгох уу, улс төрийн тогтвортой байдлыг хангаж чадах уу, хууль эрх зүйн орчноо сайжруулж дийлэх үү. Мөн хамгийн чухал нь урд, хойд хөрш болох БНХАУ, ОХУ-ын геополитикийн дарамтыг зохицуулж, өөрийн хөгжлийн замаа олж чадах уу? Монголд байж болох эрсдэлүүдийг энд тоймлон хүргэе:

### Улс төрийн тогтворгүй байдал

Монголын ардчилсан Засгийн газрын “бааштай” зан нь гадаадын хөрөнгө оруулалттай төслүүдийг хүнд байдалд оруулж мэднэ. Тухайлбал, Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ л гэхэд улс төр болон хууль зүйн тодорхой бус нөхцөл, орон нутгийнхны шаардлага хийгээд гэнэт гарч ирсэн 68 хувийн татвар зэргээс болж таван жил сунжирсан билээ.

Түүнчлэн Монголын төр засгийн эрх баригчдын дунд халаа сэлгээ элбэг гардаг нь санаа зовоох асуудал юм. Эрдэс баялгийн нөөцийг төрөөс хатуу хянах, ард түмэндээ тэгш хуваарилах зэрэг гоё амлалтаар Монгол орны удирдагчид амь торгоож байна. Тиймээс шинжээчид энэ орны улс төрийн намуудын сул дорой байдал хийгээд хууль зүйн муу зохицуулалтад нэлээд гомдоллодог. Ялангуяа авлига нь Монгол Улсын хувьд удаан оршин тогтнох төлөвтэй. “Transparency International” агентлагийн гаргадаг авлигын индексээр Монгол Улс 2008 онд 102 дугаарт жагсаж байсан бол 2009 онд 120 дугаарт орж, “тушаал буурсан” юм. Харин 2010 онд ялимгүй дээшилж, 116 дугаарт багтсан байна.

### Юуг анхаарах вэ?

-Монголын эрх баригчид эрдэс баялгийн орлогоо хэрхэн зарцуулах вэ? Төсвийн тогтвортой байдлыг хангаж, боловсролд анхаарна хэмээж байгаа ч ард түмэндээ бэлэн мөнгө тараана гэсэн амлалт байсаар л байна.

-Гадаадын шууд хөрөнгө оруулалт дийлэнх хувийг эзэлж байгаа энэ үед Монголын Засгийн газар эдийн засгийн огцом өсөлт хийгээд түүний аюулгүй байдлыг хэрхэн зохицуулах вэ? Зэс, алтны Оюутолгойн төсөлд оруулж буй санхүүжилтийн хэмжээ л гэхэд дангаараа тус улсын 2009 оны ДНБ-тэй дүйцэж буй.

### Зохицуулалтын эрсдэл

Монголын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Засгийн газар уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын хууль журмуудыг тодорхой болгож цэгцэлтэл ашигт малтмалын лиценз олгох, шилжүүлэх явдлыг зогсоох тушаал гаргасан. Олон жилийн турш Монголд ажилласан хөрөнгө оруулагчдын хувьд энэ нь маш тодорхой бус байдлыг бий болгосон билээ.

Энэ юу ч биш. Өнгөрсөн арваннэгдүгээр сард

Монголын Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хүрээнд эхний ээлжинд алтны 254 лиценз цуцлах шийдвэр гарсан, цаашид уул уурхайн 1700 орчим тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно гэдгээ зарласан юм.

### Юуг анхаарах вэ?

-Шинэ хуульд орох өөрчлөлтүүд ямар байх бол?

-Иргэний хөдөлгөөнүүдийн дарамтад Засгийн газар өртөн, стратегийн ач холбогдолтой ордуудад хатуу хяналт тавих уу?

### Орос, Хятадаас хараат байдал

Монголын хараат бус байдал ямар тогтворгүй болохыг 2002 оны үйл явдал харуулсан юм. Төвдийн үзэл бодлын лидер Далай лам Улаанбаатарт уригдан ирэх үед Бээжин энэ айлчлалыг эсэргүүцэн, төмөр замын шугамаа хоёр хоногийн турш хаасан билээ. Ингэснээр 500 орчим зорчигч саатсан удаатай.

Чин династи нурж унаснаас буюу 1911 оноос монголчууд тусгаар тогтнож эхэлсэн ч гэлээ БНХАУ 1950 онд л Монгол Улсын хэрэгт оролцохоо байсан. Гэвч одоо ч Хятад улс Монголын эдийн засагт чухал байр суурь эзэлж байгааг өнгөрсөн оны нийт экспортынх нь 84 хувийг худалдаж авсан явдал гэрчилнэ биз ээ. Түүнчлэн Хятадаас орж ирдэг ажиллах хүчний урсгал Монголын уул уурхайн салбарыг эзэлснээр улам эрчимжих төлөвтэй хэмээн монголчууд айж байгаа.

Оросын талаас ч мөн монголчуудыг чадахаараа дарамталдаг. Энэ нь ялангуяа ураны салбарт нэлээд ажиглагдаж буй. Канадын “Khan Resources” өөрийг нь зайлуулахын тулд монголчуудыг араас нь өдөөн хатгаж, хөндлөнгөөс оролцсон хэмээн Москваг буруутгасан явдал гэрчилнэ. Монголыг “эзэгнэх” хоёр орны өрсөлдөөн бүр тээврийн дэд бүтцийг ч томоохон асуудалд унагасан. Геополитикийн энэ маргаан төмөр замын цариг болон шугамыг тойрон явагдсан юм. Нэгдүгээр “раунд”-ыг эцэстээ ОХУ хожиж, Монголын Засгийн газар өргөн царигтай төмөр замыг Тавантолгойгоос Оросын хил хүртэл тавихаар болов.

Монгол Улс Орос, Хятадын сонирхлыг эвтэйхэн тэнцвэржүүлж, “гуравдагч хөрш”-ийн бодлого баримтлан урагшаа алхахыг эрхэмлэж байна. Гэвч ямар ч орон Монголоос ОХУ, Хятадын нөлөөг арилгаж, Монголын хараат бус байдлыг баталгаажуулах чадваргүй гэж шинжээчид анхааруулж байгаа юм. Монгол орон эрдэс баялгаа хурдхан ашиглах хүсэлтэй байхад томоохон төслүүдийнх нь дийлэнх хэсэг нь геополитикийн асуудлуудын буланд шидэгджээ.

### Юуг анхаарах вэ?

-Монголын эдийн засагт эзлэх Хятадын нөлөө томорч байгаагаас олон монгол элит Оросын замаар явахаар сэтгэл шулуудаж байна. Гэвч Хятадууд тоглоомоос гарах нь юу л бол. Түүнчлэн Монголын автозам болон төмөр зам хаана, ямар маягаар баригдаж байгаа тухай ярих зүйл их гарч мэднэ. ■



**KIA MOTORS**  
MONGOLIA

# “КИА МОТОРС” 2011 ОНЫ ШИНЭ ЗАГВАР МОНГОЛД

“Mind changer” буюу “Сэтгэхүйг өөрчлөгч” уриатай, бизнесийн хурдны гайхамшгийг үзүүлж буй “Киа” брэндийн шинэчлэгдсэн ALL NEW-2011 загварын автомашинуудыг монголчууд хүлэглэж, салхи татуулан давхих боломж бүрдлээ. Солонгосын “Киа Моторс”-ын албан ёсны дистрибьютер, Монголын авто ертөнцөд шинэ, гайхалтай өөрчлөлтийг нэвтрүүлэгч “Киа Моторс Монгол” компани “Киа”-гийн Picanto-гоос эхлээд Mohave хүртэл бүх төрлийн автомашиныг Монгол хэрэглэгчдийнхээ сонголтод санал болгож байна.

“Киа”-гийн шилдэг, шинэлэг, эзнийхээ байр суурийг харуулж чадах автомашинууд Монгол нутагт хөл тавьж, монголчуудын сонголтод хувьсгал хийж буйг бататгасан ёслол өнгөрөгч баасан гариг буюу 2011-04-08-нд боллоо.



“Киа Моторс” корпорацийн Ази, Номхон далайн бүсийн салбарын Ерөнхийлөгч МК Ким БНСУ-аас хүрэлцэн ирж ёслолд оролцсон юм. Мөн УИХ-ын дэд дарга, Монголын Автомашин, Мотоциклийн Холбооны Ерөнхийлөгч Г.Батхүү оролцож, “KIA optima” маркийн автомашиныг танилцуулснаар ёслолыг нээлээ.

Grand  
OPENING CEREMONY  
2011-04-08

<http://www.mongolianeconomy.mn>

Хурд, хүч, тав тух, аюулгүй байдал, тансаг хэрэглээ, амьдралын өөр хэв маяг, өөрийгөө үнэлэх байр суурийг мэдрүүлэх "Киа"-гийн төмөр хүлгүүд олны харцыг булааж, сэтгэлийг татах нь энэ үдшийн нэгэн өнгө төрх байв. Морин хуур, хөөмийн аялгуу ёслолд оролцогсдын сонорыг мялааж, тал нутгаар "Киа"-гийн автомашинтай салхи татуулан давхиж, эрх чөлөөг тунхаглах шиг таатай мэдрэмжийг бас төрүүлж байлаа.

Энэ үдэш анхны худалдан авагчид болсон "Монгол даатгал", "АПУ", "Атибус" компани, ОХУ-ын Элчин сайдын яамны төлөөлөгчдөд "Киа Моторс Монгол" компанийн захирал Т.Буян-Ундрах гарын бэлэн батламж гардуулсан юм.

Онцлон тодотгоход, "Киа Моторс" үйлчлүүлэгчиддээ гурван жилийн буюу 100 мянган км-ийн баталгаа гаргаж өгсөн нь Монголд анхных. Өөрөөр хэлбэл, Монголд анх удаа хамгийн урт хугацаат баталгааг гаргасан нь нэг талаар автомашиныхаа чанар чансаанд итгэлтэйгнх, нөгөө талаар хэрэглэгчдээ эрхэмлэн хүндэтгэснийх гэлтэй. "Киа Моторс" корпораци БНСУ-ын хамгийн анхны автомашин үйлдвэрлэгч бөгөөд 1944 онд байгуулагджээ. "Киа" үйлдвэр нь шилдэг брэндээрээ дэлхийн автомашин үйлдвэрлэгчдийн тэргүүлэгч байх эрхэм зорилготой. Жилд найман орны 13 салбарт 2.1 сая гаруй автомашин үйлдвэрлэж, албан ёсны дистрибьютер компаниудаараа дамжуулан 172 орны хэрэглэгчдэд борлуулдаг байна. Дэлхий даяар 44 мянган ажилчинтай, жилд дунджаар 20 тэрбум ам.долларын ашиг олдог "Киа Моторс" Дэлхийн хөлбөмбөгийн холбооны албан ёсны түнш агаад Австралийн нээлттэй тэмцээний ивээн тэтгэгчээр ажиллаж буй. "Киа Моторс"-ын гол уриа нь "The Power to Surprise". Энэ нь үйлчлүүлэгчдийнхээ хүсэлт, хүлээлтийг үргэлж шинэ загварууддаа шингээн, шинэчлэн сайжруулахын илэрхийлэл болдог аж.



"Киа Моторс Монгол" компани 2011 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн "Киа Моторс"-ын Монгол дахь цорын ганц албан ёсны дистрибьютерээр ажиллаж байгаа юм. Тус компани "Киа" брэндийн автомашиныг эх орондоо нийлүүлэхийн зэрэгцээ өндөр туршлагатай, мэргэжлийн засварын баг орчин үеийн жишигт нийцсэн оношлогоо хийж, засвар үйлчилгээ үзүүлэх төв нээгээд байна.

NEW MONGOLIAN  
CHOICE



## “Өглөгч аав”, өвчинд нэрвэгдсэн ард түмэн...


Д.Чимэгээ

Дорж их өглөгч эр л дээ. Цалингаа авангууаа хэдэн хүүхдэдээ бэлэн мөнгө тараадаг, эхнэртээ бэлэг сэлт аваад дуусгадаг зуршилтай нэгэн. Ингэснээрээ эхнэр хүүхдүүдээ ихэд хайрлаж байгаа хэмээн баясна. Учраа мэдэхгүй бяцхан жаалууд тэр дор нь дэлгүүр орж, чихэр жимсхэн аваад мөнгөө үрж дуусгана. Гэтэл “гай газар дороос, гахай модон дотроос” гэдэгчлэн нүүрсний уурхайд ажиллаж ирсэн Дорж гэнэтхэн цомхтголд ороодхов. Дэлхийн зах зээл дэх нүүрсний үнэ уначихсан хэрэг. Хадгалсан юмгүй Дорж хэцүүхэн байдалд оржээ. Энэ цагаас гай зовлон эдний гэр бүлийг амраасангүй. Эхнэр нь дахиад хөл хүндтэй болсон ч арван сар тээсэн үрээ амьд мэнд гаргаж чадсангүй. Бага хүүгээ бурхны оронд илгээчихээд удаагүй байтал бусад хүүхэд нь сургуульд орох цаг ч боллоо. Гэтэл сургалтын төлбөр өгөх зардал байхгүй баларч сууна.

Харин Аугусто хамаагүй өөр бодлоготой. Тэрбээр цалингаасаа хүүхдүүддээ бэлэн мөнгө өгнө гэж “гонжийн жоо”. Хийл, төгөлдөр хуур, шатар авч өгөөд юм сургахыг илүүд үзнэ. Ер нь Аугусто их алсын хараатай. Сар бүр цалингийнхаа тодорхой хэсгийг хав дарж, хожим нь хүүхдүүдийнхээ эрүүл мэнд, боловсролд зарцуулах бодол тээнэ. Дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ буурсан ч Чилийн эр нөөцөлсөн юмтай болохоор дажгүй, додигор сууна. Аугустогийн хүүхдүүд том болоод Англи, Америк, Герман руу эрдэм сурахаар явцгаав. Өндөр боловсролтой залуус болж ирээд, эх орноо хөгжүүлэх ажилд шамдан оржээ.

Уг нь чили аавын амьдралын ухааныг хүмүүс магтан сайшаахыг Дорж олонтаа сонсож, цагтаа гэрт нь хүртэл зочилж амжсан хүн. Түүний туршлагаас суралцаж, зөв замаар гэлдрэхийн тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэдгийг баталсан тухай ч монгол аав сайн мэднэ. Даанч угаас ахархан ухаантай, амьжиргааны бололцоо муутай юм болохоор хэдэн хүүхдэдээ бэлэн мөнгө өгч буйгаа их юманд санаж явж л дээ...

Яагаад ийм жишээ татах болов оо? Монгол Улсын нэгдсэн төсвөөс 2011 онд дөрвөн их наяд төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн нь орлогоосоо 780 орчим тэрбум төгрөгөөр давж, нийт эдийн засгийн 10 хувьтай дүйцэж рекорд тогтоосон хэрэг билээ. Жилээс жилд данхайж буй төсвийн зарлага монголчуудад юу авчрах вэ? Энэ их мөнгийг эмнэлэг, сургууль барьж, ирээдүйн боловсон хүчин, эрүүл чийрэг залуусыг бэлдэхэд зарцуулж байсан бол сайн л хэрэг. Даанч үгүй ажээ.



2011 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 627.7 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр УИХ баталсан. Үүний дийлэнх хэсгийг буюу 44.1 хувийг дэд бүтцийн салбарт зарцуулахаар төлөвлөсөн бол эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд ердөө 10 хувь нь оногдож байх жишээтэй. Монголчууд энэ талаар нухацтай бодолцох цаг нэгэнт ирснийг сануулах сэтгэл сэрдхийм тоо баримтыг хөрвүүлбэ.

Эрүүл мэндийн салбартердөө 54.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийхээр төлөвлөсөн бол улс төрийн амлалт биелүүлэхэд үүнээс 16 дахин их буюу 805.2 тэрбум төгрөг төсөвлөсөн нь анхаарал татна. Гэтэл Монголын эрүүл мэндийн салбар өнөөдөр ямаршуу байгаа билээ? Халдварт өвчнөөр энэ оны эхний улиралд 9859 хүн өвчилжээ. Мөн хугацаанд тав хүртэлх насны 346 хүүхэд эндсэн байна. Гуравхан сарын дотор шүү дээ! Дотор муухайрам дээрх тоонууд дээр амьгүй төрсөн, гажигтай мэндэлсэн хүүхдүүдийг

» нэмээд үзэхээр юу болох бол оо? Хорт хавдар, зүрхний шигдээс, саажилт зэрэг аймшигт өвчин Монголын ард түмний дунд хүрээгээ тэлсээр. Энэ хэний буруу вэ? Дурын эмнэлгээр ороод эмч нарын ажиллаж байгаа орчин, эмнэлгийн барилгын байж байгаа царай, тоног төхөөрөмжийнх нь өрөвдөлтэй байдлыг нэг хараарай.

IV төрөх эмнэлгийн сураг дуулдаад, төсөв мөнгө нь шийдэгдэхгүй сажилж байх хооронд бид хүйн халдвараар хэдэн ч нялх амьтныг хорвоогоос хөөгөөд явууллаа даа. Уг нь тэр эмнэлгийг 19 тэрбум төгрөгт барина гэж байсан юм шүү дээ. Өөрөөр хэлбэл, 805.2 тэрбум төгрөгөөр бид ийм эмнэлэг 42 ширхэгийг босгочихож дөнгөх байжээ. Алт, зэс, нүүрс, уран байлаа гээд монгол хүн сэтгэл тэнүүн амьдарч, монгол үрс эрүүл саруул өсч бойжиж чадахгүй бол ямар хэрэгтэй билээ? 21 мянган төгрөг халаасандаа хийлээ гээд хэцүү цагт эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй бол ямар олиг байх вэ?

“Байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна” гэж Үндсэн хуульд заасан байдаг. Энэ заалтыг хэрэгжүүлэх үүднээс 76 гишүүн маань үүцээ задалж олсон мөнгөө үндэс нэгтнүүдтэйгээ хуваалцаж байгаа юм гэнэ. “Эх орны хишиг”, “Эрдэнийн хувь” гэх сайхан нэртэй сонгуулийн амлалт 21 мянган төгрөг болоод ард түмний гарыг цайлгаж буй. Гэтэл Үндсэн хуулийнхаа арванзургадугаар зүйлийг 76 гишүүн маань уншсан юм болов уу? Уг нь монгол хүн амьд явах эрхтэй юм байна. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй юм байна шүү, гишүүд ээ! Гэтэл энэ оны эхний улиралд 5091 гэмт хэрэг бүртгэгдэж, үүнээс болж 1874 хүн гэмтэж, 346 хүн нас барсан тухай Үндэсний статистикийн хороо дуулгав. Монгол хүнд ер нь амьд явах эрх байна уу?

Эдийн засаг, санхүү, төсвийн бодит боломжоос хэтэрсэн мөнгө хүнд бүрт амлаж, иргэдийн саналыг аван төрийн эрхэнд гардаг УИХ-ын гишүүдийн увайгүй үйлдэл Монголын ард түмний хамгийн чухал эрхийг ноцтойгоор зөрчиж буй бус уу? Үүнийг зогсооход чиглэсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төслийг бэлтгэж батлуулсан Засгийн газар улс төрийн нөлөөнд автаад таг чиг...

“2011 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим төслийг хойшлуулах замаар 2012 онд 116.5 тэрбум төгрөгийн ажлыг шинээр эхлүүлэхээр санал боловсруулсан. Энэ нь хэрэгжихгүй тохиолдолд 2012, 2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр төсөл хэрэгжүүлэх боломжгүй” хэмээн үзэж буйгаа Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооныхон “Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” сэдвээр илтгэл тавихдаа дуулгасан юм. Юу гэсэн үг вэ? ДНБ-ий 10 хувьтай дүйцэх хэмжээний алдагдалтай батлагдсан төсвийн чадал хөрөнгө оруулалтадаа ч хүрэлцэхээ байжээ.


Олон улсын валютын сангийн Ажлын хэсгийн ахлагч Стивен Барнетт “Бэлэн мөнгө тараах нь урт хугацаанд үр өгөөжгүй, инфляци өсгөхөөс цаашгүй. Харин эрүүл мэнд, боловсрол, дэд бүтцэд хөрөнгө оруулах нь эсрэгээрээ, хожим нь эерэг үр дагавар авчирна” хэмээн онцолж байсан. Үнэндээ манай орон хүнсний бараа, бүтээгдэхүүнийхээ 70 хувийг импортолдог. Түлш, шатахуунаа тэр чигээр нь

Оросоос авдаг. Ийм үед бэлнээр тарааж буй 805.2 тэрбум төгрөг урд, хойд хөрш рүү урсаад алга болох нь тодорхой бус уу? Өөрөөр хэлбэл, 802.5 тэрбум төгрөг тараахын оронд төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдээ санхүүжүүлбэл ашигтай ажээ. Энэ мөнгөөр хэчнээн эмнэлэг, сургууль, цэцэрлэг, спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн бий болох байсан бол оо?

Гэхдээ төсвийн хөрөнгө оруулалтыг нэмээд л бүх зүйл ОК болчихдог юм биш ажээ. Энэ тал дээр цэгцлэх ажил даанч их байгааг олон мэргэжилтэн сануулж буй. Эрх мэдэлтнүүдийн танилууд төсөвт өндөр өртөгтэй барилга, байгууламж “шахдаг”, тендер будлиантдаг, төлөвлөлтөд орон нутгийн оролцоо байхгүй байдгаас хөрөнгө оруулалт бодитой болдоггүй, давхарддаг, орхигддог, шаардлагагүй, үр өгөөж муутай төсөл олноор орж ирдэг гэх мэтийн олон зөрчил байдгийг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтнүүд ний нуугүй ярих аж. Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, үнэлгээ өгөх систем ч байхгүйг олон улсын байгууллагууд шүүмжилсээр өдий хүрлээ. Энэ мэтээр татвар төлөгчдийн мөнгийг тарамдаж, улс төрийн хожоо хайх булхайтай үйлдэл хэдий болтол үргэлжлэхийг бүү мэд.


Монгол оронд 80 төрлийн ашигт малтмалын 1170 орд, 8000 орчим илрэл бүртгэгдсэн гэх тоо бий. “Уул уурхай шууд эерэг дүн гаргаж чадахгүй, хэрхэн удирдахаас л шалтгаална” хэмээн Дэлхийн эдийн засгийн форумын төлөөлөгч Катрин МакПайл сануулж байв. Африктаа нефтийн хамгийн том экспортлогч болох Нигерийн нийт хүн амын 95 хувь нь маш ядуу, үлдсэн таван хувь нь маш сайн амьдарч байна. Тэгвэл Венесуэлийн эрх баригчид иргэдээ бухимдуулахгүйн тулд бэлэн мөнгө тараасаар ядууруулсан билээ. Ийм зовлонг монголчууд дайрч биш, тойрч гараасай гэсэндээ учир мэдэх хүмүүс зөвлөсөөр, сануулсаар. Гэтэл “өглөгч аав” үл ойшооно. “Өрмийг нь аваад хусмыг нь ард түмэндээ өгөх” бодлогодоо төрийн эрх баригчид нэгмөр автсан бололтой. ■

2011 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 627.7 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ



Улсын төсвийн хөрөнгө оруулалт (салбараар)





Санхүү

## Шидэт дохиур ба Хөгжлийн банк

И.Отгоо

### Хөгжлийн банк хэзээ үүдээ нээж, өрхөө татах вэ?

Хөгжлийн банк хуультай болсон. Менежментийг нь удирдан авч явах гадаадын туршлагатай багийг ч аль хэдийнэ өнгөрсөн оны төгсгөлд буюу 2010 онд багтаагаад сонгон шалгаруулчихсан. Түүнчлэн Хөгжлийн банкнаас 800 тэрбум төгрөгийн бонд гаргаж, орон сууцны зээлийг зургаан хувьд барих боломжтой гээд Засгийн газрын тогтоол гарсан. Ийнхүү Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гарах тоолон нийгэмд тус банкны өрхөө татаж, үүдээ нээхийг хүлээх хүлээлт улам бүр бадарч байна. Учир нь, уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуй гэх мэт ашиг багатай, урт хугацаанд үр өгөөжөө өгдөг төслүүдийг Хөгжлийн банк

санхүүжүүлж, хөгжлийг түргэвчилнэ гэсэн болохоор нийгмийн хүлээлт ийн өндөр байгаа хэрэг.

Тэгвэл Хөгжлийн банк хэзээ үүдээ нээх вэ? 2009 оны долдугаар сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд Хөгжлийн банктай холбоотой асуудлаар цаасан дээр буулгасан ажил бол их л дээ. Аль хэдийнэ үүдээ нээгээд, өрхөө татчихсан байгууллага гэж хэлж болохоор.

Зарим улстөрч биш мэргэжлийн хүмүүстэй уулзаад, Хөгжлийн банкны тухай ярилцахад, “Энэ бол төсөл шүү дээ. Төсөл техник, эдийн үзүүлэлтэй байх учиртай. Мөнгөн хөрөнгийн урсгал гэх мэт санхүүгийн нарийн үзүүлэлтүүд нь тодорхой байх ёстой. Гэтэл эдгээрийн юу юу нь ч байхгүй байгаад гайхаад байгаа” хэмээн учирлах юм билээ. Гэрийнхээ ханыг

ч дугуйлж амжаагүй санхүүгийн шинэ тоглогч дааж ядсан их ачаа үүрчээ. Мэргэжилтнүүдийн хэлж байгаагаар тенхик эдийн засгийн үндэслэл тооцоо нь байхгүй байгаа бол хачирхалтай л юм. Нарийн ширийн асуудлыг нь боловсруулдаг, мэддэг албаныханд холбогдох эдийн засгийн тооцоо нь байдаг байх гэж найдъя. Одоогоор Хөгжлийн банк нь ийм ийм техник, эдийн засгийн үзүүлэлттэй гээд хэвлэлд гаргасан мэдээлэл нээрээ байхгүй байгаа.

Хөгжлийн банк гэсэн энэ хоёр үг Алтан загасны үлгэр шиг улс төрчдийн санасан бодсоныг гүйцэлдүүдэг шидэт дохиур л биш бол тусгайлсан хууль, Засгийн газрын том шийдвэртэй зэрэгцэн хүмүүсийн гарт баригдаж, нүдэнд харагдах бодит ажил хийгдэж эхлэх ёстой баймаар.

» Олон түмэн урд өмнө нь манайд огт байгаагүй Хөгжлийн банк гэдэг санхүүгийн шинэ байгууллагын бат бөх хийцтэй хаалганы бариулаас сайтар атгаж, хүчтэйхэн татаж орохыг хүсч байна. Гэтэл Хөгжлийн банкны ТУЗ-ын даргаар томилогдож цөөнгүй сар толгой өндийх завгүй ажиллаж яваа Ч.Хашчулуунд одоогоор хань бараа болох Хөгжлийн банкны удирдлага болон гүйцэтгэх удирдлагыг томилох талаар сураг чимээ ч алга. ҮХШХ-ны цахим хуудсанд Монголын Хөгжлийн банкны хүний нөөцийн мэдээлэл бүрдүүлэх тухай зар тавьжээ. Уг мэдээллийг сонирхоход “Энэхүү банк байгуулагдсанаар өмнө нь Монголбанк, Арилжааны банкуудаас бүрдэж байсан Монгол Улсын банкны тогтолцоонд хөгжлийн санхүүгийн хэмээх гуравдагч шинэ институци бий болж байна. Эх орныхоо хөгжилд бодит хувь нэмрээ оруулах хүсэл, зорилго бүхий боловсон хүчин таныг Хөгжлийн банкинд ажиллахыг урьж байна” гэж уриалжээ. Дотоод аудитийн газрын захирал, Эрсдэлийн удирдлага хариуцсан дэд захирал гэх мэт 20 гаруй ажлын байр зарласан байв. Хөгжлийн банкны менежментийг удирдан жолоодох тендерийн олон улсын сонгон шалгаруулалтаар БНСУ-ын KDB тодорсон ч энэ тухай мэдээлэл бүдгэрсээр бүдгэрсээр сүүлдээ бүр нам жим болов. Сангийн сайд С.Баярцогт “Хуулиа баталсныхаа дараа тендерийн асуудлыг ч эргэж авч үзнэ” гэж хэлсэн удаатай. Тэгвэл энэ асуудал ямар шийдэл хүлээж байгаа бол оо.

2010 оны төгсгөлд тендерт ялалт байгуулаад баяртай буцсан БНСУ-ын KDB-ийн төлөөлөгчид асуудлаа шийдэгдэхийг сонирхож Монголд ирж, буцаж байгаа болов уу хэмээн чих тавьж үзлээ. “Ойрын хугацаанд л лав ирээгүй, сайн мэдэхгүй байна” гэхээс өөр мэдээлэл олсонгүй. Тэд асуудлаа сонирхон Монголд байн байн ирж, холбогдох яам, тамгын газраар эргэлдээд байдаггүй бололтой. Юмыг яаж мэдэх вэ?, Монголын Хөгжлийн банктэй холбоотой мэдээлэл тавьчихсан байж юуны магад гээд KDB-ийн сайтад зочиллоо, сонирхсон мэдээлэл байсангүй.

Энэ талаар Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны мэргэжилтэн Э.Цогбаярт хандахад “Тендерийн үнэлгээний хорооны урьдчилсан дүгнэлтээр БНСУ-ын Хөгжлийн банк шалгарсан. Гэхдээ Засгийн газраас KDB-г ялагчаар тодорсныг баталгаажуулж албан ёсоор зарлаагүй байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн банкны ТУЗ KDB-тэй тохиролцоо хийх эрхээ аваагүй гэж ойлгож болно. Тийм болохоор ТУЗ, тендерт ялагч этгээд хоёр хэлэлцээрийн ширээний ард албан ёсоор суугаагүй байгаа гэсэн үг. Тийм учраас Монгол Улсын Хөгжлийн банкныг БНСУ-ын Хөгжлийн банк удирдахаар болсон гэж хараахан үзэж болохгүй” хэмээн тайлбарлав. Хөгжлийн банкны талаар сонирхсон асуултад хариу өгөхдөө тун ч болгоомжтой, няхуур хандсан тэрбээр “Хөгжлийн банкны тухай хуулийг батлаагүй байхад яагаад тендерийн сонгон шалгаруулалт явагдсан юм бэ? Хууль бус болсон юм биш үү гэсэн яриа хүмүүсийн дунд байдаг. Тийм болохоор энд товчхон тайлбар хийх нь зөв байх гэж бодож байна. Засгийн газрын 2010 оны долдугаар сарын 26-ны өдрийн 195 дугаар тогтоолоор Хөгжлийн банкныг байгуулсан. 2009 оны Ерөнхий сайдын 66 дугаар захирамжаар Хөгжлийн банк байгуулах асуудлаар холбогдох санал болон баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий холбогдох байгууллагуудын төлөөлөл оролцсон Ажлын хэсэг гарч ажилласан. Тэгээд одоогийн мөрдөгдөж байгаа Банкны тухай хуулиар Хөгжлийн банкны үйл ажиллагааг зохицуулж болох юм байна гэж үзсэн. Гэтэл Монголбанк, УИХ-ын зарим гишүүний зүгээс одоогийн мөрдөж байгаа Банкны тухай хууль Хөгжлийн банкны зарим үйл ажиллагааг хязгаарлаж байна. Тийм болохоор тусгайлсан хууль шаардлагатай гэж үзсэний үндсэн дээр Хөгжлийн банкны тухай хуулийг 2010 оны аравдугаар сарын 2-нд баталсан. Иргэд Хөгжлийн банк үүдээ нээхгүй яагаад удаад байна гэж яарч байгаа. Манайд хөгжлийн санхүүгийн байгууллага байгуулж байсан түүх байхгүй. Хөгжлийн банк ач холбогдолтой ч нөгөө талаасаа эрсдэл өндөртэй. Буруу хийвэл улсын эрх ашиг

хөндөгдөх учраас яарч хэрхэвч болохгүй. Бидний төлөвлөснөөр явбал ирэх тавдугаар сард үүдээ нээчих байх” гэж хэлсэн.

## 800 тэрбумын бонд мөрөөдөл үү?

Хөгжлийн банкны 800 тэрбум төгрөгийн бондыг дотоодын зах зээлд 5, 10, 15 жилийн хугацаатай гаргах тухай Засгийн газрын шийдвэр нь монголчуудын хувьд бонд гэдэг өмнө нь төдийлөн сонирхож, ашиглаж байгаагүй санхүүгийн хэрэгслийн мэдлэгээ нэмэгдүүлэх шаардлагыг бий болгов. Монгол хүн бүр 536 ширхэг хувьцаа эзэмшигч болчихоод сүүлийн үед хувьцааны тухай мэдлэг, мэдээллийг чухалчилж байгаа шиг Хөгжлийн банк иргэдийг бондыг шохоорхоход хүргэх нь энэ.

800 тэрбум төгрөгийн бонд орон сууцны зээлийн хүүг зургаан хувьд барих зорилготой, тэгээд дээр нь хугацаа урттай гээд чихэнд чимэгтэй мэдээлэл олонтой. Гэвч “буянтай” бондын борлуулалт дотооддоо ямар байх вэ гэдэг хамгийн чухал асуудал. Улс төрийн шийдвэр бол эдийн засаг биш шүү дээ. Энэ талаар улс төрчид сайхан үг урсгаж байгаа ч банк, санхүүгийн мэргэжилтнүүд сайн гэж сайшаах дургүй байна.

Хөгжлийн банк жилийн зургаан хувийн хүүтэй мөргөйж санхүүжүүлнэ гэдэг хөрсөн дээр хэр буусан шийдвэр юм бол оо? Уг санхүүгийн хэрэгслийн борлуулалтын асуудлыг ялангуяа банкныхан тал талаас нь харж, хэдийнэ үнэлэлт дүгнэлтээ өгч амжсан. Энэ утгаараа Төвбанк болон арилжааны банкны холбогдох мэргэжилтэнд хандаж, 800 тэрбумын бондын борлуулалтын тухай сонирхоход, толгой сэгсрэхээс өөрөөр тодорхой зүйл ярихыг хүсэхгүй байна. Тэгэхээр маш бага хүү, урт хугацаатай 800 тэрбумын бонд өнөөдрийн манай найман тэрбум долларын эдийн засгаас ахадсан ачаа бололтой гэж дүгнэхээс яалтай. Яагаад тийм байна вэ гэдэг эдийн засгийн үндэслэлийг нь сонирхоод үзье. Манай арилжааны банкны зээлийн хүү жилийн 20 хувьтай байгаа. Түүнчлэн манай

» инфляцийн өсөлт 11 хувьтай, Төвбанкны үнэт цаасны хүү мөн хэмжээний хувьтай байгаа энэ үед жилийн зургаан хувийн хүүтэй, урт хугацаатай орон сууцны өрийн бичиг гаргана гэдэг мөрөөдөл хэмээн хэлэхэд хатуудахгүй гэж Төвбанкныхан үзэж байна. Учир нь, Хөгжлийн банкны ТУЗ-ын дарга уг бондын хүүг бүр 3.5-3.7 хувьтай гаргахыг санал болгож байгаа нь АНУ-ын Засгийн газрын бондоос ч хямд шахуу гэнэ. Гэтэл

инфляцийн өсөлт нь хоёр оронтой тоотой, бараг 10 хувийн төсвийн алдагдалтай манай улсын эдийн засагт жилийн зургаан хувийн хүүтэй бонд арилжина гэдэг маш өндөр эрсдэлийг агуулж буйг тэд нуухгүй байна.

Арилжааны банкныхны хувьд өөрийгөө хүндэлдэг банкир л лав дээрх 800 тэрбумын бондыг авах нь битгий хэл, нэг нүдээрээ ч харахгүй нь тодорхой.

Орон сууцны бонд гаргаж,

иргэдээ хямд өртөгтэй байраар хангах гэж байгаа төрийн бодлого буруу биш. Хамгийн гол нь бондын хүү бодит зах зээлийнхээ жамаараа бол арилжааны банкны зээлийн хүүгийн хэмжээнд 15-20 хувьтай байх ёстой. Гэтэл Хөгжлийн банк зургаан хувийн хүүтэй мөргэйж санхүүжүүлээ гэхэд 10-15 хувийн зөрүүг хэн төлөх вэ гэдэг сонин. Тэнгэрээс мөнгөөр бороо орохгүй нь лав. ■

## Хөдөө аж ахуй

# Хөдөө аж ахуйн шинэ бодлого

## И.Отгонжаргал


Хурал цуглааны үеэр үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзаж байхад, “Монгол Улс дэлхий ертөнцөд байдаггүй тийм шинэ зүйлийг хийж, гарч ёстой. Бид чадна. Монголчуудад оюуны өндөр чадавхи байна, өргөн уудам газар нутаг байна, олон сая толгой мал байна. Малынхаа ноос, ноолуураар чанартай бүтээгдэхүүн хийх технологийг эзэмшиж чадсан. Чухам ямар брэнд бий болгох вэ гэдгийг хэлж мэдэхгүй нь. Энэ тал дээр төрийн цэцэн ухаан тун үгүйлэгдэж байна даа. Төр, засгийнхан маань зөвхөн уул уурхайн урвадаг мөнгөнд шунаад, оюун бодол, нүд, чихийг нь таглачихаад байна шүү дээ. Тэд уул уурхайн их мөнгөнөөс өөр юу ч харахыг, сонсохыг, сонирхохыг хүсэхгүй байна. Ямар чиг л гэсэн бидэнд дэлхийн брэнд болгож гаргаж ирэх ямар нэгэн зүйл байгаа. Харин газар тариалан уу, эсвэл ноос ноолуур байх уу гэдэг л байна” хэмээн санаашрангүй өгүүлэх нь бий. Голланд өвчин буюу уул уурхайн их мөнгө бусад салбарын өрсөлдөх чадварыг дарангуйлж, хиар цохих вий гэж болгоомжилсондоо нийгмийн



баялаг бүтээдэг давархынхан ийн нэгийг бодож байна. Тэгвэл Монгол Улс хөгжих үү?, эс хөгжих үү? гэсэн эгзэгтэй цаг үед Засгийн газар, улстөрчдөд ухаантай ажиллах шаардлага бий. Бодлого тодорхойлогчдын ухаан одоо л яруу тодоор харагдах болоод байна. Явал улсынхаа эдийн засгийг дэлхийд зартай Голланд өвчин тусгахгүй авч гарч болох вэ гэдэг дээр тэдний ухаан бодол төвлөрөх ёстой.

Урвадаг хөрөнгө, ухагдаж дуусдаг баялагтай уул уурхайгаас өөр баялаг Монгол Улсад цөөнгүй бий. Тэр дундаа үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийн олонх нь хөдөө аж ахуйн салбарыг онцлоод

байгаа нь учиртай. Эл салбарт үйлдвэрлэл, бизнес эрхлэхэд эрсдэл өндөртэй ч ноос, ноолуур, газар тариалан гээд нөхөн сэргээгдэх баялаг арвинтай. Тийм болохоор чих дэлхийлгэж, нүд бүлтийлгэсэн их мөнгө, үсрэнгүй хөгжил ярьж буй энэ үед хөдөө аж ахуйн шинэ бодлого хамгаас чухал. Нэг үгээр хэлбэл, эдийн засгаа эрүүл хөгжүүлэхэд хөдөө аж ахуйн салбарын бодлого тодорхойлогчдын мэргэн ухааны хувь нэмэр их юм. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, хүнсний хомсдол гээд сүүлийн үед дэлхийг түгшээж байгаа асуудлууд жижигхэн Монголд боломж олгохыг ч үгүйсгэхгүй. Нөгөө талаас энэ нь



Эх сурвалж: ХХААХҮЯ

Монголын хөдөө аж ахуйн бодлогыг чимбайруулахыг цаг үе шаардаж байгаа хэрэг. Тэгвэл манайд хөдөө аж ахуйн шинэ бодлого байна уу?

“Байгаа” гэдэг хариултыг ХХААХҮ-ийн дэд сайд Х.Золжаргалаас олж сонслоо. Ноолуурын үйлдвэрлэл, газар тариалангийн хөгжил гээд гарц хайж болох, найдлага тээсэн салбар эднийд бий. Дэд сайдын яриа ч энэ талаар өрнөсөн юм. Гэхдээ тэрбээр зөвхөн хөдөө аж ахуйн салбар яриагүй. “ХХААХҮЯ гэдэг утгаараа зөвхөн мал, газар тариалан биш хөнгөн үйлдвэр, хүнс, худалдаа, нийтийн ахуй үйлчилгээ хүртэл манай салбарт хамаарах учраас зөв бодлогоор, зөв зохион байгуулалттай хөдөлж чадвал энд хамгийн олон ажлын байр бий болох боломжтой. Нөгөө талаас гадагшаа явж туршлага судалсан төрийн хүмүүс уул уурхайгаас гадна уламжлалт аж ахуйгаа хөгжүүлэхэд ихээхэн хөрөнгө хаявал, Голланд өвчин тусахгүй байх юм байна гэсэн ганцхан дүгнэлттэй ирдэг учраас хөдөө аж ахуйн шинэ бодлого ч энэ чиглэлд явж байгаа” хэмээн товчхон тодорхойлсон.

Хөдөө аж ахуйн шинэ бодлогын талаар Дэд сайдаас олон сайхан мэдээлэл сонссон ч урьд өмнө нь төдийлэн ярьж байгаагүй нэгэн салбарын сонирхолтой мэдээллийг эхлээд хүргэмээр санагдлаа. Уул уурхайгаас их мөнгө орж ирэх, бэлэн мөнгө тараах, хувьцаа эзэмшигч болох энэ тэр бол монголчуудын хувьд нэг их найдаад суухаар зүйл биш бөгөөд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахгүй гэж учир мэдэх хүмүүс учирлах юм билээ. Хамгийн гол нь хүн бүр баталгаатай ажлын байртай байх нь чухал гэдэг. “Нэг их дээшээ гарч, туршлага хуримтлуулж хөгжиж байсан түүх

байхгүй оёдлын салбарыг өөд татах хэрэгтэй байна. Хонконг, Хятадын бизнесмэнүүд манайд ирж, монголчуудаар хувцас оёулж, АНУ руу гаргаж байсан түүх бий болохоос монголчууд өөрсдөө зөөлөн оёдлоор гадаад зах зээлд нэвтэрч байсан удаагүй. Гэхдээ манайхан чинь аливаа хувцсанд өөрийн үндэснийхээ загварыг шингээгээд загвар гаргахдаа гарамгай улс” хэмээн Золжаргал сайдын хэлсэн нь шинэлэг асуудлын учгийг хөндөх шиг.

### Англичууд “Made in mongolia” гэсэн шошготой хувцсаар гангарна

Монголын нэг жижигхэн үйлдвэр бөс даавуун материалаар хийсэн өдөр тутмын хувцасныхаа ачилтыг ирэх тавдугаар сард Англи руу хийхээр ажиллаж байгаа аж. Өдөр тутмын хувцас гэдэгт нь богино ханцуйтай цамц, унтлагын хувцас зэрэг орж байгаа юм байна. Хамгийн сонирхолтой нь тэд англичуудын захиалгын дагуу хувцас хийж байгаа юм. Англид ажиллаж байсан ах, дүү хоёр дизайнер залуу энэ санааг ажил хэрэг болгож, салбарын яамныхаа дэмжлэгийг авч чаджээ. Хоёрхон ажилтантай ч энэ үйлдвэрийн ажлын гараа сайн байж, бариа нь амжилттай байх юм бол Европын зах зээлд Монголын оёмол бүтээгдэхүүн гарах замыг нээгээд зогсохгүй дотооддоо ч иймэрхүү оёдлын жижиг үйлдвэр олноор бий болгох эхлэлийг тавих юм байна. Тийм болохоор ХХААХҮЯ-наас тэднийг зориуд бодлогоор дэмжиж байгаа аж.

Монголын оёмол бүтээгдэхүүн Европын зах зээлийн гуравхан хувийг эзлэхэд 150 сая паундын орлого олох боломжтой гэнэ.

Энд гэхдээ богино ханцуйтай цамц, унтлаганы хувцас мэтийн өдөр тутмын хувцасны төрлөөр оролцоно гэсэн. Манайхан энэ боломжит зах зээл рүү нэлээд орой дөтөлж байгаа бололтой. Тайланд, Непал, Вьетнам зэрэг Азийн жижиг орон хэдийнэ дээрх зах зээлийн 5-10 хувийг эзэлсэн байдаг аж. “Монголчууд гурван хувь гээд маш даруухан дуугарахад л бидэнд маш их боломж байгаа” гэж Золжаргал сайд онцолсон. Тэрбээр мөн “Хэрвээ энэ ажил амжилттай хэрэгжвэл ойрын 4-5 жилд оёдлын салбарт 2000 ажлын байр бий болох боломжтой” хэмээсэн. Монголчууд загвар дизайн гаргахдаа санаа зоволтгүй, харин Европын стандартад нийцсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд суралцах нь чухлыг дэд сайд санаа зовнин өгүүлж байсан. Хамгийн гол нь эхний ээлжинд монголчуудыг үнэлж захиалга өгсөн анличуудад тоогдох ёстой. Тийм болохоор Англид олон жил ажиллаж амьдрахдаа эх орондоо бизнесийн шинэ санаатай ирж, түүнийгээ ажил хэрэг болгож байгаа дээрх хоёр залууд амжилт хүсье.

### Махны экспортын хэмжээг 10 дахин нэмэгдүүлэх боломжтой

Дараагийн гарц монгол малын мах. Ирээдүйд Монгол Улсын хийх гол ажил бол уламжлалт аж ахуй руугаа илүү анхаарч, хөрөнгө хаяж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах явдал. Уламжлалт аж ахуй гэхээр мал аж ахуй, газар тариалан орно.

Монгол Улс мах экспортлогч орон болох боломжтой гэдгийг Золжаргал сайд тэмдэглэж байна. Гэхдээ Засгийн газар зөв бодлого явуулж, малчид, үйлдвэрлэгчидтэйгээ хамтран ажиллаж чадвал шүү дээ. Хэрвээ тэгэх юм бол манай улс жилдээ 100000 тонн мах экспортлох боломжтой гэсэн ХХААХҮЯ-ныхны тооцоо байна. Монгол Улс ийм их хэмжээний мах экспортолж байсан түүх байхгүй ч зөв зохион байгуулалтаар хийх гээд оролдвол бүтэхгүй зүйлгүй гэдгийг дэд сайд хэлсэн. Манай улс 1980-аад онд

► тухайн үеийн ЗХУ-д мал хөлөөр нь гаргаж байх үед нийт 45000 тонн мах экспортолж байсан нь хамгийн их экспорт гэж тэмдэглэгдсэн байдаг юм билээ. Тийм болохоор малаар баян Монголд өдгөө 100000 тоннын экспортын шинэ бодлого байж болох л зүйл. Албаныхан 100000 тонн гэдгийг зүгээр ч нэг гаргаж ирээгүй бололтой. Махны үйлдвэрлэлийн хувьд цаг агаар сайхнаараа байгаад байвал Монголын бог мал жилд дунджаар 5-6 сая толгойгоор өсөх боломжтой тооцоо байдаг. Гэхдээ бэлчээр, эколого бодсон ч малын тоог механикаар өсгөх нь манай бодлого биш юм. Богийн гулууз мах дунджаар 15 кг-ийн жинтэй гэж тооцоход таван сая толгой малаас жилд 75 сая тонн мах үйлдвэрлэнэ. Дээр нь үхрийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, адууг оролцуулахад 20000 тонн мах нэмэгдэх боломжтой гэж тооцжээ, салбарын яамныхан.

## Монголын эдэлбэр газрууд уул уурхайгаас дутахгүй баялаг

Уул уурхайгаас дутахгүй дараагийн том баялаг бол Монголын эдэлбэр газрууд .

Хэдийгээр дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор Монголд хуурайшилт, цөлжилт эрчимтэй явагдаж байгаа ч гэсэн манай улс өргөн уудам нутагтай учраас бидэнд хүнс их хэмжээгээр үйлдвэрлэх боломж бий. Дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй экспортлох боломж ч манайд их. Өөрөөр хэлбэл, хямрал боломж олгодог гэдэг утгаараа дэлхийг түгшээсэн хүнсний хомсдолын аюул холын Монголд боломж бэлэглэж байгаа нь энэ гэж эрт баярлаж болох. Энэтхэг, Хятадын эдийн засагт сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөлт явагдаж, хүн амынх нь амьжиргааны түвшин сайжирсантай холбоотойгоор хүнсний хэрэглээ нэмэгдсээр байгаа нь ажиглагдаж буй. Дээр нь ган гачиг, хар салхи, газар хөдлөлт гээд байгалийн гамшгийн давтамж ойртож байгаатай холбоотойгоор хүнсний хангамж дэлхийг түгшээсэн асуудал болон босч ирж байгаа билээ. Энэ нь манай улсыг мах, улаан буудай зэрэг хүнс

экспортлогч орон болоход тус дэм болох талтай.

Хөрсөө ухахаас илүү үр дүнтэй дараагийн хөрөнгө хаяж, хөгжүүлэх үйлдвэрлэл мэдээж улаан буудайн тариалалт. Социализмын үед Монгол орон нийт 1.2 сая га тариалангийн эргэлтийн талбайтай байсан. Харин өдгөө 650 мянга орчим га талбайг газар тариаланд ашиглаж буй. “Атрын III” аяны хүрээнд атаршсан талбайгаа тодорхой хэмжээгээр эргүүлэн ашигласан. Дээрх хэмжээний талбайд тариалалт эрхэлж төмс, улаан буудайн дотоодын хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны 60 орчим хувийг хангаж байгаа. Атаршиж үлдсэн талбайгаа бүрэн сэргээж ашиглаагүй байгаа учраас цаашид тариалалтын талбайгаа нэмэгдүүлж, улаан буудай, төмс, хүнснийногооныхоо үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээс гадна хорвоо ертөнцөд огт байдаггүй шинэ таримал гаргаж ирнэ гэж романтик зорилго өвөртөлж яагаад болохгүй гэж. “Санаж явбал бүтнэ, сажилж явбал хүрнэ” гэдэг ардын үг байдаг даа. Ингэхийн тулд усалгаатай тариалан, өндөр технологи гээд багагүй хөрөнгө хүч шаардсан ажил хийх учиртай.

Газар тариалан мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх бодлогыг хөдөө аж ахуйн шинэ бодлогоор нэрлэсэн. Энэ нь гэхдээ бараг зах зээл эхэлснээс хойш яригдсан асуудал учраас хуучирсан пянз шиг сонсогдож байж магадгүй юм. Гэхдээ Монгол Улс өргөн уудам газар нутагтай, 40 гаруй сая толгой малтай учраас том зорилго тавьж, шинэ бодлого боловсруулахад зүй ёсоор тавигдах ёстой л асуудал.

## “Бээлий” хөтөлбөр ба 2000 ажлын байр

Хөнгөн үйлдвэрийн салбар өрсөлдөх чадвартай гэдгээ эгзэгтэй үед харуулах шаардлага бий. Энэ салбарын шинэ бодлогыг ХХААХҮЯ-ныхан харжээ.

“Малын гаралтай бүх бүтээгдэхүүнийг аль болох эцсийн боловсруулалт хийж, экспортод гаргах нь хамгийн чухал байгаа юм. Энэ чиглэлээр манай яам олон мэргэжлийн холбоотой хамтарч ажиллаж байгаа. Тэдний зүгээс сайхан санал санаачилга гарч

байгаа нь бас их олзуурхуштай байна” гэдгийг Золжаргал сайд дуулгасан. Тухайлбал, Монголын арьс, шир үйлдвэрлэгчдийн холбооныхон “Бээлий” хөтөлбөр хэрэгжүүлэх сайхан санал тавьжээ. Тэд арьсан бээлий хийж, экспортлох бодол өвөртөлжээ. Ажлын бээлий гэхэд манайд урд хөршөөс ямар их хэмжээгээр орж ирж, өргөн хэрэглэж байгаа билээ дээ. Ноосон утсаар нэхсэн импортын ажлын бээлийний чанар тийм ч сайн биш. Тэгвэл монгол малын арьс ширээр нэг их гоё ганган дэгжин гэхээсээ илүүтэй бөх бат чанарыг нь чухалчилж энгийн хэрнээ эдэлгээтэй бүтээгдэхүүн хийвэл хойд хөрш рүү экспортолж болох гэнэ. Манай сэтгүүлийн хоёр дахь дугаарын “Шинэ санаа ба бизнес” булангийн зочноор орсон “Энхжин сувенир” компанийн захирал эмэгтэй манай арьсан эдлэл хийцийн хувьд больхи ч эдэлгээ сайтай, чанартай гэдэг үзүүлэлтээрээ хоёр хөршдөө нэр хүнд нь маш сайн яваа” гэж сонирхуулж байсныг энд тэмдэглэе. “Бээлий” хөтөлбөр хэрэгжсэнээр 2000 ажлын байр бий болгох боломжтой гэж Арьс, шир үйлдвэрлэгчдийн холбооныхон салбарынхаа яамны удирдлагуудад танилцуулсан байна.

## Ноолуур үйлдвэрлэгчдийг 100 тэрбумаар дэмжинэ

Цагаан алт гэгддэг ноолуурын үйлдвэрлэл Монголын нөхөн сэргээгдэх чухал баялаг мөнөөсөө мөн. Чанартай түүхий эд, өндөр технологи нь бидэнд бий учраас ирээдүйн хөгжил нь сайн явахыг илтгэнэ. Тийм ч учраас “Монгол ноолуураар дэлхийг гоёно” гэсэн том уриа итгэлтэй дэвшүүлсэн үйлдвэр ч бий. Гагцхүү манай үндэсний томоохон ноолуурын үйлдвэрүүд эргэлтийн хөрөнгө муутайгаас түүхий эдээ хятадуудад алддаг талтай. Үүнийг төр, засгаас анхаарч шийдэх аваас Монголын ноолуурын үйлдвэр хөгжих нь дамжиггүй. Олон жил яригдсан дээрх асуудлыг энэ жилээс шийдэхээр Засгийн газар чармайж байгаад талархая. Засгийн дэмжлэгийг авахын тулд “Монгол ноолуур нэгдэл” гэдэг компани шинээр байгуулагдаж

» байгаа аж. Засгийн газраас ноолуур үйлдвэрлэгчдэдээ буюу “Монгол ноолуур нэгдлийг” дэмжиж 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдэж өгөхөөр болжээ. Энэ мөнгөөр ноолуур үйлдвэрлэгчид юу хийх вэ? Эхний ээлжинд 2000 тонн түүхий эд худалдан авч, эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлд ажиллана. Дээрх мөнгө 14 үйлдвэрт хуваарилагдах бололтой. 2000 тонн ноолуур авахад, 900 орчим тонн самнасан ноолуур болох аж. Нэг цамц 300 граммын жинтэй гэсэн мэргэжилтнүүдийн тооцоог үндэслээд тооцоог цаашаа үргэлжлүүлбэл чамлахааргүй хэмжээний сүлжмэл бүтээгдэхүүн болж, экспортлогдоно гэсэн үг. Ноолуурын үйлдвэрийнхэн энэ хүрээнд 1800 ажлын байр шинээр бий болгоно гэж үзэж буй.

Голланд өвчнөөс Монголыг хамгаалж болох хөдөө аж ахуйн салбарын баялаг буюу экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл дуусаагүй байна.

Хөдөө аж ахуйтай холбоотой нэг том бодлого ложистикийн асуудал. Манайд ложистикийн

төрийн нэгдсэн бодлого ч гараагүй байгаа. Ченжүүд гэдэг нэртэй бэлтгэн нийлүүлэгчид өнөөгийн манай ложистикийн үүргийг гүцэтгэж байгааг Золжаргал дэд сайд нуугаагүй. Монгол өргөн уудам нутагтай, зам тээвэр сайн хөгжөөгүй учраас бараа бүтээгдэхүүний үнэ, үйлчилгээнд тээврийн зардал том дарамт учруулдаг. УИХ-д өргөн барьсан Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн тухай хууль ложистикийн шинэ тогтолцоог бий болгох ач холбогдолтой гэнэ.

Түүнчлэн “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” баримт бичигт малчдад төрөөс үзүүлэх үйлчилгээг малдаа биш, хүндээ нэлээд чиглүүлж өгчээ. Хамгийн гол зорилго нь дов жалгын нэг хувиа борлуулах малчдыг биш, ажил хөдөлмөрөө хоршиж, хоршоо хэлбэрт шилжсэн малчин өрхүүдийг илүү дэмжих бодлого явуулах аж. За тэгээд малчдыг эдийн засаг, бизнесийн ухаанд суралцуулах, бүх малаа бүртгэлжүүлж, эрүүлжүүлэхэд “Монгол мал” хөтөлбөрийн ач холбогдол оршиж буй юм. ■

Ямар гоё байсныг үгээр илэрхийлж ч чадахгүй нь.

“Архигүй Монголын төлөө” үндэсний сүлжээ бий болж, Хууль зүй, дотоод хэргийн яамныхан “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн төслийг шинэчлэн найруулж байгаа зэрэг сайхан мэдээ ойрын үед дуулдах боллоо. Монголын оюутнууд ч архины эсрэг “Нэгдэх үү” хэмээн уриалсан нь хэчнээн сайхан хэрэг билээ? Гэтэл Монгол орон архиар бялхаж, бялуурч байгааг гаргасан статистик мэдээллүүд зүрх зүсэх шиг болов.

Өнгөрсөн онд Монголд үйлдвэрлэсэн архины хэмжээ жилийн өмнөхөөсөө 42 хувиар нэмэгдэж, 136.6 мянган тоннд хүрчээ. Гэтэл үйлдвэрлэсэн сүүний хэмжээ үүнээс найм дахин бага буюу ердөө 17.4 мянган тонн байгаа юу гэж ойлгох вэ? Түүнчлэн сүүлийн жилүүдэд Монголын нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэмжээ тогтмол өсч ирснийг Үндэсний статистикийн хорооны судалгаа харуулна. Иймэрхүү тоо баримтыг хараад архи, тамхи үйлдвэрлэгчид л алгаа ташин суугаа биз ээ. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас гаргадаг ТОП 100 компанийн жагсаалтад ч архи, тамхины үйлдвэрүүд толгой цохиж байх жишээтэй. Арга ч үгүй юм даа, “согтуу Монгол” оронд тэд л хамгийн ихээр ашиг олж байгаа байлгүй.

Энд тэндгүй архины эсрэг аян зарлаж, “Идээний дээж бол сүү” хэмээн сурталчилж эхэлсэн нь сайн л хэрэг. Манай сэтгүүл ч энэ аянд нэгдэж, дээрх уриалгыг уухайлан дэмжиж байна. Гэхдээ согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдааг хууль эрх зүй болон эдийн засгийн аргаар хатуу зохицуулах хэрэгтэй болсныг дээрх статистик харуулна биз ээ. Товчхондоо, архины зах зээлд төр “төмөр нударга” үзүүлэх цаг иржээ. ■

Mongolian Economy сэтгүүл сүүн санаачилгыг дэмжиж байна

# Идээний дээж сүү юү, архи уу?

“Идээний дээж бол архи” гээд ямар чөтгөр нь хэзээ хэлчихсэн юм бүү мэд. Хундага өргөчихөөд ёроолыг нь харах ёс яаж байгаад тогтчихсоныг ч бас мэдэхгүй. “Аз жаргал нь ёроолдоо байдаг юм” ч гэх шиг... Нанчид зооглоод насны жаргал эдэлсэн хүнийг би лав үзээгүй. Сархад хүртээд сайн яваа хүний жишээ энэ байна гээд Та хэлчихэх чадах уу?

Хуучин оноо үдэж, шинэ оноо угтах мөчид Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хундагандаа архи биш, сүү хийж байгаад ард түмэндээ хандан үг хэлсэндээ. Энэхүү Төрийн тэргүүний шинэ жилийн сайхан өрөөлөөс хойш “Идээний дээж бол сүү” гэх ойлголт нийгэмд бага ч гэсэн хоногшсон болов уу. “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон анхны дугаараа гаргачихаад, хундаганд сүү хийж тулгасан юм.



http://www.mongolianeconomy.mn

## “Чөлөөт худалдааны боломжит зах зээлийг нээх хэрэгтэй”

*Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал С.Жавхланбаатартай ярилцлаа.*

**-Уул уурхайн томоохон төслүүд эхэлж байгаатай холбоотойгоор үнэтэй тоног төхөөрөмж ихээр орж ирэх боллоо. Энэ нь гадаад худалдааны алдагдал нэмэгдэхэд нөлөөлж байх шиг?**

-Мэдээж эрдэс баялгийн салбар хөгжиж байгаа учраас хүнд машин механизм, үнэтэй тоног төхөөрөмж, ашигт малтмал боловсруулах зориулалт бүхий химийн бүтээгдэхүүний импорт нэмэгдэж байна. Үүнээс үүдэн гадаад худалдааны алдагдал ихэсч байгаа нь ч үнэн. Гэхдээ бид алдагдал гэхээсээ илүү үүний үр дүнд үйлдвэрлэл хэр их нэмэгдэж байгааг харах ёстой болов уу. Учир нь, тоног төхөөрөмж оруулж ирснээр өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн шиг нэг удаа хэрэглээд устаад алга болохгүй, харин үйлдвэрлэлийг сэргээж, ажлын байр бий болгож, эдийн засагт эергээр нөлөөлдөг юм.

**-Экспортыг аваад үзэхээр эрдэс баялгийн бүтээгдэхүүн 70 гаруй хувийг нь эзэлж байна. Уул уурхайн бус салбараа дэмжиж, экспортын бараа бүтээгдэхүүний төрлийг олшруулах тал дээр ямар бодлого байгаа вэ?**

-Экспорт нэг салбараас, мөн нэг улсаас түлхүү хамааралтай байгаа нь үнэн. Зөвхөн нүүрс л гэхэд экспортын 30 хувьд хүрч байх жишээтэй. Тиймээс уул уурхайн бүтээгдэхүүнээ боловсруулж, нэмүү өртөг шингээх бодлого явж байгаа. Ингэснээр эрдэс баялгийн бүтээгдэхүүн олширч, төрөлжих юм.

Бусад салбараа дэмжих тал дээр бол дотоодын үйлдвэрлэлээ байгаа нөөц бололцоогоо түшиглэн хөгжүүлэх ёстой. Мэдээж мал аж ахуй, газар тариалангийн салбар хамгийн түрүүнд орж ирнэ. Тухайлбал манай ноолуур дэлхийн брэнд болоход ойрхон байна. Тэгвэл дэлхийн зах зээлд монгол ноолуурын худалдан авагчдыг буюу зах зээлийг нь тэлэх, тогтвортой болгох ёстой. Үүний тулд өндөр чанартай, өрсөлдөх чадвар сайтай үндэсний имиж, брэндийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь зүйтэй байгаа юм. Өөр нэг жишээ татахад Австралийн үхрийн мах дэлхийн брэнд болчихсон байна шүү дээ. Тиймээс монгол малын махыг хэрхэн тэр түвшинд хүргэж болох вэ гэдэг тал дээр төрийн бодлого төвлөрөх ёстой. Мөн аливаа үйлдвэрлэлийн нэмүү өртгийг бий болгоход чухал орцын нэг нь мэдээж мэргэжлийн боловсон хүчний асуудал. Энэ бүхнийг



цогцоор нь шийдэхийн тулд бид Экспортын үндэсний хөтөлбөрийг энэ жилдээ багтаан боловсруулах төлөвлөгөөтэй байгаа.

**-Уул уурхайн бус үйлдвэрлэлийг дэмжих, экспорт хийхэд нь туслах зорилгоор төр, засаг ямар нэгэн татварын хөнгөлөлт үзүүлдэг үү?**

-Экспортын татварыг манай улс одоогоор тодорхой 4-5 тооны түүхий эдээс бусад бараа, бүтээгдэхүүнд огт ногдуулахгүй байгаа шүү дээ. Харин гаалийн импортын татварын хувьд манайх бүс нутагтаа хамгийн бага нь. Тусгай зөвшөөрөл бүхий эм тариа, архи тамхи зэргээс бусад нь тавхан хувийн татвартай. Түүнчлэн жижиг дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж оруулж ирэхэд хөнгөлөлт үзүүлж байгаа. Өөрөөр хэлбэл, Монголын татвараас болоод үйлдвэрлэл явуулж чадахгүй байна, экспорт хийж болохгүй байна гэсэн ойлголт байх учиргүй. Харин дотоодын зах зээлийн хөгжлийн түвшинд л асуудал байгаа болов уу. Манай санхүүгийн тогтолцоо ямар байна вэ, гаалийн үйл ажиллагаа хэр хурдан байна вэ, ачаа барааг нэг хотоос нөгөө хотод хүргэхэд хүндрэлтэй байна уу гээд л... Иймэрхүү татварын бус шалтгаан маш олон байгаа. Үүнийг арилгах чиглэлээр л холбогдох байгууллага, яам тамгын газрууд ажиллах ёстой.

**-Гадаад худалдаа хоёр хөршөөс, тэр дундаа Хятадаас хэт хамааралтай байгаа нь түгшүүртэй бус уу?**

-Импортын хувьд хоёр хөрш маань тус бүр 30 орчим хувийг эзэлж байна. Баланс барьж байгаа гэсэн үг. Бид хоёр том зах зээлийн хооронд хавчуулагдсан далайд гарцгүй улс учраас энэ нь хэвийн үзэгдэл л дээ. Харин экспортыг аваад үзэхэд 84 хувь нь Хятад руу гарч байгаа. Мэдээж манай уул уурхайн бүтээгдэхүүний гол худалдан авагч бол урд хөрш. Энэ том зах зээлийг бид ашиглах ёстой. Нөгөө талаас бусад улсад гаргаж буй экспортыг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл шинэ зах зээл нээхэд анхаарч ажиллах хэрэгтэй байгаа юм. ▶

» **-Дэлхийн худалдааны салбарт эзлэх байр сууриа бид яаж нэмэгдүүлэх вэ?**

-Энэ тал дээр боломж их байна. Байгалийн баялаг ихтэй учир Монгол Улс хөгжингүй орнуудын анхаарлыг татаж байгаа. Бид арвин нөөцтэй учир ямар ч салбарын үйлдвэрлэлд өөрсдөө нэмүү өртөг шингээгээд оролцох боломжтой гэсэн үг. Энэ хүрээнд Монгол Улс үйлдвэрлэлийн "Value chain" буюу нэмүү өртгийн гинжин хэлхээнд хамрагдаж байж дэлхийн зах зээлд өөрийн байр суурийг нэмэгдүүлнэ. Электрон барааг аваад үзэхэд л зарим эд ангийг нь Японд үйлдвэрлээд, Хятадад угсраад, Европын орнуудад нийлүүлэх жишээтэй. Иймэрхүү сүлжээнд бид ямар нэгэн эд ангийг нь үйлдвэрлэх ч юм уу, эсвэл түүхий эдийг нь боловсруулж хангах маягаар орохыг зорих хэрэгтэй.

**-Монголд худалдааны алба үүсч хөгжсөний 90 жилийн ой энэ онд тохиож байна. Энэ салбарын ирээдүй ямаршуу харагдаж байгаа вэ?**

-1990-ээд он хүртэл манай худалдаа цөөхөн улсаар хязгаарлагдмал байсан. Одоо харин бид дэлхийн 130 гаруй оронтой худалдаа хийж байна. Ер нь Монголын худалдааны салбар маш эрчимтэй хөгжиж байгааг зарим тоо ч харуулна. 2010 онд л гэхэд манай гадаад худалдааны нийт эргэлт 6.2 тэрбум ам.долларт хүрсэн байна. Бид ДНБ-тэйгээ дүйцэхүйж хэмжээний худалдаа хийчихсэн байна шүү дээ. Гэтэл 1990-ээд оны эхэнд энэ үзүүлэлт ердөө 200 гаруй сая ам.доллараар хэмжигдэж байсан. Одоо Монгол оронд бүтээн байгуулалт өрнөж байгаа тул худалдаа бүр ч их нэмэгдэх нь ойлгомжтой. 2013 онд гадаад худалдааны эргэлт 12 тэрбум ам.долларт хүрч, одоогийнхоос хоёр дахин нэмэгдэх таамаглал ч байна. Мөн тэр үед экспорт эрчимжиж, гадаад худалдааны тэнцэл ашигтай болох хандлагатай. Ер нь ирээдүй нэлээд

гэгээтэй байна гэж хэлж болно.

**-Гадаад худалдаа ингэж хурдацтай өргөжиж байгаа үед энэ талын бодлогодоо ч мөн өөрчлөлт хийх хэрэгтэй байх, тийм үү?**

-Бид гадаад, дотоод худалдааг хамарсан Худалдааны зохицуулалтын хуулийн төсөл боловсруулж байна. Өнөөдөр худалдааны салбарт бие даасан хууль ч алга байна шүү дээ. Гадаад худалдааны бодлогыг салбар болгон тус тусдаа гаргаж, хэрэгжүүлж байх жишээтэй. Үүнийг нэг бодлогоор зохицуулах хэрэгтэй болов уу. Ер нь худалдаа гэдэг бол эдийн засгийн гол хөдөлгөгч хүч юм. Дэлхийн худалдааны хэлэлцээр буюу ДОХА-гийн хэлэлцээр гацаанд орсон хэвээр. Гэтэл бүс бүсээрээ болон хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үзэгдэл идэвхжиж байх жишээтэй. Харин Монгол Улс өнөөдрийн байдлаар ДХБ-ыг эс тооцвол бүс нутгийн болон хоёр талын худалдааны хэлэлцээр хараахан байгуулаагүй л байна. Ийм л учраас гадаад худалдааны салбар дахь бодлогын механизмыг түргэн сайжруулах шаардлага байгаа юм.

**-Гэхдээ Японтой чөлөөт худалдааны хэлэлцээр хийнэ гэж ярьж байгаа. Энэ нь бидэнд ямар ашигтай юм бэ?**

-Японтой энэ төрлийн хэлэлцээр байгуулах судалгааг эхлүүлээд явж байгаа. Ер нь бид чөлөөт худалдааны боломжит зах зээлийг нээх ёстой. Нэг талаас тухайн улс манайд бараа бүтээгдэхүүнээ импортын татваргүй оруулах боловч нөгөө талаас бид шинэ зах зээл нээж, дотоодын үйлдвэрлэгч нарт боломж олгож чадна. Манай зах зээл жижиг боловч экспортод чиглэсэн үйлдвэрлэл явуулж, ашигтай ажиллах боломж бүрдэнэ. Ийм нөхцөл бий болоод ирэхээр хөрөнгө оруулалт ч нэмэгдэх юм. Тэгээд хөрөнгө оруулалтаар дамжаад дэвшилт технологи,

**Статистик**

2010 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 6177.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 53.5 хувиар өсчээ. Гадаад худалдааны алдагдал өмнөх оныхоосоо 50.1 хувиар нэмэгдэж, 378.7 сая ам.доллар болсон байна.

Нийт экспортын 84.4 хувь буюу 2448.2 ам.долларын бараа бүтээгдэхүүнийг Хятад улс руу гаргасан нь

өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 175.8 хувиар өссөн дүн юм. 2010 онд Монгол Улс зэсийн баяжмал, чулуун нүүрс болон цайрын баяжмалыг 100 хувь урд хөрш рүү экспортолжээ. Энэ хугацаанд тээврийн хэрэгслийн импортын үнийн дүн 150.1 хувиар, хүнд машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэгийнх 95.4 хувиар огцом өссөнийг хүснэгтээс харна уу.

Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллараар)

Нэр төрөл	2009	2010	Монгол дунгийн өөрчлөлт /хувиар/
1 Чулуун нүүрс	305.7	874.6	186.1% ↑
2 Зэсийн баяжмал	501.9	770.6	53.5% ↑
3 Төмрийн хүдэр ба баяжмал	88.8	250.9	182.7% ↑
4 Мөнгөжөөгүй алт	308.5	178.3	-42.2% ↓
5 Боловсруулаагүй нефть	115.6	154.9	34.0% ↑
6 Цайрын хүдэр ба баяжмал	122.5	134.1	9.5% ↑
7 Ямааны угаасан ноолуур	90.9	104.6	15.0% ↑
8 Ямааны самнасан ноолуур	68.4	68.8	0.7% ↑
9 Жонш, лейцит, нефелинт	48.2	63.2	31.0% ↑
10 Моллибдений хүдэр ба баяжмал	50.3	52.0	3.3% ↑
11 Бусад	184.5	247.1	33.9% ↑
<b>Нийт экспорт</b>	<b>1.885.4</b>	<b>2.899.2</b>	<b>53.8% ↑</b>

Чулуун нүүрсний зах зээлийн үнэ (сараар)





Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллараар)

Нэр төрөл	2009	2010	Мөнгөн дүнгийн өөрчлөлт /хувиар/
1 Нефтийн бүтээгдэхүүн	527.9	678.0	28.4% ↑
2 Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	279.5	546.2	95.4% ↑
3 Тээврийн хэрэгсэл	168.8	422.2	150.1% ↑
4 Хүнсний бүтээгдэхүүн	155.6	168.9	8.6% ↑
6 Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	82.7	114.2	38.1% ↑
7 Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	41.1	63.5	54.4% ↑
5 Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	60.4	22.8	-62.2% ↓
8 Төрөл бүрийн даавуу	1.5	1.7	14.7% ↑
9 Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	92.7	124.2	34.0% ↑
10 Бусад	727.4	1.136.2	56.2% ↑
<b>Нийт экспорт</b>	<b>2.137.7</b>	<b>3.277.9</b>	<b>53.3% ↑</b>

Эх сурвалж: Монголбанк

Гадаад худалдааны нийт эргэлт (сая ам.доллараар)



Хөгжлийн төв

# Далайд гарцгүй орнуудын төв Улаанбаатар хотноо нээгдэх нь

Манай улсад анх удаа “Ази, Номхон далайн далайд гарцгүй, хөгжиж буй орнуудын өндөр түвшний бодлогын уулзалт” болж өндөрлөлөө. Далайд гарцгүй ганцхан том асуудалтай орнуудын төлөөлөгчид хэрхэн хамтран ажиллах, бүх л улс орны нийтийн өмч усан цэнхэр далайд хэрхэн яаж гарцтай болох талаар уулзалдаж зөвлөлддөг уламжлалтай. НҮБ-аас байршлын хувьд эх газарт ордог ч далай бол бүх л улс орны өмч, хамтран харилцан ашигтай ашиглах утга бүхий шийдвэр гаргасан байдаг. Энэ л утгаар тус орнуудын албаны хүмүүс уулзаж, үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулах, өөрийн орны бүтээгдэхүүнийг далайд гаргах замаар зах зээлээс хэрхэн ашиг хүртэх, дамжин өнгөрөх тээврийн

асуудалд хэрхэн хандах талаар ярьж, санал бодлоо хуваалцдаг юм. Тус орнуудын хувьд гарцгүй учраас бусдын санал болгосон үнийг хүлээн зөвшөөрөхөд хүрэх жишээ цөөнгүй. Манай улс ч ялгаагүй зах зээлээс хэд дахин доогуур үнээр нүүрс, алт, зэс, төмрийн хүдэр, ноос ноолуур, түүхий эдээ экспортолдог билээ. Хоёрдугаарт, энэхүү уулзалтыг зохион байгуулах нь тухайн улсын нэр хүнд болоод эдийн засгийн талаасаа өндөр ач холбогдолтой хэмээн төлөөлөгчид дүгнэсэн юм. Зөвлөлдөх уулзалтыг Монгол Улсын нийслэлд хийх болсон гол шалтгаан нь манай орны байршил. Тиймээс ч Азийн төвд байрлалтай, хоёр их гүрний дунд орших давуу болон сул тал нь далайд гарцгүй орнуудын хөгжлийн төв болгох санааг бусад оронд

төрүүлсэн биз. Дээрх уулзалтаас гарсан Улаанбаатарын тунхаглалд далайд гарцгүй 10 орон нэгдлээ. Тунхаг бичгийг далайд гарцгүй бүхий л улс даган мөрдөх юм. НҮБ-ын “Мянганы төслийн илтгэл”-д тэмдэглэснээр далайд гарцгүй орнуудын эдийн засгийн жилийн өсөлт далайн эргийн орнуудынхаас даруй 0.7 хувиар доогуур үзүүлэлттэй гарчээ. Манай улсын импортын бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд гарах зардал 6.4 хувьтай байна. Харин дамжин өнгөрөгч орнуудын дундаж нь 6.3 хувь. Чех, Словак, Польш зэрэг Европын далайд гарцгүй оронтой харьцуулахад даруй хоёр дахин өндөр байгаа юм. Монгол Улс дэлхийн 100 гаруй улс оронтой худалдаа хийж байна. Нийт худалдааны эргэлтийн 40-»

» өөд хувийг БНХАУ, 20 гаруй хувийг ОХУ, 15 орчим хувийг Европын Холбооны улсуудтай хийж байгаа билээ. Сүүлийн жилүүдэд Япон, Солонгос улстай хийх худалдаа нэлээд жин дарах болжээ.

## Далайд гарцгүй орны зовлон ба гарц

Манай хилээр дамжин гарч буй бараа бүтээгдэхүүн БНХАУ, ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин гуравдагч зах зээлд хүрдэг. Хойд хөршийн зургаан боомт, Хятадын нэг боомтын гарцтай. Үүнээс гуравдагч улстай харилцах хамгийн дөт нь 1700-3800 км-ын зайтай Хятадын Тяньжин, Оросын Владивосток хотууд. Одоогоор Таван толгойн нүүрсийг Владивостокоор гаргахаар төлөвлөөд буй. Эхний нүүрсний цуваа ч аль хэдийнэ тус боомтыг зорьсон. Зүүн хойд Азийн цор ганц далайд гарцгүй орон нь Монгол Улс. Хоёр хөрш орны нутаг дэвсгэрээр өөр улсын бараа бүтээгдэхүүн дамжин тээвэрлэхэд нийт тээврийн зардлын гуравны хоёрыг зарцуулдаг гэсэн тооцоо бий. Манайх Хятад, Солонгос, ОХУ-тай транзит тээврийн гэрээ байгуулаад байна. Далайн хуулийн тухай НҮБ-ийн конвенцид “Далайд гарцгүй орнууд бусад улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх татвар төлөхгүйгээр далайд гарах эрхтэй” хэмээн тэмдэглэжээ. Өдгөө дэлхийд 43 далайд гарцгүй улс бий. Чех, Лаос, Молдав, Армен, Чад, Замби, Монгол гээд 43 улсын нэр үргэлжилнэ. 30 улс гэж заримдаа тэмдэглэсэн байдаг. Эдгээр улсын дунд хөгжлөөрөө ядуу буурайгаас гадна бүс нутагтаа тэргүүлэх ч улс орон бий.

## Монгол Алматын хөтөлбөрийг үргэлжлүүлнэ

Дээрх уулзалтыг Монгол Улсын Засгийн газар, НҮБ хамтран зохион байгуулсан юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, хатагтай Ноэлин Хэйзер уг уулзалтад оролцож, НҮБ-ын байр суурийг хүргэсэн. Тус уулзалтаар “2003



онд Алмат хотноо болсон далайд гарцгүй болон транзит орнуудын сайд нарын хурлаас гаргасан хөтөлбөрийн биелэлт”-ийг авч хэлэлцсэн. Энэхүү хөтөлбөрт транзит тээврийн бодлогыг сайжруулах, зам, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, далайд гарцгүй хөгжиж буй орнуудын гадаад худалдааг дэмжих, санхүү болон техникийн тусламж үзүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах таван асуудлыг чиглэлээ болгосон. Ази, Номхон далайн бүс нутагт ямар өөрчлөлт гарсан, учирч буй саад бэрхшээлийг хэрхэн даван туулах, хамтран ажиллах талаар ч зөвлөлдсөн байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд зөвлөлдөх уулзалтад оролцож үг хэлэхдээ “Далайд гарцгүй орнуудын тээвэр, дамжин өнгөрөх өндөр өртгийг зохицуулах үүднээс бодлогыг томъёолох, электрон худалдаа бий болгох, хоёр тал болон бүсийн гэрээ хэлэлцээр хийх, дамжин өнгөрөх тааламжтай, хөнгөлөлттэй нөхцөл бий болгох нь зүйтэй” хэмээн онцлохын зэрэгцээ Алматын хөтөлбөрийг үргэлжлүүлэх, Олон улсын далайд гарцгүй орнуудын судалгааны төвийн ажлыг жигдрүүлэхэд анхаарахаа ч мэдэгдсэн билээ. Далайд гарцгүй орнуудын хуурай боомтыг далайд гарцтай орнуудын усан боомттой зам, төмөр замаар холбох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаа хатагтай Ноэлин Хэйзер хэлж байлаа.

## Хөгжлийн төв хөгжих л үлдлээ

НҮБ-аас манай Улаанбаатар хотыг “Далайд гарцгүй орнуудын хөгжлийн төв” хэмээн албан ёсоор олон улсад удахгүй зарлах нь. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нийслэлд НҮБ-ын далайд гарцгүй орнуудын олон улсын байгууллагыг байгуулахаар болжээ. Олон Улсын байгууллага байгуулах гэрээг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүнд гардуулсан байна. Одоо гэрээнд гарын үсэг зурах л үлджээ. Стратегийн томоохон орд газрууд нь дэлхийн зах зээлийг зорьж буй энэ үед тээврийн асуудал хамгийн ээдрээтэй хэвээр. Хэдий Хятадын хүчирхэг зах зээлтэй хил залгаа оршиж байгаа боловч Япон, Солонгос гээд Монголд олон улсын чөлөөт зах зээл алсад байна. ОХУ-аар дамжин Европын зах зээлд гарч болох ч цаг хугацаа, тээврийн зардал гэх мэтчилэн хөрөнгө мөнгө, нөхцөл тавигдах нь мэдээж. Өнгөрөгч өдрүүдэд “Далайд гарцгүй орнуудын хөгжлийн төв”-д 10 орны 100 гаруй төлөөлөгчид ирж, дээрх асуудлыг шийдэхэд анхаарлаа хандуулж байлаа. Юутай ч хоёр өдрийн турш Улаанбаатарт чуулсан далайд гарцгүй орны төлөөлөгчид эдийн засгийн өөр нэгэн гарц олоод буцсан. Энэ гарц нь Улаанбаатар хот. Тиймээс хөгжлийн төв хөгжих л үлдлээ. ■



Ногоон эрчим хүч

## Усан цахилгаан станц хөгжил авчрах уу?

Д.Бэхээ

Ер нь монголчууд бид дэлхийн хөгжлийн чиг хандлагын эсрэг яваад яах вэ дээ. Дэлхий дахинаараа ногоон хөгжлийн төлөө, байгальд ээлтэй хөгжлийг сонгож, улс орон бүр төрийн бодлогоо энэ л хандлагад чиглүүлэн хурдтай ажиллаж байхад манайх шиг шинэ хөгжлийн ритмээс нэлээд хоцорч, мэлхийн хурдаар мөлхөж яваа улс ховор. Тэгээд гадаад дотоодгүй явж, юм үзэж, нүд тайлсан нэгэн нь “Та минь ээ хөгжил өөр тийш гэрлийн хурдаар явж байна, харин бид улам бүр хоцорчихгүйн тулд бодлогоо тэр зүг рүү чиглүүлэе” гэхээр ард иргэд уламжлагдан ирсэн ойлголтоосоо, улстөрчид нь амин хувийн ашиг хонжоо хайж улстөржсөнөөс болж, асуудлыг улам удаашруулж, хөгжлийг чангаагаад байгаад дүгнэлт хийх цаг иржээ.

Дэлхийд усны эрчим хүчний үйлдвэрлэлээр Канад улстэргүүлж, АНУ, Бразил, Хятад, ОХУ-ууд эхний таван байрт ордог. Харин Европ тивд тэргүүлдэг Норвеги улс 30000 орчим МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцуудтай бөгөөд нийт эрчим хүчнийхээ 99,5 хувийг усны эрчим хүчээр хангадаг байна. Тэгвэл Канад улс усан цахилгаан

станцуудаасаа 350 тэрбум кВтц цахилгаан гаргажаваад 50 тэрбумыг нь АНУ-д экспортлох замаар цэвэр хуримтлалыг үүсгэдэг аж.

Монгол Улсын хувьд усан цахилгаан станцыг хөгжүүлэх талаар өнгөрсөн жилүүдэд холбогдох төрийн байгууллага, мэргэжилтнүүд багагүй эсргүүцэлтэй тулж байж усны эрчим хүчний хөгжлийн үндэс суурийг тавьсан билээ. Усан цахилгаан станц гээч зүйлийг л баривал мөнөөх олон жилийн түүх домогтой гол мөрөн сүйдэж, иргэдийн хайрлан ирсэн нутаг орных нь гол мөрөн нь ширгэж, алга болох аюул нүүрлэнэ гэсэн олон жил бугшсан ерөөсгөл ойлголт цаашид улс орны хөгжлийн гарцад бүү саад болоосой билээ. Хэрвээ гадаадад ийм ойлголт байдаг бол дэлхийн ихэнх улс усан цахилгаан станцыг түлхүү хөгжүүлж, түүнээсээ ногоон эрчим хүч гарган авч ажиллаад хөгжиж, дэвшээд явах уу. Тэд чинь биднээс илүү эх орноо, байгаль дэлхийгээ бодитоор хайрлан хамгаалдаг хүмүүс шүү дээ. Усан цахилгаан станцын нэр хүнд унасан үе бий. Харин одоо эргээд сэргэж, улс орнууд төрийн бодлогоо усны эрчим хүчийг хөгжүүлэхийн

төлөө тууштай чиглүүлж эхэллээ. Яагаад гээч. Маш энгийнээр тайлбарлахад ердөө л дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой цэвэр экологийн эрчим хүчийг хөгжүүлэхийг л зорьсон хэрэг. Ялангуяа дулаарлын явц бусад орноос илүүтэй байгаа манай улс томоохон чадлын усан цахилгаан станц барьж байгуулах нь цаашдын эрчимтэй хөгжлийн гол хөшүүрэг, бас олон тулгамдсан асуудлын гарц болно гэж мэргэжилтнүүд ярьсаар байна. Уул уурхайн хөрөнгө оруулалтыг далласан хурдацтай хөгжлийн ирмэг дээр манай улсын өнөөгийн суурилагдсан эрчим хүчний нөөц ирээдүйн их хөгжлийн хурдыг гүйцэхээргүй байгаад эрчим хүчний салбарынхан санаа зовж, хэрвээ томоохон чадлын усан цахилгаан станц барьчихвал аваарын байдалд орших нөөц эх үүсвэрийн асуудал шийдэгдэнэ гэж яриад байгаа юм. Мөн төрийн түшээдийн толгойны өвчин болоод буй нийслэлийн утаа униарын асуудал ч шийдэгдэх тухайд тэд онцолсоор. Энэ л үүднээс хэдэн жилийн өмнө эрчим хүчний салбарынхан нийлээд Эгийн голын усан цахилгаан станцыг барихын ач холбогдлыг төрийн түшээдийн

Дэлхий дээр усны эрчим хүч, усан цахилгаан станцыг тогтвортой хөгжлийн тулгуур хэмээн хөгжүүлэн ашиглах болсон 10 шалтгаан

**Усан цахилгаан станц нь**

1. Сэргээгдэх эрчим хүч
2. Экологийн цэвэр эх үүсвэр,
3. Эдийн засаг, санхүүгийн хямрал, инфляцид өртдөггүй найдвэртэй эх үүсвэр,
4. Уян хатан байдал нь системийн ашигтай горимыг хангана,
5. Импортоор оргил ачаалал хаах чадлыг гадаадад түрээсээр хадгалах, цахилгааны импортыг оролж, валют хэмнэн гаднаас хамааралгүй болгоно,
6. 100-гаас дээш жил ашиглагдах тул тогтвортой байдлыг хангаж өгөх ба УЦС нь зөвхөн усны механик энергийг ашиглахаас бус түүнийг хорогдуулах үйл ажиллагаанд оролцдоггүй,
7. Усны үер, ган гачиг, гал түймрээс хамгаалан орчныг чийгшүүлж, цөлжилтөөс хамгаалдаг,
8. Уул уурхайн үйлдвэрлэлийг эрчим хүчээр урт хугацаанд үр ашигтай хангана,
9. Усалгаатай эрчимжсэн газар тариаланг хөгжүүлэн ургацыг хэд дахин өсгөж хүнсний хангамжийг сайжруулах болон хот суурингийн усан хангамжийн эх үүсвэрийг давхар шийдэх боломжийг нээдэг.
10. Үл үзэгдэх экспорт гэдэг экотуризмийг хөгжүүлэн нэмэлт орлого олох боломж агуулдаг.


тархинд суулгаж, олон Засгийн газрын нүүр үзсэн энэхүү төсөл арайхийн ажил хэрэг болохын даваа дээр мөнөөх л улстөржсөн шийдвэр гарч, тус салбарын мэргэжилтнүүдийн мөрөөдөл талаар болсон билээ. Үнэндээ бол томоохон чадлын усан цахилгаан станц барьж байгуулах нь эрчим хүчний салбарынхны мөрөөдөл юм. Тэр нам, энэ хүн энэ том станцыг барих үүд хаалгыг нээж, олон түмэнд нэр хүнд олж болохгүй, би л, эсвэл манай нам л хийж, улстөрийн нэр хүнд олж авч, УИХ-ын гишүүнээр сонгогдох ёстой гэсэн өчүүхэн хүсэлдээ хөтлөгдөн хөөрхий манай улстөрчид хөгжлийн төлөө бус өөрсдийнхөө төлөө шийдвэр гаргаж, нэг л өглөөний нарнаар хууль эрх зүйн орчноо, эсвэл өч төчнөөн зарлага гаргасан төслөө нураагаад л явдаг нь нууц биш. Чухам энэ л үүднээс Эгийн голын усан цахилгаан станцын төсөл нурсан юм. Тэгвэл Тайшир, Дөргөний станцууд мөн л багагүй эсэргүүцэлтэй тулгарч байж л босч, одоо ашиглалтад ороод баруун аймгуудын эрчим хүчний тодорхой хэсгийг хангаад олон айл өрхийг гэрэл гэгээтэй, өнөөгийн зуунд ядахдаа телевизээ үзээд суух хэмжээний болгож байгаа нь хөгжил бус уу. Одоо энэ хоёр станц нүүрсхүчлийн хийг бууруулсан, байгальд ээлтэй үйлдвэрлэл явуулсан үзүүлэлтээрээ Киотогийн

протоколын дагуу хүлэмжийн хийн олон улсын арилжаанд оролцож, тодорхой хэмжээний орлого олох боломжтой болоод байгаа. Өөрөөр хэлбэл, Манай Дөргөн, Тайширын УЦС Цэвэр хөгжлийн механизмд бүртгүүлэх өндөр шаардлага босгыг давж тэнцсэн Монголын анхны экологийн цэвэр сэргээгдэх эрчмийн хоёр эх үүсвэр бөгөөд жилдээ 60000 тн хүлэмжийн хийг бууруулах замаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж 500000 хүртэл ам. долларын нэмэлт орлого олох боломжтой болгоод байна. Энэ нь өөрөө хөгжил бус уу. Байгальд ээлтэй экологийн цэвэр үйлдвэрлэлийг дэлхий дэмжиж, мөнгө өгөх гэж байна шүү дээ. Уул уурхайгаас гадна сэргээгдэх эрчим хүчний нөөцөөр нэлээд баянд ордог Монгол Улс энэ салбараа хурдацтай хөгжүүлээд мөнгө олох боломж байгаа бус уу. Тухайлбал, манай орны усны эрчмийн нөөц 50 тэрбум кВт.ц-аар үнэлэгдсэн нь цаашдын өсөн нэмэгдэх цахилгааны хэрэгцээний тодорхой

хэсгийг усны эрчим хүчээр хангах бүрэн боломжтой аж.

Манай эрчим хүчний системийн оргил ачаалал 2010 оны арванхоёрдугаар сард 728МВт-д хүрэхэд дулааны цахилгаан станцууд бүрэн хүчин чадлаараа ажилласан хэрнээ оргил ачааллыг хаахаар хойд хөршөөс 70МВт эрчим хүч импортолсон билээ. Манай орны хэтийн хөгжлийн чиг хандлагаар 2020 оны түвшинд оргил ачаалал 1128МВт-д хүрэх төлөвтэй бөгөөд тэр үед импортоор 500 орчим МВт чадал авахаар байна. Ийм хэмжээний цахилгааны чадал жил бүр авахад хүрвэл улсын эдийн засаг доройтолд орохоос гадна шугамын дамжуулах чадвар ч хүрэлцэхгүй болох гэнэ.

Манай улс дулааны цахилгаан долоон станцтай бөгөөд жилдээ дөрвөн тэрбум кВтц эрчим хүчийг үйлдвэрлэж, харин оргил ачааллын цахилгааныг ОХУ-аас 40-өөд жилийн туршид импортлох замаар аргалж ажиллаж ирсэн. Өөрөөр хэлбэл, 40 жилийн турш ОХУ-аас хараат явж ирсэн гэсэн үг. Тэгвэл эдүгээ хөгжлийн шинэ үе ирж буйтай холбогдуулан эрчим хүчний салбартаа шинэчлэл хийж, томоохон чадлын усан цахилгаан станцыг барьж байгуулах замаар эрчим хүчний хараат бус байдлыг халж, нийслэлчүүдийн утаа униар, ирээдүйн эрчимтэй хөгжлийн хэрэгцээг бүрэн хангахуйцаар ногоон эдийн засгийг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Гамшгийн хэмжээнд хүрсэн нийслэлийн утааг арилгах талаар сүүлийн жилүүдэд багагүй ярьж, зарим нэг арга хэмжээг авч хэрэгжүүлжбайгааг Улаанбаатарын хотын утаа улам л ихсэх. Олон хүн санаа бодлоо уралдуулсаар л. Эрчим хүчний салбарынхан ч бас санаа оноогоо хэлж, асуудлаа тайлбарлаж эхэллээ. Тэд Эгийн гол, Сэлэнгэ мөрөн дээр каскад/цуваа/ усан цахилгаан станцууд



барьснаар оргил ачааллаас гадна нийслэлийн агаарын бохирдлыг арилгах бүрэн боломжтой талаар ярих боллоо. Төрийн түшээ Та нэг анхааралтай сонсоод бас судлаад үзээрэй. Яг өдгөө манайд эрчим хүчний, нөгөө нь утааны гэсэн хоёр том асуудлыг юун түүнд шийдэх хэрэгтэй байгаа шүү дээ. Цаашдын өсөн нэмэгдэх эрчим хүчний хэрэгцээг хангах хэмжээний эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг шийдэхгүйгээр, мөн утааг арилгах асуудлыг бодитоор ярихгүйгээр хөгжил яриад, уул уурхайн баялаг, их мөнгө мөрөөдөөд яах юм бэ. Тэгвэл утаа, эрчим хүчний найдвартай байдлыг хангах, дээрх хоёр асуудлыг нэгэн дор цогцоор шийдэх гарц бол

томоохон чадлын усан цахилгаан станц барьж байгуулах гэж эрчим хүчний мэргэжилтнүүд үзэж байна.

Манай орны усны эрчим хүчний нөөц 50 тэрбум кВт.ц. Дөргөн, Тайширын станцын үйлдвэрлэл нийлээд 75 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэх чадалтай байгаа нь монголчууд усны нийт эрчим хүчнийхээ 0.15 хувийг л эдийн засгийн эргэлтэд оруулж буй тухай ЭБЭХ-ний дэд сайд Т.Энхтайван яриад “Монгол Улс бараг хөндөгдөөгүй байгаа усны эрчим хүчний баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулснаар 100 жилийн хоцрогдлоосоо зургаан жилийн дотор гарах бүрэн боломжтой” гэжээ. ■

эгчдээ, ажлын хүндээ ч ургаж буй цэцэг бэлэглэснээр түүнд эрүүл мэнд, эрч хүч гээд олон зүйлийг давхар өгч байгаа” хэмээн “Увдист цэцэг төв”-ийн тэргүүн Б.Уранчимэг ярилаа. Нээрээ ч савтай цэцэг хуучрахгүй бэлэг юм.

МУИС-ийн Экологийн боловсрол төв, “Увдист цэцгийн төв”-ийнхөнтэй хамтран тасалгааны цэцгийг өөрийн хүлэмжиндээ үндэслүүлэн тарьж, хавар намрын улиралд үзэсгэлэн худалдаа зохион байгуулдаг уламжлалтай аж. Тэд 2011 оны хаврын үзэсгэлэнгээ дөрөвдүгээр сарын 16-наас 26-ны хооронд Экологийн боловсролын төвдөө зохион байгуулж байна. “Агаарын бохирдол хэцүүдлээ” гэж ярьж буй энэ үед Та гэртээ ч, ажилдаа ч тэр цэвэр агаараар амьсгалах аргууд бас бий. Тэдгээрийн нэг нь амьд цэцгэнд “умбах” явдал. Цэцгийн үнийн тухайд нас, өнгөнөөсөө шалтгаалаад өөр өөр. Дээрх үзэсгэлэнг сонирхогчдын дунд өндөр настнуудаас гадна нялх үрээ тэвэрсэн хүн ч цөөнгүй байсан. Эл үзэсгэлэнгийн цэцгүүд ерөнхийдөө 1500 -45000 төгрөгийн хооронд үнэтэй байв.

### Сурвалжлага

## Ургаж буй цэцгийг бэлгэнд сонгоё

Гоодаль, Унтаахай хатан, хамрын ханиад эмчлэгч Зузаахай, хүчилтөрөгчийн дээд “Мөлхөө”....Цэцгийн үзэсгэлэнг сонирхохдоо өнгө, үнэрт нь баясах төдий биш, тэрхүү амьд амьтны өөр өөрийн онцлогийг мэдрэхийг хүсвэл сонголт хийхэд

илүү хялбар болдог аж.

“Хэрвээ Та хэн нэгэн хайртай дотнын хүндээ савтай ургаж буй цэцэг бэлэглэвэл уулзах бүртээ найз чинь цэцгээ ярина байх. Цэцгээ хэрхэн арчлах, тордоход суралцаж, түүнээсээ байгаль дэлхийгээ хайрлаж сурна. Ах

### Агаар цэвэршүүлэх цэцэг борлуулалт сайтай байдаг

Үзэсгэлэнгийн шилдэг цэцэгчнээр Диваажингийн шувуухай цэцгийг дөрөв дэх жилдээ ургуулж буй Г.Даваадэлгэр шалгарсан юм. Стрелиция буюу Диваажингийн шувуухай цэцэг нь Монголд ховор тооцогдох цэцгийн нэг аж. Түүнийг цэцгийн хаан гэж нэрлэдэг байна. Шилдэг цэцэгчнээр шалгарсан Г.Даваадэлгэр “Цэцэг тарих нь чимхлүүр нарийн ажиллагаатай. Сэтгэл бүр ч чухал. Би 2007 оноос цэцэг тарьж эхэлсэн. Агаар цэвэршүүлэх цэцэг хамгийн борлуулалт сайтай байдаг. Тиймээс энэ төрлийн цэцгийг түлхүү тариалдаг. Гэрт тарьсан цэцэг маань багтахгүй болохоор цэцгэндээ зориулж 3х6 хэмжээтэй байшин барьсан. Сүүлийн жилүүдэд хүмүүс цэцэг сонирхох, худалдан авах нь эрс нэмэгдсэн. Цэцэг бүхэн өөр өөрийн эзэнтэй, түүхтэй. Тийм болохоор цэцэг сонгож авна гэдэг нарийн нандин



» зүйл ” гэв.

Агаар дахь нян бактерийг саармагжуулна, өрөө тасалгааны агаарыг ариутгана, дархлаа тогтооно, химийн элдэв элементийг өөртөө шингээнэ гээд цэцэгт муу тал алга бололтой. Соронзон туяаг саармагжуулах Сүлтгэнэ, дархлаа тогтоогч гэрийн эмч буюу Аруу гээд цэцэг бүр өөр өөрийн ач тустай. Дорно дахины ард түмэн цэцгийн соёлыг өрнөдөд дэлгэрүүлсэн түүхтэй юм билээ. Цэцэг үйлдвэрлэлтээрээ өнөөдөр Голланд улс дэлхийд тэргүүлж байна. Манай улсад энэ төрлийн цэцгийн үйлдвэрлэл одоо л хөгжиж буй гэж үздэг. Иргэдэд ахуйн хэмжээнд цэцэг тариалж, түүнийгээ худалдах болсныг эс тооцвол цэцгийн бизнест сул чөлөөтэй талбар байсаар. Цэцэггүй баяр, цэцэггүй тэмдэглэлт өдөр гэж үгүй. Байгаль орчинд ээлтэй цэцгийн худалдааг хориглосон хууль хаана ч байхгүй. Хэрэгцээ шаардлага нь байна. Эрэлт бий. Нийлүүлэлт нь дутмаг зах зээл гэвэл буруудахгүй болов уу. Юутай ч энэ салбар шинэ хэвээрээ байна.

### Экологийн боловсролыг цэцэг тарихаас эхлүүлэе

Өдөр бүр ургаж байдаг цэцгийг бие биендээ бэлэглэж байвал ямар вэ?, хүмүүс ээ. Үзэсгэлэнг зохион байгуулж буй Экологийн боловсрол төвийн гол зорилго энэ аж. Эднийх иргэдийн цэцэг тарих идэвхийг сэргээх, экологийн боловсролыг цэцэг тарихаас эхлүүлэх гэнэ. Тиймээс цэцэг тарих зөвлөгөө, сургалт, мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүйгээр явуулж иржээ. Ургаж буй цэцэгэнд элдэв янзын тууз, чамин боодол хэрэггүй. Зөвхөн бордоо, ус, нар илүү чухал болохыг онцолж байлаа. Цэцгийн дэлгүүрээс ихэнх хүмүүс “амьд” сарнай худалдан авах нь олонтаа. Харахад үзэмжтэй, сэтгэл татам хэдий ч усалгаатай, таримал цэцгийг үл гүйцнэ. Март-8, Есдүгээр сарын 1, хонхны баяр дөхөөд ирэхээр сарнай цэцгийн үнэ ханш есөх нь хууль. Өгч байгаа хүндээ үлдэж хоцрох нь даанч ховор. Дурсагдах нь үгүй.

Цэцэг сонирхдог хүмүүс санаа нэгдэж “Увидаст цэцэг төв”-ийг



байгуулжээ. Цэцэг сонирхдог, сонирхохыг хүссэн хэн бүхэнд 300-гаад гишүүнтэй энэ төвийн хаалга нээлттэй гэсэн. Тэдний зарим нь дэлгүүрийн лангуунаа борлуулалт нь гялтганадаг цэцгүүдийн талаар “Хэдий цэцэг боловч үндэс, мөчрөөсөө салсан төдий л зүйл” гэж ярьсан. Гэтэл гадуур худалдаалах сарнай сав боодол туузтайгаа үнэ нь хоршоод ирвэл тансаг агаад үнэтэй

бэлэг болдог. Гэхдээ амьдрах, аж төрөх биологийн нас нь хэдхэн цаг. Цэцэг тариалагчдын яриа хэдхэн цагийн настай сарнайнд мөнгөө үрэх биш, тэмдэглэлт өдрийн бэлгэнд ургаж буй тасалгааны цэцэг яагаад сонгож болохгүй гэж хэмээсэн сайхан санааг уламжлах байна. Таны маргаашийн бизнес ургадаг цэцэг байгаасай. ■



Фотоз INET

Цаг үе

# Тавантолгойн асуудал толгой эргүүлсээр...

## Хувьцаа эзэмшигчдийн орон

2011 оны гуравдугаар сарын 31. Энэ өдрөөс өмнө мэндэлсэн Монгол Улсын иргэн бүр Тавантолгойн нэгээхэн хэсгийг үнэ төлбөргүйгээр эзэмших эрхтэй боллоо. “Эрдэнэс Тавантолгой” компанийг байгуулан 15 тэрбум ширхэг хувьцаа гаргасны 10 хувийг ард түмэнд тараах түүхэн шийдвэрийг Засгийн газар гаргасан нь энэ.

Монголчууд бид хоёр сая 796 мянгуулаа. Монгол хүн бүр нэрийн данстай, дансандаа 536 ширхэг “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаатай болох нь. Төр засаг одоогоор хувьцааны тоог хэлсэн ч түүний нэрлэсэн үнийг зарлаагүй байна. Бас дээр нь “Эрдэнэс МГЛ” компанийн давуу эрхийн хувьцаа гаргаж, хүн бүрт нэг ширхэгийг бэлэглэх тухай Засгийн газар хэлэлцэж, дэмжээд байгаа билээ. Цаашдаа иймэрхүү сюрприз олон гарч мэдэхийг хэн байг гэх вэ, сонгуулийн өмнөх жил шүү дээ! Ингэхэд иргэн бүр нь “хувьцаа эзэмшигч” болсон Монголоос өөр орон байдаг болов уу?

“ОХУ, Саудын Араб болон бусад оронд хувьчлалын жишээ гарч

байсан л даа. Гэхдээ яг Монгол шиг бүх иргэндээ хувьцаа тараасан орныг би л хувьдаа мэдэхгүй юм байна” хэмээн “Евроази капитал” группийн захирал Алишер Али хариулав. “Ер нь иргэн бүртээ хувьцаа үнэгүй өгсөн туршлага бусад оронд байхгүй л болов уу. Гэхдээ энэ нь бэлэн мөнгө тарааснаас хамаагүй дээр гэж бодож байна. Хүмүүс хувьцаагаа барьцаалаад банкнаас зээл авч болно, ирээдүйд зарсан ч болно. Бас ногдол ашиг аваад, тэрийгээ боловсрол, эрүүл мэнддээ зарцуулах боломж бүрдэх байх” хэмээн Монголын Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг учирлаад, “Гол нь энэ хувьцааны бодит үнэ цэнийг иргэд сайн ойлгох хэрэгтэй” хэмээн онцлов.

Гэхдээ гурван монгол хүний нэг нь нэн ядуугийн ангилалд багтаж байгаа өнөө үед үнэгүй авсан хувьцаагаа хүмүүс хамгийн анхны боломжоор зарж, хоногийн хоолоо залгуулах магадал тун ч өндөр. “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд гаргаж, зах зээлийн үнэ цэнэ нь тогтох үед арилжаа нээлттэй болно гээд байгаа шүү дээ. “Арга зальтай

этгээдүүд худал, үнэн аргаар бүх хувьцааг цуглуулан авсаар, 10 жилийн дараа гэхэд иргэдийн ихэнх нь нөгөө л ядуу хэвээрээ, бүх баялгийг гартаа төвлөрүүлсэн цөөхөн этгээдийн зарц болох вий” гэж эдийн засагч Д.Жаргалсайхан бичжээ. Үнэхээр 1990-ээд онд төрийн өмчийг цэнхэр, ягаан тасалбар болгон үнэгүй тарааснаас болж эдүгээ Монголын хөрөнгийн бирж дэх компаниудын ихэнх нь нэгдмэл сонирхол бүхий хэсэг хүний гарт төвлөрсөн байдаг. Тэд мэдээлэл хомс, хөрөнгийн зах зээлийн талаар ойлголтгүй хүмүүсийг “мангартуулж”, хувьцааг нь хуулийн дагуу болон хууль бус аргаар дээрэмдсэн нь түүхэн сургамж. Манай хөрөнгийн зах зээл дэх эмх замбараагүй байдал ч үүнээс улбаатайг “Mongolian Economy” сэтгүүл өмнөх дугаартаа дэлгэрэнгүй бичсэн билээ.

“Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд сайн анхаарахгүй бол 1990-ээд оны цэнхэр, ягаан тасалбар шиг юм болж магадгүй” хэмээн Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан зовних. “Маш том сургалт явуулах учиртай. Алс хөдөө сууж байгаа малчин

» ч хөрөнгийн зах зээлийн тухай ойлгогчид байх ёстой шүү” хэмээн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж сануулах. Ямартай ч төр, засаг нэг бүдэрсэн газраа дахиж унахгүй гэж найдах л үлдлээ.

## Гараа амжилттай, харин бариа?

Монголын Засгийн газар түүхэндээ анх удаагаа олон улсын хөрөнгийн зах зээлээс их хэмжээний хөрөнгө татах гэж байна. Энэ гараа ч амжилттай эхлэв. Дэлхийд толгой цохих хөрөнгө оруулалтын 20 гаруй банкны төлөөлөгчид Улаанбаатарт цуглан, монголчуудтай хамтарч ажиллахын төлөө өөр хоорондоо өрсөлдсөн нь урд хожид үзэгдээгүй гайхамшигт явдал болсон гэлтэй. Хэдхэн жилийн өмнө хэний ч анхаарлыг татахгүй байсан манай орон ийнхүү уул уурхай, банк санхүүгийн “акул”-уудыг даллаж эхэллээ.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн IPO-г олон улсын хөрөнгийн зах зээлд хийх ажлыг зохион байгуулах эрхийг одоогоор дөрвөн банк аваад байгаа нь Германы “Deutsche bank”, АНУ-ын “Goldman Sachs”, Францын “BNP Paribas”, Австралийн “Macquarie” билээ. Эдүгээ тэд Тавантолгойд мөнгө босгож өгөх бэлтгэл ажилдаа хэдийнэ орсон тухай албаны эх сурвалж мэдээлэв. Гэвч “Эрдэнэс Тавантолгой” компанийн 10 хувийг монголчууд үнэгүй өмчилж байгаа нь олон улсын зах зээлээс хөрөнгө татахад сөрөг үр дагавар авчрах юм биш биз?

“Олон улсын IPO-д харин ч сайнаар нөлөөлөх болов уу. Энэ компанийн ард бүхэл бүтэн улсын ард түмэн байна гэхээр хөрөнгө оруулагчдын хувьд таатай байж болох юм. Улс төрийн тогтвортой байдалд ч чухал шүү дээ” хэмээн Ө.Ганзориг учирлав. Үнэхээр ч “Эрдэнэс Тавантолгой”-н хувь заяанаас нийт монгол үндэстний амьдрал, амьжиргаа шалтгаалах болоод буй.

Ямартай ч Наадмаас өмнө иргэдэд хувьцааг нь тараана, тэгээд энэ ондоо багтаан олон улсын хөрөнгийн зах зээлд IPO хийнэ хэмээн төр, засгийн эрхмүүд амлаж байна. Гэтэл ийм томоохон ажил хийхийн тулд наад зах нь хоёр жил

бэлтгэх хэрэгтэйг мэргэжилтнүүд онцолж буй. Одооны өрнөөд буй үйл явдлаас дүгнэлт хийхэд “Эрдэнэс Тавантолгой” компани нэлээд үнэ хүрэхээр байгааг Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугар учирлаад, “Дэлхийн зах зээлээс 2-4 тэрбум ам.доллар босгох хэлцэл маш их хүч шаардана шүү дээ” хэмээн онцлов. Яг хэдий хэмжээний мөнгө босгохоо ч тогтоогоогүй байж Засгийн газар яараад л байх юм.

Гэхдээ “Бушуутуулайборвиндоо баастай” гэдэг дээ. Олон улсын зах зээлд гарах компани өндөр шалгуур давж гарах ёстой байдгийг мэргэжилтнүүд сануулж байгаа юм. Техник, эдийн засгийн үндэслэлээ ч гүйцэд боловсруулаагүй, оператор компаниудаа ч сонгоогүй, дэд бүтцийн асуудлаа хэрхэн шийдвэрлэх нь ойлгомжгүй үед “Эрдэнэс Тавантолгой” маань олон улсын зах зээлд хувьцаа гаргана гэдэг үнэмшилгүй ажээ. Гаргалаа ч үнэд хүрэхгүй байж болохыг шинжээчид анхааруулсаар.

“Уурхай бүрэн ашиглалтад орж, тодорхой хэмжээний үр өгөөжийг өгдөг болсон цагт IPO хийх нь хамгийн сайн. Түргэн зуур мөнгөтэй болох гээд яаруу, сандруу зүтгэснээр хямд үнэлгээтэй, түүхий ажил болбол хоёр, гурван жилийн дараах хариуцлагыг хэн үүрэх вэ. Хамгийн үнэтэй өөрийн хөрөнгийг /equity/ хамгийн хямд үед нь маш их хэмжээгээр гадагшаа гаргаж байгааг гэмт хэрэг гэж үзэж байна” хэмээн УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Тавантолгой тойрсон тав, зургаан асуулт” нийтлэлдээ бичжээ.

## “Хагас толгой”, зургаан сонирхол

Тавантолгойн орд нь Цанхи, Ухаа худаг, Зүүн болон Бортолгой гэсэн хэсгээс бүрддэг. “Энержи ресурс” компани Ухаа худагийг буюу 4000 га газрын тусгай зөвшөөрлийг авсан байдаг бол орон нутгийн “Тавантолгой” компани нийт 270 га газар эзэмшиж буй. Харин “Эрдэнэс МГЛ”-ын мэдэлд 68 мянган га газар байгаа ажээ. Өөрийн мэдлийн энэхүү 68 мянган га “толгой”-гоо Засгийн газар хоёр ч хувааж, олон улсын уралдаант шалгаруулалт зарлаад байгааг бид мэднэ.

“Эрдэнэс Тавантолгой” компани

“бор зүрхээрээ” хариуцаж, борлуулалтаа өөрөө хийх Цанхийн зүүн хэсэгт захиалгаар олборлолт явуулахын тулд БНЭУ-ын “Mesco Steel”, ХБНГУ-ын “BBM Operta”, Австралийн “MasMahon” гэсэн гурван компани саналаа ирүүлсэн билээ. Эндхийн хөрсийг хуулж, олборлолт эхлэхэд бэлэн болсон тухай “Эрдэнэс МГЛ”-ын гүйцэтгэх захирал Б.Энэбиш мэдэгдсэн нь бий.

Харин Цанхийн баруун хэсэгт хөрөнгө оруулж, олборлолт хийн, борлуулалтаа хариуцах эрхийн төлөө таван тивийн 15 компани, консорциум өрсөлдсөн. Энэхүү тендерийн эхний ялагч нарыг Үнэлгээний хороонохон тодруулсан бөгөөд хоёрдугаар шатанд АНУ-ын “Peabody Energy”, БНХАУ-ын “Shenhua Energy” болон Японы “Mitsui & Co” компаниудын консорциум, “Оросын төмөр зам” болон Японы консорциум, БНСУ-ын “Корес” группээр ахлуулсан компаниудын нэгдэл, Австралийн “Xstrata coal”, Бразилийн “Vale”, Люксембургийн “ArcelorMittal” тунаж үлдээд байгаа. Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж буй Ажлын хэсгийн эрхмүүдийн тэдэнтэй хийх хэлэлцээр үргэлжилсээр.

Угтуулан тавих нөхцөл бол Тавантолгойн гол “хагас толгой” болох Цанхийн баруун хэсгийн олон улсын тендерийг дүгнэх чухал шалгуур юм. Нүүрс тээвэрлэх төмөр зам, транзит тээврийн үнэ, боомтын шийдэл, шилдэг технологи, боловсруулах үйлдвэрлэлийн туршлага зэргээр нь дээр зургаан компанийг эрэмбэлнэ гэсэн үг. Бас дээр нь урьдчилгаа төлбөрөө ярих нь гарцаагүй. Уг тендерийн ялагчаар аль нэг консорциум, эсвэл консорциумуудын нэгдэл болсон хэдэн ч оролцогч тодорч мэдэх аж. Гэвч энд бид нэг зүйлийг сайн ойлгох хэрэгтэй болов уу. Хэлэлцээр зөвхөн монголчуудын талд ашигтай болно гэж хүлээж суух нь өрөөсгөл ойлголт юм. Нэгэнт л хөрөнгө мөнгөө зарцуулж, Тавантолгойн нүүрсийг олборлохын тулд өрсөлдөж буй зургаан компани, консорциум тус бүрдээ өөрийн сонирхол, ашиг хонжоог хайх нь ойлгомжтой. Харин Монголын Засгийн газрыг, энэ орны нийт ард түмнийг төлөөлөн хэлэлцээрийн ширээний ард сууж буй эрхмүүд л

► алсын хараатай байж, аль болох ухаалаг шийдвэр гаргаасай гэж залбирнам.

“Засгийн газар хөрөнгө оруулагчийг сонгохдоо зөвхөн урьдчилгаа төлбөрт хэтэрхий хөтлөгдөх вий. Урьдчилгаа мөнгө авна гэдэг бол нэг л асуудал. Цаана нь дэд бүтэц, нөгөө угтуулан тавих нөхцөл гээд том асуудлууд байгаа шүү” хэмээн Ерөнхийлөгч сануулсан юм. Ямартай ч олон улсын хөрөнгийн зах зээлд IPO хийхээс өмнө Цанхийн баруун хэсгийн бүх асуудлыг шийднэ гэж албаны хүмүүс ярьж байна.

### Лааны гэрэлд нүүрсээ ухаад, Явган зөөх үү

Тавантолгойн нүүрсийг юу юугүй олборлож эхлэх тухай Б.Энэбиш онцолж буй хэрнээ түүнийгээ яаж олборлох, хаагуур тээвэрлэх, хэрхэн борлуулах асуудал дээр таг чиг. Наад зах нь эрчим хүчний асуудлаа хэрхэн шийдвэрлэх гээд байгаа нь ойлгомжгүй. “Эрдэнэс МГЛ” компани “Оюу Толгой”-той хамтарч цахилгаан станц барих гээд байгаа ч юм шиг, эсвэл Тавантолгойг төвийн эрчим хүчний системд холбох гээд байгаа ч юм шиг... “Тавантолгойн усны нөөц хангалтгүй гээд байгаа. Энэ үед нэмээд цахилгаан станц барих нь зөв үү, үгүй юу гэдгээ бид яриад л явж байна” хэмээн Б.Энэбиш

тайлбарлажээ.

Төрийн өмчийн хороо Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэлийн 435 км авто зам “барих, ашиглах, шилжүүлэх” төрлийн концесс олгох уралдаант шалгаруулалт зарласан байгаагийн ялагч хэзээ тодорч, зам нь хэзээ бэлэн болох юм, бүү мэд. Түүнчлэн Тавантолгойн нүүрсийг Сайншандад хүргэж, улмаар Чойбалсанг чиглээд суналзах 1100 км төмөр замын барилгын ажил яг хэзээ эхлэх, улмаар хэзээ ашиглалтад орох нь ойлгомжгүй. Товчхондоо, дэд бүтцийн тал дээр тодорхой зүйл огтхон ч алга. Тэгээд лааны гэрэлд нүүрсээ ухаад явган зөөх болж байна уу?

Ер нь Тавантолгойг эдийн засгийн эргэлтэд оруулах үүрэг аваад гурав дахь жилтэйгээ золгож буй Засгийн газар одоо хүртэл барим тавим төлөвлөгөө ч боловсруулаагүй явж байгаа нь хачирхалтай. Энэ хугацаанд зохион байгуулсан уулзалт, зөвлөлгөөн, хэлэлцээр ч тоогоо алдсан. Гэтэл үр дүн нь хаа байна вэ? Тавантолгойн хэлэцээр одоо ч үргэлжилсээр, харин мэдээлэл нь хав дарагдсан хэвээр. Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн Ц.Элбэгдорж хүртэл ард түмнээсээ ялгаагүй, энэ тухай мэдээлэл авч гависан юмгүй сууж байгааг хараад олон хүн гайхсан биз

ээ. Гэтэл монгол хүн бүр “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа эзэмшигч бус гэж үү? Өөрийн өмчийн тухай мэдээлэл байнга авч, санаа тавих эрхгүй бил үү?

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Тавантолгойн төсөл эдийн засаг, бизнес, геополитикийн олон сонирхлын огтлолцол болоод буй. Энэ төсөл хэрхэн хэрэгжихээс монгол хүн бүрийн амьдрал, амьжиргаа шалтгаалах гээд байна. Тиймдээ ч Монгол Улсын Засгийн газраас томилсон Ажлын хэсгийн үйл ажиллагаа тунгалаг, нээлттэй байх ёстойг олон хүн сануулж байгаа юм.

Эцэст нь, Монгол Улсын хөгжлийн төлөө Тавантолгойг эдийн засгийн эргэлтэд оруулж, монгол хүн бүрийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг бэлэглэж буй бол төр, засгийн эрхмүүдэд “баярлалаа” гэж хэлэхээс өөр яах билээ. Үнэхээр бэлэн мөнгө өгснөөс хамаагүй дээр, ухаалаг шийдвэр болсон байж ч мэдэх юм. Гэхдээ сонгуулийн шоу хийхийн тулд Тавантолгойн баялгаа тарамдаад хаячих вий гэсэн бодол төрж буйг нуух юун. 536 ширхэг хувьцаа хоосон цаас биш байгаасай, хожим нь ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх баталгаа болоосой. ■

### Хөрөнгийн бирж

## Хөрөнгийн биржийг хөгжүүлэх ажил эхэлээ

**2011.04.08.** Эл өдөр түүхэнд тэмдэглэгдэн үлдэнэ. Учир нь, “Лондоны хөрөнгийн бирж” групп Монголын хөрөнгийн биржтэй энэ өдөр “Ажлын мастер гэрээ”-г үзэглэлээ. Энэ гэрээг үзэглэснээр Монголын иргэдэд гурван жилийн дараа олон улсын санхүүгийн зах зээлд гарах боломж бүрдэнэ. Тодруулбал, Лондон, Тронтогийн биржийн арилжаанд 24 цагийн турш оролцдог болно. Өөрөөр хэлбэл, монголчууд гэрээсээ интернэтээр холбогдон дээрх хөрөнгийн биржээс хувьцаа худалдан авч, Канад, Английн иргэд Монголын хөрөнгийн биржээс хүссэн хувьцаагаа авч,

зарах боломжтой гэсэн үг.

“Өдрийн мэнд” хэмээн монголоор мэндчилсэн Лондоны хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал ноён Хавиер Ролет “Монгол Улс эдийн засгаараа дэлхийд тэргүүлэх бүрэн боломжтой. Монголын хөгжлийн шинэ үе эхэлж байгаа үед хамтын ажиллагааны сууриа тавьж байгаад баяртай байна” гэв. Дэлхийн 70 шахам орны 2600 гаруй компанийн ойролцоогоор дөрвөн их наяд ам.доллар бүхий хөрөнгийг удирдаж буй Лондоны биржийнхэн “Монголд эдийн засгийн өсөлтийг авчирч чадах дэлхийн хэмжээний хөрөнгийн зах зээлийг



Фотог INET

бүтээн байгуулах итгэлт түнш байх болно” гэдгээ илэрхийлж байлаа.

Тэд Монголын хөрөнгийн биржид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид орон зай, цаг хугацаанаас үл хамаарах өндөр хурдны арилжааны программыг нэвтрүүлэх гэнэ. Өөрсдийн арилжаанд ашигладаг Millenium IT буюу дэлхийн хамгийн хурдан энэ программ нь хямд өртгөөр, урт хугацаанд, үр ашигтай оролцож, хөрөнгийн захаас бодит өгөөж хүртэх боломжийг бий болгох давуу талтай аж. Лондоны хөрөнгийн биржийн техникийн болон арилжааны мэргэжилтнүүд манай Төрийн өмчийн хорооны хяналт дор ажиллаж, биржийн бүх технологийг шинэчлэх юм байна.

“Ажлын мастер гэрээ”-нд гарын үсэг зурах ёслолыг нээж Ерөнхий сайд С.Батболд үг хэлсэн юм. Тэрбээр жилгаруйн өмнө Хөрөнгийн зах зээл хөгжлийн түлхүүр гэсэн илтгэл тавьж, энэ зах зээлийг хөгжүүлэхийн ач холбогдлыг тухай онцлон дурдаж байлаа. Энэ удаад уг санааг давтан “Дугуйг шинээр бүтээх шаардлагагүй. Хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэхийн тулд туршлагатай улс орнуудаас суралцах хэрэгтэй. Энэ хүрээнд Лондоны хөрөнгийн биржтэй хамтран ажиллах стратегийн гэрээнд гарын үсэг зурж, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг шинэ шатанд гаргах хөгжлийн бодитой хөшүүрэг болгох чухал гэрээг байгуулж байна” гэлээ. Түүнчлэн “Энэ хамтын ажиллагаанаас монголчууд илүү хожих болно. Монгол Улсын хөгжилд бодитой

хувь нэмэр орно гэдэгт эргэлзэхгүй байна. Энэ өдрүүдэд Засгийн газраас “Эрдэнэс Тавантолгойн”-н нийт хувьцааны 10 хувь буюу 1.5 тэрбум ширхэг хувьцааг иргэддээ адил тэгш, үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх томоохон шийдвэр гаргаад байгаа. Энэ агуулгаараа түүхэн чухал үйл явдал болж байна” гэж тэмдэглэсэн юм.

Монголын хөрөнгийн биржийг олон улсын түвшинд хүргэсэн, бүс нутгийн хөрөнгийн зах зээлийн

томоохон түшиц төв болгоход дэмжиж хамтран ажиллана гэсэн Лондоны биржийн удирдлагуудад тэрбээр амжилт хүссэн юм.

“Гэрээнд гарын үсэг зурсны маргаашнаас бүх зүйл хийгдчихнэ гэж ойлгож болохгүй. Энэ арилжааны программуудыг суурилуулахад тодорхой хугацаа шаардана, битгий яараарай” гэж Лондоны хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал учирласан. Тэрбээр “Ерөнхий сайдын хэлснээр бодитой ажил болгохын тулд бүх зүйл биднээс шалгаална. Туршлагатай хөрөнгийн биржтэй стратегийн түншлэлийн хамтын ажиллагааг эхлүүлж байгаа нь зүг чигээ тодорхойлчихлоо гэсэн үг” гэж тодотголоо. Мөн ард иргэдийг хөрөнгийн зах зээлийн мэдлэгтэй болгох талд тусгайлан хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх тухай ярьснаа дуулгав.

Монголын санхүүгийн зах зээлийн нэр хүнд цаашид Лондоны хөрөнгийн биржийнхнээс ихээхэн хамаарна. Монголчуудын хүсэн хүлээсэн санхүүгийн хөгжил гурван жилийн дараа илүү тодорхой харагдана. ■

## Тендер шалгаруулалтын үнэлгээг цахим системээр хийнэ

Сангийн яам Засгийн газрын худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхээр БНСУ-ын Засгийн газартай хамтран “Монгол Улсад цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх төсөл”-ийг нэг жилийн хугацаатайгаар 2010 оны аравдугаар сараас хэрэгжүүлж эхлээд байна. Үүний хүрээнд тус яам тендер шалгаруулалтын үнэлгээг цахим системээр хийхээр төлөвлөн ажиллаж байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд манай орны хууль эрх зүйн орчинд тохируулан системийн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан ба түүнд тулгуурлан системийн загварыг хийх ажил үндсэндээ

дуусчээ.

Системийн загварыг боловсруулж буй хугацаанд төрийн байгууллага, тендер оролцогч нарын санал хүсэлтийг сонсож системд тусгах зорилгоор төслийн явцын танилцуулгыг энэ дөрөвдүгээр сарын 14, 15-нд зохион байгуулав. Энэ үеэр Монгол Улсад Цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх төслийн хүрээнд хийгдэж буй системийн үйл ажиллагаа, түүний удирдлагыг төрийн байгууллагын худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтан нарт танилцуулах бөгөөд цахим худалдан авах ажиллагааны системийн онцлогийн талаар санал солилцов.

# Алишер Али: Монголчууд Казахстаны алдааг бүү давтаасай

*“Eurasia Capital” группийн захирал Алишер Алитай ярилцлаа.*

**-Монголын Засгийн газар “Эрдэнэс Тавантолгой” компанийн IPO-г олон улсын хөрөнгийн зах зээлд хийнэ гэж байгаа. Та энэ тал дээр ямар бодолтой байдаг вэ?**

-Энэ нь Монголын хувьд үнэхээр түүхэн үйл явдал болно гэж би үздэг. “Эрдэнэс Тавантолгой” нь IPO хийснээр Монголын анхны “Үндэсний аварга” төрөхөөр байгаа юм. Хэмжээ болон ач холбогдлыг нь авч үзвэл “Эрдэнэс Тавантолгой” компани зах зээлийн үнэлгээ нь 190 тэрбум ам.долларт хүрсэн Оросын “Газпром”, 168 тэрбум ам.доллараар үнэлэгддэг Бразилийн “Vale”,



90 тэрбумын Хятадын “Shenhua Group”, 12 тэрбум ам.долларын зах зээлийн үнэлгээтэй Казахстаны “Kazakhmys” зэрэг компанитай дүйцэхээр байгаа юм. Тиймээс “Эрдэнэс Тавантолгой”-н IPO Монголын ард түмний амьжиргааг дээшлүүлж, Монголын хөрөнгийн бирж сайжрахад нөлөөлж, Монголын эдийн засгийн урт хугацааны эрчимтэй өсөлтийн гол хөшүүрэг болно гэдэгт би итгэдэг.

**-Гэхдээ Монголын эдийн засгийн форумын үеэр Та “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг эхлээд дотоодын хөрөнгийн зах зээлд гаргах хэрэгтэйг онцолж байсан шүү дээ. Үүнийгээ манай уншигчдад тайлбарлахгүй юу?**

-“Үндэсний аварга” компанидаа монголчууд юуны түрүүнд хөрөнгө оруулах боломжтой байх нь чухал шүү дээ. “Эрдэнэс Тавантолгой” болон бусад төрийн өмчит томоохон компанийн үндсэн бүртгэлийг Монголын хөрөнгийн биржид хийх нь улс орны хөгжилд ч чухал гэж би боддог. Ингэснээр хөрөнгийн баялаг Монголын дотоодын зах зээлд бий болно. Монголын Засгийн газар, компаниуд болон хувь хөрөнгө оруугчид дотооддоо хөрөнгө оруулж, үндэсний баялгийнхаа үр шимийг шууд хүртэх боломжтой болох юм.

Нэг жишээ татъя л даа. Манай “Silk Road Mongolia” индексийн (Гадаад, дотоодын биржүүд дээр бүртгэлтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг томоохон компаниудын хувьцааны ханшийг харуулдаг энэхүү индексийг “Eurasia Capital” гаргаж буй) сагсад багтдаг 31 компанийн 22 нь Нью-Йорк, Торонто, Лондон, Хонконг болон Австралид хувьцаагаа арилжаалж байна. Эдгээр 22 компани 36 тэрбум ам.долларын баялгийг олон улсын зах зээлд буюу Монголоос гадуур бий болгочиоод байна шүү дээ. Энэ нь мэдээж том амжилт, гэхдээ монголчуудын оролцоо хязгаарлагдмал бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчид л хамгийн их ашгийг хүртсэн байгаа юм. Гэтэл Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа арилждаг 300 гаруй компанийн зах зээлийн нийт үнэлгээ ердөө хоёр тэрбум ам.долларт хүрч байх жишээтэй. Харьцуулаад үз л дээ.

Харин “Эрдэнэс Тавантолгой” болон бусад төрийн өмчит томоохон компанийн хувьцааг дотооддоо гаргаснаар томоохон хөрөнгө оруулалтын банк, брокерийн пүүс, зөвлөгөөний компани гэх мэтийн зах зээлийн олон бүрэлдэхүүнийг цогцоор нь бий болгох, хөгжүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл, энэ нь мэдлэгт суурилсан, оюунлаг санхүүгийн үйлчилгээний салбарыг үүсгэх, өндөр ур чадвартай

» боловсон хүчнийг олноор нь бий болгох сайн талтай. Энэ нь нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл бий болгох Засгийн газрын бодлоготой ч нийцэх юм шиг санагддаг шүү.

**-Монгол шиг хөгжиж буй орон дотоодын хөрөнгийн зах зээлээ амжилттай хөгжүүлсэн туршлагаас Та тодорхой жишээ дурдаж болох уу?**

-Дотоодын зах зээлдээ ач холбогдол өгөхийн давуу талыг бид Малайзын жишээнээс харж болох байх. Тус улсын үүрэн холбооны томоохон оператор болох "Maxis Communications" 2009 оны арваннэгдүгээр сард дотоодынхоо буюу Куала Лумпурын хөрөнгийн биржид IPO хийсэн нь маш амжилттай болсон юм. Нийт хувьцааныхаа 30 хувийг олон нийтэд санал болгохдоо олон улсын "Credit Suisse", "Goldman Sachs" болон "JPMorgan" зэрэг хөрөнгө оруулалтын томоохон банкнаас тусламж авч, 3.3 тэрбум ам.доллар босгосон байдаг. "Goldman Sachs" энэхүү IPO-д андеррайтераар оролцохын тулд ганц сарын дотор Малайз улсад салбараа нээсэн гээд бод доо. Малайзын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ сүүлийн таван жилийн дотор хоёр дахин нэмэгдэж, эдүгээ 270 тэрбум ам.долларт хүрсэн нь төрийн өмчит компаниудынхаа хувьцааг дотооддоо арилжаалдгаас үүдэлтэй болов уу. Тус улсын ихэнх компани зөвхөн "гэртээ" хувьцаагаа арилждаг бөгөөд энэ нь олон улсын хөрөнгө оруулагчдыг огтхон ч үргээдэггүй. Харин ч гадаадын хөрөнгө оруулагчид зөвхөн Куала Лумпурын хөрөнгийн биржээс л Малайзын компаниудын хувьцааг авах боломжтой байдаг тул энэ зах зээлд хөрөнгө оруулалт их орж ирдэг юм.

Ер нь "Эрдэнэс Тавантолгой" үндсэн бүртгэлээ гадаадад хийвэл алдаа болж, Монголын хөрөнгийн биржийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж мэдэхийг Казахстаны жишээ ч харуулах байх. Тус улс өмнө нь хийсэн алдаатайгаа одоо хүртэл тэмцсээр. 2005 оноос Казахстаны компаниуд Лондоны хөрөнгийн биржид идэвхтэй нэвтрэх болсон юм. Ялангуяа тус улсын "үндэсний аварга" болох ENRC болон "Kazakhmys" (эдүгээ хоёул FT-100 индекст багтаж байгаа)

Лондонд IPO хийсэн нь хамгийн том 100 компанийнх нь тоонд орчихоод байгаа. Гэтэл өнөөдөр Казахстаны компаниуд дотоодынхоо хөрөнгийн биржид давхар бүртгүүлсэн ч гэлээ энэ нь зүгээр л "хэлбэрдэлт" болж хувираад байна. Яагаад гэвэл Казахстаны компаниудын хувьцааны 95-99 хувь нь Лондонд л арилжаалагддаг (доорх хүснэгтээс харна уу). Гадаадын хөрөнгө оруулагчид Казахстаны компаниудын хувьцааг Лондоноос авах нь хамаагүй хялбар учир Казахстаны хөрөнгийн зах зээлд шууд хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа юм. Ингээд арилжааны хэмжээ нь өчүүхэн, идэвхгүй тул Казахстаны хөрөнгийн зах зээл хөгжөөгүй өдий хүрлээ. Монголчууд энэ орны 5-6 жилийн өмнөх алдааг битгий давтаасай гэж боддог. Үүнийг тойрч гарч чадна гэдэгт ч итгэдэг.

**-Гэхдээ Монголын Засгийн газар зөвхөн олон улсын хөрөнгийн зах зээлээс л их хэмжээний мөнгө төвлөрүүлж чадна гэж үзээд байгаа шүү дээ...**

-Хэрвээ төгс ертөнц гэж байдаг сан бол Монголын компаниуд зөвхөн Монголын хөрөнгийн биржид л бүртгэлтэй байх хэрэгтэй болов уу. Мэдээж үүнийг бодит бус, боломжгүй гэж үзэх хүн цөөнгүй гарах байх. Яагаад гэвэл Монголын хөрөнгийн бирж жижиг учраас гадаадын хөрөнгө оруулагчид Лондон эсвэл Хонконгийн хөрөнгийн биржээр дамжуулж хөрөнгө оруулахыг илүүд үзнэ гэх байх л даа. Мэдээж Монголын хөрөнгийн биржийг олон улсын стандартад хүргэхийн тулд их хөдөлмөр, хугацаа шаардлагатай. Монгол Улсын Засгийн газар "Эрдэнэс Тавантолгой"-н IPO-г цаг алдалгүй хийхийг хүсч байгаа бол тус компанийн хувьцааг эхэлж Монголын хөрөнгийн биржид бүртгүүлээд, хадгалалтын сертификат (Depository Receipts) гэдэг санхүүгийн хэрэгслийн тусламжтайгаар Лондон болон Хонконг зэрэг хөрөнгийн биржид давхар бүртгүүлж болно шүү дээ. Эдгээр хадгалалтын сертификат нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Эрдэнэс Тавантолгой" компанийн хувьцаанд суурилсан байх юм. Энэ арга Бразил, ОХУ, Хятад, Вьетнам зэрэг хөгжиж буй зах

**Казахстаны зарим компанийн гадаадын (ЛХБ) болон дотоодын бирж дэх арилжааны хэмжээ, 2010 онд**

Компанийн нэр	Үйл ажиллаганы чиглэл	Төрийн эзэмшлийн хувь	Зах зээлийн үнэлгээ (сая ам. доллар)	Арилжааны хэмжээ (сая ам.доллар)		Нийт дүнд эзлэх хэмжээ (хувиар)	
				дотоодын	гадаадын	дотоодын	гадаадын
ENRC	Төрөлжсөн ашигт малтмалын	25%	19,704	0.95	20,596.01	0.01%	99.99%
Kazakhmys	Зэс	15%	12,463	1,362.33	30,278.99	4.3%	95.7%
Kazmunaigas EP	Газрын тос & байгалын хий	60%	9,907	3.04	1,744.93	0.2%	99.8%
Halyk Bank	Банк	20%	3,330	9.11	444.44	2%	98%
Kazkommertsbank	Банк	21%	2,728	0.47	124.49	0.4%	99.6%

Эх сурвалж: Bloomberg, Eurasia Capital

► зээлийн компаниудын дунд өргөн дэлгэрч байгаа юм.

**-Улстөрчдийн шийдвэрийн дагуу “Эрдэнэс Тавантолгой”-н 10 хувийг иргэдэд үнэгүй тараах болсон. Энэ тухай Та юу гэж боддог вэ?**

-Би хувьдаа энэ шийдвэрийг дэмжиж байгаа. Яагаад гэвэл улсынхаа байгалийн баялгийг эзэмшиж байна гэсэн санааг нийт иргэдэд шууд хүргэж байгаа юм. Түүнчлэн Засгийн газар цаашид дэмжээд өгвөл иргэдийн санхүүгийн мэдлэг өндөр болно. Монгол хүн бүр хувьцаа эзэмшигч болж байгаа учраас түүнийгээ удирдан, шийдвэр гаргах туршлага сууна. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн хөгжилд илүү идэвхтэй оролцож эхлэх болов уу. Ер нь зүгээр бэлэн мөнгө тарааснаас хувьцаа тараах нь хамаагүй дээр гэж би үздэг.

**-Дэлхийн хамгийн өндөр өсөлттэй зах зээлээр Монголын хөрөнгийн зах зээл шалгарсан, өнгөрсөн онд. Энэ байдал цаашид үргэлжлэх болов уу?**

-Өнгөрсөн онд Монголын хөрөнгийн биржийн Top 20 индекс 138 хувиар өсч, нийт зах зээлийн үнэлгээ нь түүхэндээ анх удаа нэг тэрбум ам.доллараас давсан. Ирэх жилүүдэд Монголын хөрөнгийн зах зээл өндөр өсөлт үзүүлнэ гэдэгт би эргэлзэхгүй байгаа. Урт хугацаанд өсөлт тогтвортой үргэлжилнэ гэж бодож байна. Гэхдээ богино хугацаанд гарч болох эрсдэлүүдийг мартаж болохгүй.

Монголын хөрөнгийн зах зээл одоогоор сул хөгжсөн байгаа бөгөөд үнийн хэлбэлзэл хэт их гарч байна. Саяхан ажиглагдсан огцом өсөлтөд л гэхэд нүүрсний дөрөв, уул уурхайн бус нэг гээд ердөө таван компани нөлөөлсөн байх жишээтэй. Хэдийгээр өндөр өсөлт ажиглагдаж байгаа ч эргэлтэд байгаа хувьцааны тоо болон арилжааны хэмжээ хэт бага байна шүү дээ. Мөн шинээр IPO хийхгүй байгаагийн зэрэгцээ зах зээлд спекулятив шинж чанартай арилжаа их хийгдэж байгаа. Иймэрхүү хүндрэл байгаа ч компанийн засаглал, тунгалаг байдлыг сайжруулж, шинэ IPO-нууд гарган туслах салбарыг хөгжүүлснээр хөрөнгө оруулагчдын сонирхлыг илүү ихээр татах

## Мэргэжлийн боловсролын сангийн хөрөнгө бүрдүүлэх журмыг баталлаа

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг Засгийн газарт жил бүрийн хоёрдугаар сард багтаан танилцуулж байхыг холбогдох сайд нарт даалгаж журмыг хэрэгжүүлэх, хяналт тавих асуудлаар хуулийн дагуу хамтран ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлд даалгав. Санд улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг УИХ, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлах бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага сайн дурын үндсэн дээр хөрөнгө төвлөрүүлж болох юм байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан” нь эрэлтэд суурилсан, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын үйлчилгээг дэмжих юм. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчид болон ажилгүй залуучууд, иргэдэд богино хугацаанд нийгэм, хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай болгон ажилгүйдэл, ядууралтай тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд энэ сан чухал үүрэгтэй гэж Засгийн газар үзэж байна.

болов уу. Энэ ч утгаараа Лондоны хөрөнгийн бирж болон Монголын хөрөнгийн биржийн түншлэл нь урт хугацааны эерэг нөлөө бүхий маш чухал алхам болсон гэж үздэг.

Лондоны хөрөнгийн бирж нь гаднын улсын, тэр тусмаа Монгол шиг шинээр хөгжиж буй орны хөрөнгийн биржийг шууд удирдан ажиллуулж байсан тохиолдол байхгүйг энд онцолмоор байна. Өөрөөр хэлбэл, энэ нь Лондоны хөрөнгийн бирж энэхүү хамтын ажиллагаанд ямар их ач холбогдол өгч байгааг харуулж байгаа юм. Энэ хамтын ажиллагаа Монголын хөрөнгийн биржийг дотоодын компаниудын хувьд хөрөнгө босгох таатай талбар, иргэдийн хувьд баялгийг оновчтой хуваарилах зөв суваг болгож чадна гэдэгт итгэдэг.

**-Танай компаниас гаргасан “Mongolia Outlook 2011” тайланд энэ онд Монголын эдийн засаг 10 хувиар өснө гэсэн байсан. Ер нь үсрэнгүй хөгжилд хүрнэ гэж монголчууд итгэдэг. Харин Та?**

-Тийм ээ, би Монголын эдийн засгийн төлөвийг эергээр харж байгаа. Өнгөрсөн онд Монголын

эдийн засаг 6.1 хувиар өсч, гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.5 тэрбум ам.доллар буюу бүх цаг үеийн дээд хэмжээндээ хүрсэн. Түүнчлэн экспорт 54 хувиар нэмэгдэж, төгрөгийн ханш 13 хувиар чангарлаа. Ирэх жилүүдэд Монголын эдийн засаг илүү хурдтай өснө гэдэгт би итгэлтэй байгаа. Манай компанийн таамаглаж буйгаар 2011 онд Монголын эдийн засаг 10 хувиар өсч, өсөлтөөрөө дэлхийд нэгдүгээрт биш юм аа гэхэд эхний гуравт жагсах болов уу. Эдийн засгийн энэхүү өндөр өсөлтийн гол хүчин зүйлүүдийн нэг нь Оюутолгойн хөрөнгө оруулалт, ашигт малтмалын өндөр үнэ болон тэдгээрийн экспортын өсөн нэмэгдэж буй эрэлт байх төлөвтэй. Түүнчлэн Засгийн газрын зарлага ихээхэн тэлж байгаа зэрэг нь Монголын эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлнө. Урт хугацаанд буюу ирэх 10 жилийн турш Монголын эдийн засаг хамгийн өндөр өсөлттэй эдийн засгийн тоонд зүй ёсоор багтана гэж боддог. Ер нь Монгол Улс маш сонирхолтой цаг үедээ ирээд байна.■

## Тэвчээр хатуужлын цараа шалгасан үйлдвэрлэл

**“Mongolian Economy” сэтгүүл энэ дугаараасаа “Made in Mongolia” гэсэн шинэ булан нээлээ. Энэ булангийнхаа зочныг сонгохоор удаан ярилцсаны эцэст нэгэн сонирхолтой үйл эрхэлдэг хүнийг олсон юм.**

### Сэрүү татаж сэнгэнэсэн суудлын бүрээс

Дан шагайгаар хийсэн машины суудлын бүрээсэн дээр сууна гэхээр “нухаж мэднэ” гэх болгоомжлол танд төрж байна уу? Жигдхэн өрж, холбосон шагай хамгийн сайн массаж болдог гэвэл Та битгий гайхаарай. Нэг суудлын бүрээсэнд дунджаар 800 шагай ордог байна. Б.Даваажанцан гэх эр шагайгаар суудлын бүрээс хийгээд таван жил болжээ. Он гарснаас хойш гурван ч суудлын бүрээс хийжээ. “Монгол Улс 40 гаруй сая толгой малтай ч шагай тийм ч олдоцтой биш. Уг нь бол монголчууд маханд дуртай учраас шагай элбэг гардаг. Гол нь хүмүүс шагайг хүндлэн дээдэлж, Цагаан сарын үеэр бараг айл бүр морь уралдуулах, алаг мэлхий өрөх дайны шагайтай байхыг эрхэмлэдэг учраас түүнийгээ зарах нь ховор” гэж Б.Даваажанцан сонирхуулсан. Гэсэн ч тэр хөдөө орон нутгаар явж, бас махны чөنجүүдтэй найзлан суудлын бүрээсээ хийсээр л байна.

Түүний түүхий эдээ хэрхэн базаадаг нь сонин. Нэг кг шагайг тэр 500-1000 төгрөгөөр худалдан авдаг аж. Килограммаар тооцвол нэг суудлын бүрээс 7-8 кг жинтэй болдог юм билээ. Шагайгаа цуглуулахдаа бас учиртай. Олдсон болгоныг нь аваад байхгүй. Хүмүүсийн захиалгын дагуу ямар шагай цуглуулахаа шийднэ. Морь талаар нь байрлуулсан суудлын бүрээс захиалсан тохиолдолд баруун, зүүн тийш харахаас үүдээд асуудал гарна. Дан баруун эсвэл зүүн тийш “харсан” шагай хайх нь төвөгтэй байдаг ч “азаар” тийм захиалга их биш байдаг аж. Биед эвтэйхнээр нь хүмүүс ихэнхдээ хонь, ямаа талаар нь байрлуулсан суудлын бүрээс захиалдаг гэсэн.

### Шагайг ямар ч химийн бодисгүйгээр өнгө оруулдаг

Шагайгаа цуглуулж, захилгатайгаа танилцснаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлнэ. Эхлээд



шагайгаа гурван удаа сайтар чанана. Энэ нь шагайгаар бүтээгдэхүүн хийчихсэн хойно тос ялгарахааргүй болгож байгаа гэсэн. Шагайн бүрээснээс тос ялгараад байвал хэцүү биз дээ. Эхний удаа 5-7 цаг чанаж, хөргөөд тосыг нь арчина. Энэ үйлдлийг гурван ч удаагийн давтамжтайгаар хийж, тосноос нь салгана. Энд ямар ч химийн бодис холих шаардлагагүй. Дараа нь өнгөнд оруулна. Үйлдвэрлэлийн хамгийн сонирхолтой хэсэг энд явагдана. Даваажанцан шагайгаа ихэвчлэн бор, улаан, шар, ногоон өнгөнд оруулдаг байна. Бүтээгдэхүүний өнгийг ямар ч химийн хоргүйгээр гаргана гэдэг сонирхолтой санагдаж байгаа биз. Энд хүрэн улаан өнгийг шинэс модны холтосноос гаргаж авах бөгөөд шагай, холтосыг хамтад нь чанадаг гэнэ. Харин шар өнгийг гаргахын тулд цэцэгтэй хольдог бол ногоон өнгийг өвснөөс төвөггүйхэн гаргаж авна. Шагайгаа өнгийг нь гаргах гэж байгаа мод, ургамалтайгаа хамт чанадаг. Энэ үед шагай малын гаралтай бүтээгдэхүүний үнэрээ гээж, ургамлын үнэртэй болдог аж. Даваажанцан “Үнэртээд үз дээ” хэмээн өнгө бүрийн шагайнаасаа байн байн миний аманд барьж сонирхуулж байв.

Дараа нь шагай тус бүрийг цэвэрлэх их ажилдаа орно. Шагайг сайтар цэвэрлэхэд техник ч хийж чадахгүй учраас шагай тус бүрийг нямбайлан өөрийн гараар цэвэрлэнэ. Үйлдвэрлэгчийн хэлснээр хамгийн түвэгтэй дамжлага нь энэ. Одоо дараагийн дамжлага цоолох. Цахилгаан өрмөөр шагай тус бүрийг хоёр удаа цоолдог. Үүгээр сатуркан утас оруулж, хэлэхдэг байна. 800 шагайг одоо хэлхэнэ. Бас л тэвчээр шаардсан амаргүй ажил. Захиалгын дагуу машины суудлын хэмжээнд тааруулж, бас өөрийн өнгө төрхийг илэрхийлэх дизайны дагуу хэлхэнэ гээд бод доо. Үйлдвэрлэлийн шат дамжлага дуусч байна. Гэвч

» энэ бүх шат дамлагад 14 хоног зарцуулдаг байна.

Шагайгаар суудлын бүрээс хийх нь нарийн гар ажиллагаа ихтэй учраас цаг их шаарддаг байна. Цаг шаардаад зогсохгүй тэсвэр тэвчээр, уран чадвар маш их зарцуулдаг үйлдвэрлэл болох нь уншигч танд ч тодорхой харагдаж байгаа болов уу. Он гарснаас хойш гуравхан хос бүрээс хийсэн нь үүнтэй холбоотой. Даваажанцан ч “Шагайгаар бүрээс хийнэ гэдэг тэвчээртэй, уйгагүй хөдөлмөрч хүний ажил гэдгийг дахин дахин учирлаж байсан. “Би дөрвөн ч хүнд хийх аргыг нь зааж өгсөн. Нэг нь эхнээсээ шантарч, гурав нь нэг нэг бүрээс хийж авсан. Гэвч тэд ахиж хийх бодлоо орхисон” гэж тэрбээр хэлсэн. Өмнө нь тэр

шагайгаар олбог, бэлэг дурсгалын зүйл хийдэг байж. Өөрийнх нь хэлснээр шагайгаар 42 нэр төрлийн бүтээгдэхүүн хийж болдог гэсэн. Харин суудлын бүрээс хийх санаагаа 2006 оноос хэрэгжүүлж эхэлжээ. Хүмүүс эхэндээ шагайн дээр суух нь нухахаас эхлээд таагүй байх гэж болгоомжилдог байж. Гэвч сууж туршсан хүн заавал захиалга өгдөг гэсэн. Хүч хөдөлмөр их зарцуулдаг гэхэд бүтээгдэхүүн нь үнэ ханшийн хувьд харьцангуй гайгүй юм. Нэг суудлын бүрээсээ 100.000 төгрөгөөр зардаг байна. Гар аргаар голлож хийдэг учраас бүтээгдэхүүндээ 10 жилийн баталгаа олгодог. Энэ хугацаанд холбоос нь тасрах, сулрах асуудал гарвал үнэгүй сольж өгч, үйлчлүүлэгчээ дээдэлдэг гэсэн.

Шагайн бүрээсийг гаднынхан их сонирхдог байна. Харин дотоодод бүтээлийг нь П.Сүхбат аваргаас эхлээд цөөнгүй хүн хэрэглэдэг аж. Шагайн бүрээсний давуу тал нь чийг татахгүй, зуны цагт бол сэрүү татаж байдаг учраас тухтай.

Даваажанцанд энэ бизнесээ үйлдвэрлэл болгон өргөжүүлэх чин хүсэл бий. Одоогоор түүний энэ хүч хөдөлмөр шаардсан ажилд нь тус дэм болох хүн байхгүй байгаа учраас цаг алдах талтай гэнэ. Сүүлийн үед захиалга нь нэмэгдсээр байгаа болохоор тэрбээр энэ ондоо багтаагаад чин хүсэл эрмэлзлээ бодит ажил болгоно гэсэнт зорилготой байгаа юм билээ. ■

## Банкир ярьж байна

# Жон П.Финиган: Монголын банкууд өөрийнхөө хөрөнгөөр томрох магадлал тун бага

Д.Бэхбаяр

*“Голомт” банкны гүйцэтгэх захирал Жон П.Финигантай ярилцлаа*

**-Монголын хөрөнгө санхүүгийн зах зээл хөгжиж эхэллээ. Энэ салбарын хөгжлийн үндэс суурийг зөв тавих талд таны бодлыг сонсоё?**

-Монголд гадаадын хөрөнгө оруулалт одоо л хөгжиж байна гэж ойлгож болохгүй. Харин сүүлийн 10-аад жилд гаднын хөрөнгө оруулалт Монголд илүү эрчтэй хөгжсөн байна. Дэлхий дахиныг хамарсан санхүүгийн хямралын ганцхан жилд л хөрөнгө оруулалтын үзүүлэлт буурсан тал бий. Түүнээс дэлхий Монголыг сонирхож байна, энэ сонирхол нь цаашид улам нэмэгдсээр байх болно. Тиймээс ирэх он жилүүдэд хөрөнгө оруулалт улам нэмэгдэж, хөгжих боломж

нөхцөл нээлттэй харагдаж байна, Монгол Улсад. Үүний тулд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, хуулиа боловсронгуй болгох, улстөрийн тогтвортой байдлыг хангах замаар хөгжлийн зөв загварыг бариад хөгжих хэрэгтэй. Монгол Улсад үйлдвэрлэл, ажлын байрыг нэмэгдүүлэх таван чухал хүчин зүйл байгаа. **Нэгдүгээрт**, нөөц бололцоо. Монгол маш онцлогтой, баялаг ихтэй орон. Химийн таблиц буюу Менделевийн хүснэгт дээрх 100 гаруй химийн элементийн 80 гаруй нь байна шүү дээ. Энэ

баялаг, нөөц боломжоо ашиглаад зөв бодлогоор явуулбал, богино хугацаанд хөгжих бүрэн боломж харагдаж байна. **Хоёр дахь** нь хөрөнгө. Монголын хувьд хөрөнгийн эх үүсвэр хангалттай бус учраас гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. Хөрөнгө оруулалт 2010 онд 176 хувиар нэмэгдэж 1.57 тэрбум ам.долларт хүрсэн. **Гуравдугаарт**, удирдах зохион байгуулах ур чадвар. Монголд энэ талын ур чадвар хангалтгүй тул гадаадын мэргэжилтэн судлаачдыг ажиллуулах замаар



» гадаад арга барилаас суралцаж, дотоодын удирдлагын системтэйгээ хослуулах нь зөв юм. **Дөрөвдүгээрт**, ажиллах хүч. Дэлхийн улс оронтой хөл нийлүүлэн явахад орчин үеийн техник технологийг эзэмшин ажиллах чадвартай боловсон хүчин зайлшгүй шаардлагатай. Монгол Улс орчин үеийн технологийг нэвтрүүлэхэд анхаарна гэж байгаа бол түүн дээр ажиллах боловсон хүчин хэрэгтэй болно. Үүний тулд сургалт явуулах, гадаадын мэргэжлийн хүмүүсийн туршлагыг судлах шаардлагатай болно. **Тавдугаарт**, зах зээл. Монгол Улс зах зээлийн хувьд азтай, адислагдсан орон. Дэлхийн өсөлт хөгжлийн төвд нь байна. Маш их эрэлт хэрэгцээг агуулсан их гүрний хажууд төдийгүй Азийн бусад хурдацтай хөгжиж буй орнуудтай нэг бүсэд байдаг. 2010 онд Монгол Улсад хийгдсэн хөрөнгө оруулалт буюу хөрөнгө бүрдүүлэлт ДНБ-ий 40 хувийг бүрдүүлж, хэрэглээ 68 хувьд хүрч, цэвэр экспортын хэмжээ найман хувийг эзэлж баланс барьж байна.

**-Лондоны хөрөнгийн биржийнхэн МХБ-ийг хөгжүүлэх ажилдаа шуударлаа. Таны бодлоор манай хөрөнгийн бирж хөгжлийн ямар түвшинд хүрэх бол?**

-Саяхан болж өнгөрсөн “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулган дээр Ерөнхий сайд С.Батболд аюулгүй амьдрах чадвартай үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх талаар үг хэлсэн. Өнөөдөр хөрөнгийн биржийн үйл ажиллагааг өнгөц харвал тоон үзүүлэлт нь сайн харагдаж байгаа хэдий ч түүний үндсэн үйл ажиллагааны чанарын асуудалд учир дутагдалтай зүйл олон байна. Эндээс үзэхэд, гаднын буюу Лондоны хөрөнгийн биржийн удирдлагын менежментийг нэвтрүүлж байгаа нь сайн зүйл юм. Ирэх 2-3 жилд хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд томоохон ахиц гарна гэдэгт итгэлтэй байна. Миний туулсан болоод ДОХА-гийн үнэт цаасны зах зээлийн шинэчлэгдэж хөгжиж ирсэн туршлагаас үзвэл энэ нь дунд хугацааны зорилт юм. ДОХА-гийнх шиг амжилттай болж чадвал энэ нь олон улсын хэмжээний бирж буй болоход хүргэдэг. Одоо ДОХА-гийн хөрөнгийн зах зээл дээрх хөрөнгийн хэмжээ нь 110 тэрбум ам.доллараас давсан ба Катарын ДНБ-ээс жаахан л бага байгаа юм. Хэсэг хугацааны дараа Монголын хөрөнгийн бирж дээрх амжилтад хүрнэ гэдэгт би бүрэн итгэлтэй байна

**-Уул уурхайн салбараас гадна бусад салбарыг хөгжүүлэхэд**

**хэрхэн анхаарах шаардлагатай байна вэ?**

-Уул уурхайн салбарын хөгжил нь Монголын эдийн засгийг хөдөлгөх гол хүч болж байна. Энэ утгаар уул уурхайн салбар хөгжихдөө өөрийн үйл ажиллагаатай холбоотой олон салбарын хөгжлийг дэмждэг. Олон салбарт сайнаар нөлөөлнө. Хөгжил дагуулна. Уул уурхайг дагасан олон төрлийн бараа үйлчилгээ гарч ирнэ. Барилга, байгууламж дэд бүтэц, вйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Олон төрлийн үйлчилгээний салбарт нөлөөлнө. Ер нь бол уул уурхай ДНБ-ийг өсгөх гол хөдөлгөгч чиглүүлэгч хүч байна. Гэхдээ маш өргөн уудам газар нутагтай мөртлөө 2.7 сая хвн амтай улсад зах зээл ямар түвшинд хөгжих, хэрэгцээ ямар байх талаар ул суурьтай бодож төлөвлөх нь чухал байх.

**-Монголын банкны салбарын өнөөгийн хөгжлийг бусад оронтой харьцуулахад ямар түвшинд явж байна вэ?**

-Монголын банкны салбар хөгжлийнхөө эхний шатанд явж байна. Банкны нийт системийн хэмжээнд 5,5 тэрбум ам.долларын хөрөнгөтэй. Бусад оронтой харьцуулахад хөрөнгийн хэмжээ маш бага гэсэн үг. Гэлээ ч өөрсдийнхөө түвшинд тийм ч муугүй хөгжиж байгаа. Монголын банкууд санхүүгийн хэцүү үеийг амжилттай даван туулж, хөл дээрээ зогссон. 2010 онд банкны нийт хөрөнгийн хэмжээ 41 хувиар өссөн ба үүний дунд “Голомт” банкных 56 хувиар өссөн. Энэ үзүүлэлт нь “Голомт” банкныг оны эцэст тус улсын хамгийн том банк болгосон юм. Банкуудын хувьд нөөц баялгаа хөдөлгөөнд оруулах тэр үүрэгт хамтарч ажиллацгаасан. Энэ утгаараа Монголын банкууд казино банк болж хувираагүй. Санхүүгийн буруу үйлчилгээ үзүүлээгүй харин ч үлгэр жишээ болж ирлээ. Чанаргүй нийт зээлийн хэмжээ зургаан хувь хүртлээ буурсан. Харин “Голомт” банкны хувьд чанаргүй зээлийн хэмжээ 1.5 болтлоо буурсан.

**-Тэгвэл банкны хөгжлийг улам хурдасгахад төрөөс ямар арга хэмжээ авах шаардлагатай бол?**

- 2010 онд батлагдсан Банкны тухай хууль нь банкуудад тулгараад байсан хэцүү асуудлуудыг авч үзэж олон улсын практик үйл ажиллагааг тусгасан байдаг. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон сайд нар Монголын эдийн засгийн чуулган болон бусад төстэй уулзалт зөвлөлгөөнүүд дээр хэлж байсан үгнээс харахад зах зээлийн үр ашигтай

ажиллагаанд саад тотгор болж байгаа болон оршин буй монополийг хадгалдаг хүнд суртал, олон дүрэм журмын хүндрэлээс зайлсхийх хэрэгтэй талаар онцлон тэмдэглэж байсан. Харамсалтай нь цаг зав бардаг хүнд суртлыг идэвхтэйгээр багасгаж, хүнд суртлыг халах арга хэмжээг дорвитой авч хэрэгжүүлж чадахгүй байна.

Энэхүү саад тотгорын нэгэн жишээ бол хөрөнгө бүрдүүлэлт болон санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг болох өргөн хүрээтэй үйлчилгээг явуулахын тулд хуулиар банкуудад олгосон өргөн хүрээтэй эрх мэдлийн эсрэг явуулж буй үйл ажиллагаа юм. Санхүүгийн зохицуулах хорооноос банкуудын

**Уул уурхайн салбар нь дөнгөж хөлд орсноос эхлээд хөгжилд хүрсэн үеийг туулсан орнуудад ажиллаж байлаа.**

эрх мэдлийг гажуудуулж зөвхөн одоо оршин буй үр ашиггүй монополиудыг хадгалж үлдэх төдийгүй Монгол Улсын тэргүүлэгч банкуудын цаашдын өсөлт хөгжил болон өрсөлдөх чадварыг хязгаарласан хуулийн төслийг саяхан боловсруулжээ.

**-Энэ талаараа дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?**

-Хөрөнгө оруулалтын банк болон банкны үнэт цаасны үйл ажиллагаанд тавьсан хязгаарлалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос бий болгожээ. Банкны үйл ажиллагаанд хязгаарлалт тавьж байгаа. Хөрөнгө оруулагч болоод үнэт цаасны зах зээлд банкнаас явуулах үйл ажиллагааг хязгаарласан гэсэн үг. 60-аад брокер диллерийн компанийн үйл ажиллагааг хамгаалж үлдэхийн тулд банкны оролцоонд хязгаарлалт хийлээ.

**-Монголын банкуудыг жижиг гэдэг. Тэгвэл томруулах, нөгөө талаар банкуудын зээлийн хувь бууруулах ямар боломж байна вэ?**

- Хvv өндөр байгаа нь Монголын эдийн засаг болоод төгрөгийн ханштай холбоотой. Төгрөгийн ханш 2010 онд

► 16 хувиар нэмэгдчихсэн байгаа бол 2011 оны нэгдүгээр сараас хойш төгрөгийн ханш тав хвртэл хувиар өссөн. Монголбанкны тогтмол хvв 11 хувь байгаа бол инфляци найман хувь руу орж ирлээ. Тэгэхээр энэхүү учир дутагдалтай хүчин зүйлүүдээс болоод Монголбанкны тогтоосон хүү зах зээлийн тохиромжтой хүүг тогтооход саад болж байна. Мөн хүү өндөр байгаа явдал нь банкны секторуудын тэнцвэргүй өрсөлдөөн, төрийн бодлого болон өөр бусад зүйлээс шалтгаалан буурахгүй байна. Ерөнхийдөө инфляцийн дарамт, төгрөгийн ханшны өсөлттэй байгаа ч зээлийн хүү буурна гэж таамаглаж байна. Дээрх хүчин зүйлүүдээс болоод Монголын банкууд томорч чадахгүй байна. Одоогоор Монголд гурван том банк байгаа. “Голомт” банкны хувьд 27 хувийн өсөлт гаргасан ч банкны системийн хэмжээнд энэ өсөлт харьцангуй бага 41 хувь байдаг. Тэгэхээр Монголын банкууд дотооддоо өөрийнхөө хөрөнгөөр томрох магадлал тун бага.

Тиймээс гадаадын капиталыг татах замаар хөрөнгөө өсгөх, томруулах боломж бий. Энэ утгаар “Голомт” банк тэргүүлэх гаднын санхүүгийн хоёр том байгууллагатай хамтарч ажилладаг. Арабын нэгдсэн Эмиратын Абу Дабигийн Хөрөнгө оруулалтын зөвлөл нөгөө нь Швейцарийн тэргүүний банк Кредит Свисс юм. Цаашдаа ч гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, ойрын хугацаанд IPO гаргана гэж төлөвлөж байна. Ер нь баялаг, боломжийг дагаад гадны санхүүгийн байгууллагууд Монгол орныг ихэд сонирхож орж ирнэ. Энэ нь Монголын банкуудад хөрөнгийн хуримтлал бий болгох, хүрээгээ тэлэхэд ашигтай байх болно. Гадаадын банкуудын суурин төлөөлөгчийн газар олноор байгуулагдах төлөвтэй байна. Тухайлбал, Нидерланд, Их Британи, Австралийн банкууд төлөөлөгчийн газраа байгуулчихлаа.

**-Та Европ, Ази, Ойрхи Дорнодын банкуудад ажиллаж ихээхэн туршлага хуримтлуулсан олон улсын банкир хүн юм. Тэрхүү туршлагаасаа хуваалцана уу. Монголын хувьд таны өмнө нь ажиллаж байсан орнуудаас ямар онцлогтой байна вэ?**

-40 жилийн турш банкны салбарт ажиллаж арвин их туршлага хуримтлуулжээ. Уул уурхайн салбар нь дөнгөж хөлд орсноос эхлээд хөгжилд хүрсэн үеийг туулсан орнуудад ажиллаж байлаа. Бруней, Индонез, Катар, Кувейт гэх мэт.

Хамгийн гайхалтай, бахархмаар нь тухайн улс орныг дөнгөж хөгжиж цэцэглэх үед ажиллаж тэдгээр улс орны жаргал зовлон бэрхшээлийг хамтдаа даван туулсан явдал. Мөн зарим нь ашигт малтмалын бүтээгдэхүүнийг экспортолж хөгжсөн улс шүү дээ.

Миний хувьд туршлагаа илүү хуваалцсан нь Катарын үндэсний банкинд гүйцэтгэх захирал болоод Катарын Сангийн сайдын зөвлөхөөр ажиллаж байсан үе. Тэр үед 1995 онд Катарын ДНБ нь зургаан тэрбум доллар байсан нь одоогийн Монголын нөхцөлтэй адилхан байлаа. Харин тус улс 16 жилийн дараа ДНБ-ий хэмжээгээ 120 тэрбум ам.доллар хүртэл өсгөсөн. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөрөө дэлхийн хамгийн хурдан хөгжилтэй оронд орно. ДНБ-ий өсөлт нь 11,6 хувиар өссөн. Дэлхийн хамгийн хурдацтай өсөлттэй орноор Хятадыг нэрлэдэг нь ташаа мэдээлэл юм.

Тэгэхээр миний бие Монгол Улсыг ДНБ-ий өсөлтийн хөгжлөөр дараагийн 10 жилд Катар улсыг гүйцэж очно гэдэгт итгэж байна. Катар нь дэлхийн хамгийн баян улс болж байгаа юм. Нэг хүнд 82000 ам.доллар ногдож байна. Монгол Улсын ДНБ ойрын хугацаанд бага орлоготойгоос дунд, дундаас их рүү хүрч өсч, хөгжихөөр байна. Монголын дөнгөж хөгжиж хөл дээрээ босч буй банкиг олон улсын стандартын мэргэжлийн банкны түвшинд хүргэхэд санхүүгийн тогтвортой хөгжлийг бий болгоход өөрийн хувь нэмрээ оруулж байгаадаа цаашдаа ч оруулах болно гэдгээрээ бахархаж байна.

**-Та манай уншигчдад анхны бизнесийн шинэ санаагаа хэрхэн амьдруулж байсан тухайгаа сонирхуулахгүй юу?**

-Сонирухотой асуулт байна. Туршлагатай менежер захирлуудын амжилтад хүрсэн түүх нь дандаа л өөрсдийн алдаанаас суралцсан байдаг. Нөгөө талаар алдаанаасаа сэргийлэх, тэр алдаа юунаас болж гарав гэдгийг мэдэж байвал амжилтад хүрэх нэг хүчин зүйл болно.

Хамгийн анхны шинэ санаагаа ярихын тулд дөрвөн жилийн өмнөх түүх ярья. 40 жилийн өмнө 1971 онд Бруней улсын Стандарт Чартеред банкинд ажиллаж байлаа. Бруней бол маш амжилттай хөгжиж байгаа орон. ДНБ нь 12 тэрбум ам.доллар хүрсэн байна. Тухайн үед улсын эдийн засгийг шингэн хийн экспорт авч явдаг байлаа. Тэр үед ДНБ нь маш бага буюу 170 сая ам.доллар.

Маш бага орлоготой, жижиг жижиг хотхонууд тархсан байдалтай байсан. Миний хувьд энэ улсын хөгжлийн потенциалын чадавхийг харсан. Хэрэглээний банкны маш их шаардлага боломж байгаа нь анзаарагдсан. Манай банк гурван салбартай тултэрхүүжижигжижиг олон хотхон бүрт салбар нээх боломжгүй. Ингээд би мобайл буюу нүүдлийн банкны үйлчилгээг нэвтрүүлсэн. Интернет, утаснаас өмнө шүү дээ. Яаж сэтгэсэн гэхээр автобусны дотор талд банкны салбараа байгуулаад жижиг хотхонууд руу дамжин явж, хэрэглэгч үйлчлүүлэгчдэд хүрч үйлчилдэг байсан. Одоо тус банк долоон салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

**-Өнөөдөр Монголд бизнесийн шинэ санаатай хүн олон байна. Та тэдэнд зөвлөгөө өгөхгүй юу?**

-Шинээр бизнес эхлэх, шинээ санаа санаачилгын хязгааргүй их боломж Монголд байна. Энэ бол зөвхөн бизнес эрхлэгч болон бизнесмэнүүдийн хөрөнгийн боломжоос шалтгаална. “Голомт” банк бизнесийн инкубатор хөтөлбөрийг зарим харилцагчтайгаа хамтраад хэрэгжүүлж байгаа. Монголын залуус болон бизнес эрхлэгчдийн бизнесээ төлөвлөх, хөрөнгөө нэмэгдүүлэхэд туслах зорилгоор ийм хөтөлбөр хэрэгжүүлж байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн 1000 хүн амтай Гурвантэс суманд хөтөлбөрийнхөө хүрээнд сургалт явуулахад 90 гаруй хүн хамрагдсан. Ингэснээр сумын иргэдэд жижиг бизнес эрхлэх суурь нөхцөлүүдийг сурч авч, уул уурхай дагасан жижиг бизнес эрхлэх боломжтой болж байгаа юм.

**-Манай улсын хөгжлийн хандлага банк санхүүгийн байгууллагуудыг цаг үетэй нийцсэн үйлчилгээ үзүүлэхийг шаардаж байх шиг байна?**

-“Голомт” банкны хувьд салбартаа тэргүүлэгч, шинийг анхлан санаачлагч байсаар ирсэн. Монголд анхны электрон банк, картын болон АТМ-ын үйлчилгээг нэвтрүүлсэн. Анхны хувийн тэтгэврийн санг өөрсдийн ажилчдын дунд нэвтрүүлсэн бол Хөрөнгө оруулалтын банкиг оруулж ирж байна. Энэ бүх үйлчилгээг зөвхөн манайх бус бусад банк ч явуулж байгаа. Ер нь улс орны болон иргэдийн хөрөнгө мөнгө нэмэгдэж байгаатай холбогдуулан хөрөнгө санхүүгийн шинэ үйлчилгээ, боломжууд гарч ирж байна. Зах зээлийн шинэ нөхцөл байдалтай уялдсан үйлчилгээг манай банк шуурхай үзүүлэх болно. ■

# Монгол Улс: Эдийн засаг, санхүүгийн зарим үзүүлэлт, 2009-2012

	2009	ХБГ 2010	Төсөөлөл 2011	2012
<b>Бодит салбар</b>	<i>Өөрчлөлт (хувиар)</i>			
ДНБ-ий бодит өсөлт	-1.3	6.1	10.3	7.6
Эрдэс баялгийн	2.3	9	13.4	12.6
Эрдэс баялгийн бус	-2.6	5	9	5.5
Хэрэглээний үнэ (хугацааны дундаж)	6.3	10.2	16.4	16
Хэрэглээний үнэ (хугацааны эцэст)	1.9	14.3	20	12
ДНБ-ий дефлятор	1.8	18	14.1	8.9
<b>Улсын нэгдсэн төсөв</b>	<i>ДНБ-д эзлэх хувиар</i>			
Нийт орлого, тусламжийн дүн	30.2	37.2	35.1	35
Нийт зарлага, цэвэр зээл	35.2	36	38.5	38.9
Урсгал тэнцэл	2.6	9.4	4.4	6.8
Суурь тэнцэл	-4.5	1.7	-3.1	-3.7
Нийт тэнцэл (тусламжийн дүн ороод)	-5	1.2	-3.5	-3.9
Эрдэсийн бус нийт тэнцэл	-11.8	-10.6	-13.3	-11.8
Тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон тэнцэл	-6.8	-2.8	-6.3	-6.5
<b>Мөнгө зээл</b>	<i>Өөрчлөлт (хувиар)</i>			
Нийт мөнгө	26.9	61.6	45	23.5
Нийт мөнгөний хурдац (ДНБ/Нийт мөнгө)	2.3	1.8	1.5	1.5
7 хоногтой ТБҮЦ-ны хүү (хугацааны эцэст, хувиар)	10	11	-	-
<b>Төлбөрийн тэнцэл</b>	<i>Сая ам.доллараар</i>			
Урсгал дансны тэнцэл (албан ёсны шилжүүлэг ороод)	-410	-931	-1,302	-1,438
ДНБ-д эзлэх хувиар	-9	-15.2	-15.1	-13.6
ДНБ-д эзлэх хувиар (уул уурхайн импортыг хасаад)	-5.8	-5.8	2.5	0.1
<b>Гадаад худалдааны тэнцэл</b>	-194	-278	-1,049	-1,107
Экспорт	1,876	2,899	3,825	4,083
Импорт	-	-3,177	-4,874	-5,190
	2,070			
<b>Гадаадын хөрөнгө оруулалт</b>	496	1,574	1,130	548
Гадаад валютын нийт албан нөөц (хугацааны эцэст)	1,328	2,290	3,586	4,127
(Дараа оны бараа, үйлчилгээний импортын сараар)	4.1	4.9	7.1	8.8
<b>Гадаад худалдааны үнэ</b>	<i>Өөрчлөлт (хувиар)</i>			
Экспортын үнэ (ам.доллар)	-18.2	29	9.8	-1.4
Импортын үнэ (ам.доллар)	-18	13.2	7.4	0.5
Гадаад худалдааны нөхцөл	-0.2	14	2.3	-1.9
<b>Засгийн газрын болон Засгийн газрын баталгаатай өр</b>	<i>ДНБ-д эзлэх хувиар</i>			
Улсын нийт өр	46.6	43	38.6	37.1
Гадаад өр	43.3	30.8	22.8	19.8
(сая ам.доллар)	1,977	2,023	2,064	2,097
<b>ДНБ, оны үнээр (тэрбум төгрөг)</b>	6,591	8,255	10,382	12,166

Эх сурвалж: Олон улсын валютын сан

# Бизнесийн орчин сайжирсан гэв үү?

Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн ажлын үр дүнгээ Ерөнхий сайд С.Батболд УИХ-ын чуулганы үеэр тайлагнаж байна. Шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж, хууль эрх зүйн орчин сайжирч, манай улсын өрсөлдөх чадвар дээшиллээ гэх мэтээр сайхан үгс урсгаж гарав. Түүний яриаг УИХ-ын гишүүд уулга алдан дэмжиж, алга таших нь холгүй баясацгаах ажээ. “2010-2011 оны өрсөлдөх чадварын үнэлгээгээр Монгол Улс 139 орноос 99 дүгээр байрт жагссан нь өмнөх жилийнхээсээ 18 байраар урагшилсан хэрэг” хэмээн Ерөнхий сайд бардамнав. Гэхдээ С.Батболд сайд маань нэг зүйлийг мартсан бололтой. Дэлхийн банкнаас гаргадаг “Бизнес эрхлэхүй 2010” судалгаагаар манайх 183 орноос 60 дугаарт бичигдэж байсан бол 2011 оны үзүүлэлтээр 73 дугаарт жагсаж, даруй 13 байраар ухарчээ.

“Монголын бизнесийн орчин хамгийн таагүй байна. Үүний тод жишээ гэвэл нийслэлчүүд хэрэгцээгээ дан импортын бараа, бүтээгдэхүүнээр хангаж байгаа явдал. Ямар ч бизнесийн орчин, орон зай алга” гэж эдийн засагч С.Одонтуяа тэмдэглэсэн байна. Үнэхээр монголчууд хүнсний бараа, бүтээгдэхүүнийхээ 70 гаруй хувийг гадаадаас худалдаж авдаг гээд бодохоор яагаад идэж, уухаа хүртэл дотооддоо үйлдвэрлэж болохгүй байна вэ гэсэн асуулт гарч ирнэ. “Одоо монголчууд голдуу хямд үнэтэй хятад бараа хэрэглэж байна. Тиймээс дотоодын үйлдвэрүүдийг хамгаалсан хууль эрх зүй, татварын таатай орчин байх ёстой. Монгол Улс импортын орон гэдгийг хэн ч хэлнэ. Гэтэл импортын орон эдийн засгийн хувьд хамгийн тогтворгүй, хөгжлийн хувьд хэзээд буурай байдаг түүхтэй” хэмээн “Их харанга” компанийн захирал Я.Энхтайван онцолж байлаа.


Үүний зэрэгцээ хөдөө орон нутгийн бизнесмэнүүд хамгийн хүнд байдалд үйл ажиллагаа явуулсаар. Ус, цахилгаан, халаалтнаас эхлээд түлш, шатахуун нь хүртэл алслагдсан аймгуудад асар үнэтэй байдгийг бид мэднэ. Түүнчлэн манай орон өргөн уудам нутагтай, хүн ам сийрэг учир аливаа тоног төхөөрөмж, түүхий эдээ нэг газраас нөгөө газарт хүргэхийн тулд их хэмжээний зардал гаргах болно. Дэрээс нь замын асуудал ямар байгаа билээ? Гэтэл татварын хэмжээ хот, хөдөө ялгаагүй нэг л түвшинд байдаг шүү дээ. Өндөр өртгөөр үйлдвэр байгуулж, жижиг зах зээлд нийлүүлэхийн тулд ажлын байр бий болгож байгаа хүмүүсийг татварын бодлогоор дэмжих хэрэгтэйг мэргэжилтнүүд зөвлөж байна.

Дотоодын үйлдвэрлэгчдэд тулгамдаж буй бас нэгэн чухал асуудал бий. Юу гэвэл ямар ч бизнес эрхлэгч тогтвортой байдлыг чухалчилдаг. Тэгвэл Монгол Улсад 20 сая ам.доллараас дээш хэмжээний хөрөнгө оруулагч гадаадын компани хүсэлт гаргавал 10-15 жилийн тогтвортой байдлын гэрээ байгуулах боломжтой. Гэтэл Монголд дотоодын хөрөнгө оруулалтын тухай тусгайлан мөрдөж буй хууль тогтоомж ч алга. Гадаадынханд болохоор хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлчихээд, үндэсний компаниудаа нүд үзүүрлэдэг гаж тогтолцоог яалтай билээ?

Дотоодын аж ахуйн нэгжүүдийг ч гэсэн тодорхой шалгууртайгаар хөрөнгө оруулалтын тогтвортой байдлын гэрээ байгуулах эрхтэй болгох санал боловсруулж буйгаа МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл дуулгав.

“Гадаадын хөрөнгө оруулагчдыг хамгаалах төрөл бүрийн дэмжлэг байдаг хэрнээ дотоодынхныг хаячихсан байсан. Гэхдээ сүүлийн жилүүдэд бизнесийн орчин сайжирч байгааг онцлох нь зүйтэй” хэмээн Монголын Энтэрпренерүүдийн холбооны тэргүүн Б.Гармаасүрэн хэлсэн юм. Үнэхээр Засгийн газар бизнес эрхлэгчдийн хувьд бага ч гэсэн найдлага төрүүлж эхэлснийг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

“Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн төлөвлөгөөнд нийт 131 зорилт, арга хэмжээ тусгаж ажилласан байдаг. Энэ хүрээнд, тухайлбал, бүртгэлтэй холбоотой 128 нэр төрлийн үйлчилгээнд хураамж авч байсныг 57 болгон цөөлжээ. Бизнес эрхлэгчид ямар нэг үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахын тулд олон албан тушаалтны гарын үсэг цуглуулж, цаг заваа алдаж, улмаар авлига энэ тэрээр ажлаа хөнгөвчлөхийг оролддогийг багасгах чиглэлд овоо ажил хийснийг сануулах юун. Нэг барилга барьж ашиглалтад оруулахын тулд 118 албан тушаалтнаар гарын үсэг зуруулдаг байсныг 56 болгож бууруулсан нь мөн л Засгийн газрын гавъяа гэлтэй.



» Энэ нь тухайн аж ахуйн нэгж гарын үсэг зуруулахад зарцуулж байсан 480 гаруй хоногийг 180 болгосон үзүүлэлт ажээ.

Түүнчлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 700 орчим тоног төхөөрөмжийг гаалийн албан татвар болон НӨАТ-аас чөлөөлсөн, хөнгөлөлттэй зээл олгож, лизингээр тоног төхөөрөмж авах нөхцөлийг бүрдүүлсэн гээд сайшаах зүйл олон гарна. Гэхдээ бизнес эрхлэгчдийг ганц, хоёр жил дэмжээд л дорвитой үр дүнд хүрчихдэг юм биш гэдгийг төр, засгийн эрхмүүд ойлгож, мэдэрсэн болов уу.

Хувийн хэвшлийн 40 мянга орчим аж ахуйн нэгж манай

улсын ДНБ-ий 70 гаруй хувийг үйлдвэрлэж, 800 мянган хүнийг ажлын байраар хангаж байгаа гэх статистик бий. Гэтэл хууль эрх зүйн тогтворгүй орчин, хүнд суртал, хээл хахууль гээд олон асуудалтай өдөр бүр тулгардаг бизнесмэнүүд бол ёстой л хал үзэж, хашир суусан хүмүүс. Ямартай ч төрийн эрх мэдэлтнүүдийн хатуу чих зөөлөрч, баялаг бүтээгчдийнхээ үгийг сонсдог болсон нь “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн хамгийн том амжилт гэдгийг ихэнх бизнесмэн тэмдэглэж байна. Хамгийн гол нь энэ ажил цаашид ч үргэлжлээд явах үндэс суурь бий болсон гэдэгт л хувийн хэвшлийнхэн найдаж буй ажээ. ■

болгож чадахгүй гацаанд орчихдог. Уг нь зээл авах хэлбэрүүд нэг үеэ бодвол нээлттэй болсон. Гэхдээ барьцаа хөрөнгөнөөс эхлээд зээлийн шалгуур нэлээд өндөр байна шүү дээ” гэж Монголын Энтерпренерүүдийн холбооны тэргүүн Б.Гармаасүрэн тэмдэглээд, “Манай банкныхан төслийг үнэлж чаддаггүй. Ирээдүйн бизнесийг барьцаалаад зээл олгодог сайхан тогтолцоо хэрэгтэй” хэмээн онцлов. Үнэхээр санхүүгийн эх үүсвэр байхгүйн улмаас олон сайхан санаа амьдрал дээр хэрэгжихгүй хоцорч байгаа болов уу. Шинэ санааг чулуу болгохын тулд мөнгө хэрэгтэй. Гэтэл хэчнээн сайхан санаа байгаад барьцаа хөрөнгөгүй л бол зээл авна гэдэг “лөө лөө”. Арай хийж зээл авлаа ч хүүгийн дарамт гэж нэг айхтар зүйл бас байна аа!

Арилжааны банкуудын бизнес эрхлэгчдэд олгож буй зээлийн хүү сарын 1-2.5 хувийн хүүтэй. Жилдээ 20 орчим хувийн хүү төлөөд үйл ажиллагаа явуулна гэдэг үнэхээр бэрх даваа. “Дэлхийн банкны судалгаанаас харахад Монгол Улсын санхүүгийн захын хөгжил 139 орноос 129 дүгээр байранд оржээ. Түүвэр судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн 40 хувь нь банкны зээлтэй байсан бөгөөд тэн хагас нь зээл авах өргөдөл гаргаагүй, харин 7.4 хувь нь татгалзсан хариу авсан байв. Эндээс санхүүгийн зуучлал хангалттай хөгжөөгүй, өндөр хүүтэй зээлийн эрэлт бага байгаа нь харагдаж байна” хэмээн Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж онцолж байв.

Зээлийн хүү өндөр байгаа нь инфляцитай шууд хамаатай. Яагаад гэвэл хадгаламжийн хүү инфляцийн түвшнээс доогуур байвал хэн ч мөнгөө банкинд өгөхгүй, улмаар зээлийн эх үүсвэр бүрдэхгүй. Өндөр хүүтэй хадгаламжаар эх үүсвэрээ бий болгосон банкууд үйл ажиллагааны зардал, эрсдэлийн тооцоо, ашгаа нэмээд бүр ч өндөр хүүтэй зээл гаргах нь дамжиггүй. 2010 онд инфляци улсын хэмжээнд 13, Улаанбаатарт 14.3 хувьтай гарсан шүү дээ. Гэтэл энд нэгэн сонирхолтой дүр зураг тодроод ирнэ.

Манай орон хүнсний бүтээгдэхүүнийхээ 70 хувийг гадаадаас авдаг байна. Хэрэглээний сагс буюу инфляцийг тооцоолоход ашигладаг 287 нэр төрлийн бараа,

Банк, санхүү

# Зээл хүртээмжтэй байна уу?


Та бизнес эхлэх гэж байна уу? Эсвэл өөрийн бизнесийн цар хүрээг тэлэх хүсэлтэй байна уу? “Зээлийн хэмжээ нэмэгдэж, нөхцөл сайжирлаа!”. Ийм утга бүхий сурталчилгааг Монголын бараг бүх банк хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацаж байна. Бичиг баримтаа бүрдүүлэн банк руу ухасхийхийнхээ түр азнаарай. Үнэхээр зээлийн нөхцөл сайжирсан гэж үү?

Санхүү, эдийн засгийн хямралын үед банкууд зээл олгохдоо хойрго болж, цөөн тооны найдвартай харилцагчидтайгаа л сэмхэн


“нөхөрлөж” байсан. Тэр үетэй харьцуулахад зээл элбэг болжээ. Одоо бол “Нааш ир, бүх төрлийн зээл байна, авах уу?” л гэнэ. Гэхдээ үүнийг өөрийн болгохын тулд Та өндөр босго давж гарах чадалтай байх ёстой. Бизнесээ хоёроос доошгүй жил тогтвортой эрхэлсэн, энэ хугацаанд татварын ямар нэгэн асуудалд ороогүй, бусад банкнаас зээл аваагүй гээд л... Хамгийн гол нь Та барьцаанд тавих хөрөнгөтэй байх шаардлагатай.

“Монголд бизнес хийх эрмэлзлэлтэй залуу олон байна. Гэхдээ төслөө бодит амьдрал

Инфляцийн бүтэц



Инфляцийн түвшин 2010 онд



Эх сурвалж: Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо

үйлчилгээний 158 нь буюу 55 хувь нь импортын ажээ. Ингээд манай импортын гол түнш орнууд болох ОХУ, БНХАУ, БНСУ-д инфляци өндөр гарснаас манайд ч мөн энэ үзүүлэлт талийсан тухай Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооныхон мэдээлсэн байна. Өөрөөр хэлбэл, бид өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнээ гадаадаас авдаг нь үнийн тогтвортой байдлыг хангахад хүндрэл үзүүлж байгаа юм. Энэ байдлаас яаж гарах вэ гэхээр дотоодын үйлдвэрлэлээ өргөжүүлэх учиртай. Гэтэл зээлийн хүү өндөр байгаагаас жижиг дунд үйлдвэрүүд төрж, өсч томрох нөхцөл алга. Товчхондоо инфляци өндөр байгаа нь зээлийн хүү буурахад саад болж буй бол зээлийн хүү өндөр байгаа нь инфляцийг тогтворжуулахад тушаа болж буй ажээ. “Өндөг тахианаас гардаг уу, тахиа өндөгнөөс гардаг уу?” гэдэг шиг л юм даа...

Монголчуудыг ийн будилж байх зуур “Bloomberg” нэгэн мэдээлэл дамжуулав. Урд хөршид инфляци таван хувьд хүрч байгаагаас тус улсын Ерөнхий сайд Вэн Зябао байж болох бүх арга хэмжээг авна гээд амлаж явна гэнэ. Гэтэл манайд энэ үзүүлэлт 10 хувиас давчихаад байхад Засгийн газар нүдэн балай, чихэн дүлий. Ер нь инфляци гэхээр л монголчууд Төвбанкаа нүд үзүүлээд ирдэг талтай. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулахад Засгийн оролцоо ч чухал гэдгийг таг мартжээ.

Гаалийн үйл ажиллагаа удаашралтай, ачаа барааг нэг хотоос нөгөө хотод хүргэхэд хүндрэлтэй зэрэг олон шалтгааны улмаас импортын барааны өртөг нэмэгдэж, инфляци өсөхөд хүргэж байгааг мэргэжилтнүүд онцолж байна. Түүнчлэн 33 сая малтай хэрнээ гурав хүрэхгүй сая монгол хүн яагаад махны үнийн өсөлтөд дарамтлуулах ёстой гэж? Энэ бүхэнд Засгийн газар анхаарлаа хандуулснаар үнийн тогтвортой байдал бий

болох учиртай. Өөрөөр хэлбэл, зээлийн хүү буурах нөхцөл бүрдэхэд нэмэртэй.

Нөгөө талаас хэрвээ манай жижиг, дунд үйлдвэрлэгчид хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох боломжтой байсан сан бол арилжааны банкуудын өндөр хүүтэй зээлийг “царай алдаж” суухгүйсэн. Тэгээд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэж, Орос, Хятадаас инфляци “импортлохгүй” амар байх сан. Даанч өнөөдөр манай орны санхүүгийн салбарын 95 хувийг банкны салбар дангаараа эзэлж буй болохоор арилжааны банкинд хандахаас өөр гарц алга байна шүү дээ.

Засгийн газар 2009 оноос улсын төсвөөс жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн. Сарын нэг хувийн хүүтэй, гурван жилийн хугацаатай зээл гэдэг юутай сайхан. “Энэ хугацаанд 11 гаруй мянган иргэн, аж ахуйн нэгж нийт 913 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авах хүсэлт ирүүлсэн байдаг. Бид үүнээс 84.5 тэрбумыг нь л олгосон. Есөн хүн тутмын нэг нь л зээл авч чадсан гэсэн үг” хэмээн Жижиг дунд үйлдвэрийн

газрын дарга Ц.Ням-Осор учирлав. Засгийн газар улс төрийн амлалт биелүүлэхийг чухалчилж, бэлэн мөнгө тараахын оронд жижиг дунд үйлдвэрлэлээ дорвитойхон дэмжээд өгвөл бизнес цэцэглэж, олон мянган ажлын байр ч бий болох тухай “Mongolian Economy” сэтгүүлийн эхний дугаарын “140 мянган ажлын байр уу, 21 мянган төгрөг үү?” нийтлэлд тодорхой харуулсан билээ.

Энэ бүхнээс үзэхэд зээлийн хүү буурч, нөхцөл сайжрах үндэс суурийг зөвхөн Төвбанк биш, Засгийн газар мөн бүрдүүлэх ёстой ажээ. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүгийн шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэх, дэд бүтцээ сайжруулах, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих гээд олон талаас арга хэмжээ авч байж зээлийн нөхцөл сайжрах тухай эдийн засагчид онцолж байна. Гэхдээ үүнийг хийхийн тулд УИХ, Засгийн газар, Монголбанк тал тал тийш хараад суух биш, хамтарч ажиллах хэрэгтэй ажээ.

Эцэст нь, монгол залуусын хүсэл эрмэлзлэл бизнес болон хэрэгжих цаг ирээсэй. Шинэ бизнес бүр шинэ ажлын байр, шинэ технологи өвөртлөн ирдэг билээ. Үүний тулд хамгийн чухал ганц зүйл бий. Хүү багатай, намхан босготой зээл хэрэгтэй. ■

Арилжааны банкуудын зарим төрлийн зээл

Банкны нэр (Зээлийн төрөл)	Зээлийн хэмжээ	Хугацаа	Хүү (сарын)
Төрийн банк (жижиг дунд бизнесийг дэмжих зээл)	15-500 сая ₮ (4 сар хүртэлх хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлж болно)	3 жил хүртэл	1.3-1.7%
Голомт банк (Бизнес зээл)	200 сая ₮ хүртэл	18 сар хүртэл	1.5-2.1%
ХААН банк (хөрөнгө оруулалтын зээл)	Бизнесийн цар хүрээндээс шалтгаалж уян хатан тогтооно	60 сар хүртэл	1.2-1.8%
Худалдаа хөгжлийн банк (Жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгох зээл)	150 саяас 1 тэрбум ₮ хүртэл	6-36 сар	1-1.85%
Хас банк (Жижиг дунд бизнесийн зээл)	3 тэрбум ₮ хүртэл	12-96 сар	1.3-1.9%
Хадгаламж банк (Эргэлтийн хөрөнгийн зээл)	Бизнесийн онцлог, цар хүрээндээс шалтгаалж тогтооно	12 сар, сайн харилцагч бол 24 сар хүртэл	1.3-2%
Үндэсний хөрөнгө оруулалтын банк эргэлийн хөрөнгийн санхүүжилтийн зээл	100 сая₮-өөс дээш	3 жил хүртэл	1.8-2.5%

## Банкир

**Нийгмийн эмзэг бүлгийнхэн хүртэл авсан мөнгөө эргүүлж төлөх чадвартай бөгөөд ядуурлыг бууруулах шилдэг арга нь барьцаагүй зээл өгөх явдал гэдгийг Бангладешийн банкир, профессор Мохаммад Юнус өөрийн үүсгэн байгуулсан “Grameen Bank”-аар баталсан билээ. Энэхүү ололтоороо тэрбээр 2006 онд Нобелийн шагнал хүртсэн тухай “Mongolian Economy” сэтгүүл анхны дугаартаа дурдаж байсан. Гэтэл Бангладешийн эрх баригчид Мохаммад Юнусыг өөрийнх нь “эх барьж” авсан банкнаас халсан явдал нэлээд шуугиан дэгдээв. Энэ тухай <http://lenta.ru/> цахим хуудсанд тун сонирхолтой нийтлэл гарсныг хөрвүүлэн хүргэж байна.**



<http://www.mongolianeconomy.mn>

## “Цус сорогчдод зай байхгүй”

*-Нобелийн шагналтныг өөрийнх нь банкнаас хөөжээ-*

**Н**обелийн шагналт Мохаммад Юнус 1983 онд өөрийн үүсгэн байгуулсан “Grameen Bank” банкны ерөнхий захирлын албан тушаалаас “хусагдав”. Дөрөвдүгээр сарын эхээр тус улсын Дээд шүүх Мохаммад Юнусыг халах Төвбанкны шийдвэрийг дэмжсэн байна. Бичил зээлийн “эцэг” болсон Юнусыг Бангладешийн эрх баригчид заналтайгаар “цус сорогч” хэмээн нэрлэсэн удаатай...

Эдийн засгийн профессор бөгөөд Бангладешийн банкир Мохаммад Юнус 2006 онд Нобелийн шагнал авснаасаа хойш дэлхийд алдаршжээ. Түүний үүсгэн байгуулсан “Grameen Bank” (орчуулбал хөдөөгийн банк) орон нутгийн ядуустай нягт харилцах болсон юм. Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст барьцаагүй зээл олгож эхлэхэд банкирууд Юнусыг “галзуурсан эрдэмтэн” гэж дүгнэж байсан үе бий. “Grameen Bank”-ны харилцагчдын ихэнх нь энгийн банкуудын айж, халгасаар ирсэн буурай иргэд байдаг болохоор

арга ч үгүй биз дээ. Харин Юнусын санаачилсан хамтын хариуцлагын систем (зээлийг бие биеэ батлан даах нэгдмэл сонирхолтой хэсэг бүлэг хүнд олгодог) нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэлийг бүрэн шийдсэн гэхэд болно. Тийм ч учраас “Grameen Bank” барьцаагүй зээлийг тайван олгож ирсэн бөгөөд одоо хүртэл эргэн төлөлт нь 98 хувьтай байгаа юм.

Гэхдээ тусбанкны зээлийн эргэн төлөлт сайн байгаагийн ард бас нэг шалтгаан байж болохыг зарим мэргэжилтэн онцолдог. Мохаммад Юнус эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг өсгөх үйлдэл хийж байгааг Бангладешийн шашны зүтгэлтнүүд нэг бус удаа шүүмжилж байв. Үнэхээр бүсгүйчүүд “Grameen Bank”-ны нийт харилцагчдын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг бөгөөд эмэгтэйчүүд л орлогоо гэр бүлийнхээ хэрэгцээнд эрчүүдээс илүү ухаалгаар зарцуулж чаддаг гэх ойлголт байдаг даа.

Ямар ч байсан Юнусын амжилт дэлхийг алмайруулсан. 1976

онд тэрбээр 27 ам.долларын бичил зээл хүнд өгөхдөө өөрийн халааснаас гаргаж байсан бол 2011 он гэхэд түүний үүсгэн байгуулсан банк ядууст нийт 10.3 тэрбум ам.долларын зээл өгсөн байна. Өнөөдөр Бангладеш улсад тус банкны 2500 салбар ажиллаж байгаа бөгөөд 81 мянган тосгоны олон сая иргэнд үйлчилгээ үзүүлж байгаа юм. Тус улсын хөдөлмөрийн чадвартай иргэдийн талаас илүү хувь нь газар тариалангийн салбарт ажилладаг ажээ.

Дэлхийн хамгийн буурай орнуудын нэг болох Бангладешийн 150 сая иргэний талаас илүү хувь нь өдрийн 1.25 ам.доллараас бага мөнгөөр гол зогооно. Харин Юнусын үүсгэн байгуулсан банк бичил зээл өгөх замаар 50 сая хүнийг ядуурлаас ангижруулсан гэх тойм тооцоо ч бий. Түүнчлэн найман сая гаруй харилцагчтай болсон “Grameen Bank”-ны туршлага хийгээд амжилт бусдыг уриалан даллаж, Бангладеш улсад бичил зээл гэдгийг ёстой л

» цэцэглүүлэн дэлгэрүүлсэн гэхэд буруудахгүй. Энэ оронд өнөөдөр “Grameen Bank”-наас гадна 1000 гаруй бичил зээлийн байгууллага ажиллаж, хоёр тэрбум гаруй ам.долларыг 25 орчим сая хүнд олгосон байна. Гэвч энэ бүх гавъяа нь Мохаммад Юнусыг өөрийнх нь үүсгэн байгуулсан банкнаас “нясалж” гаргахад саад болсонгүй.

## Баатрыг “шагнасан” нь

2011 оны гуравдугаар сард 71 настай Мохаммад Юнус “Grameen Bank”-ны ерөнхий захирлын албан тушаалаас халагдав. Энэ шийдвэрийг Бангладешийн Төвбанк гаргахдаа “Зохицуулагчдын зөвшөөрөлгүйгээр албан тушаал хашиж байсан, түүнчлэн тус улсын хуулийн хүрээнд 60-аас дээш насны хүн ажил хийх боломжгүй, тэтгэвэртээ суух ёстой” гэх шалтаг тоочжээ. Тэгвэл яагаад тэтгэврийн насны тухай хуулиа гэнэт санаж, зөвхөн одооноос л хэрэгжүүлж эхэлж байгаагаар холбогдох албаныхан тайлбарлахыг хүссэнгүй. Тэр тусмаа “Grameen Bank”-ны хувьд тусгай статустай учир тэтгэврийн насыг мөрдөлгүй өдий хүрсэн гээд бодохоор бүр ч хачирхалтай.

1983 онд “Grameen Bank” хараат бус статустай болсон бөгөөд 2000 онд 60 нас хүрсэн Юнус тус банкны ерөнхий захирлын албан тушаалыг хугацаагүй хаших эрх авч байжээ. Гэхдээ “Grameen Bank”-ны 75 хувийг зээлийн байгууллага, үлдсэн 25 хувийг нь Бангладешийн Засгийн газар эзэмшдэг бол “эх барьж” авсан Юнус энд ямар ч эзэмшилгүй байдаг бас л сонин.

Колумбын их сургуулийн эдийн засагч Ягдиш Бхагвати сүүлийн жилүүдэд “Grameen Bank” болон Юнус Засгийн газрынхаа эсрэг хүчин болж хувирч байгааг онцлоод, энэхүү үзэгдлийг Бангладешийн эрх баригчид хэрхэвч зүгээр өнгөрөөхгүйг сануулж байлаа. Үнэхээр ч түүний бодол бодожин биелэв. Төр, засгаас нь Юнусыг халагдахыг шаардах үед тэрбээр банкныхаа ТУЗ-ийн даргаар үлдэхийг гуйж байв. Ингэснээр Юнус өөрийн үүсгэн байгуулсан банкны үйл ажиллагааг хөндлөнгөөс ч болтугай харж чадахаа онцолж байсан юм. Гэвч Засгийн газар



нь Нобелийн шагналтны гуйлтыг биелүүлэхээс татгалзжээ.

1990-ээд оны дунд үед “Grameen Bank” Норвегийн Засгийн газрын мөнгийг хууль бусаар зарцуулсан хэмээн Юнусыг буруутгасан баримтат кино өнгөрсөн арванхоёрдугаар сард цацагдсан юм байна. Уг киноны зохиогчид “Norad” буюу Норвегийн хамтын ажиллагааны хөгжлийн агентлагийн архиваас олсон зарим баримтаараа Юнус 100 сая ам.долларын тусламжийн мөнгийг өөрийн нэг компаниас нөгөө компани руу шилжүүлэх замаар татвараас бултсан тухай өгүүлж л дээ. Гэхдээ Норвегийн Засгийн газар энэхүү баримтат киног шалгаж, Юнус мөнгийг буруу зүйлд ашигласан гэх ямарч баримт, нотолгоо олоогүйгээ албан ёсоор мэдэгдсэн ажгуу. Даанч нэгэнт хоцорсон байжээ.

Норвегийн уран бүтээлчдийн хийсэн киноны араас Юнусыг Бангладешийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд хурцаар шүүмжилж, Засгийн газар нь түүнийг татвараас зугтахын тулд заль хэрэглэсэн хэмээн үзэж, Норвегийн албан ёсны мэдэгдлийг үл харгалзан өөрсдөө шалгаж, судлахаа амласан юм. Бангладешийн Ерөнхий сайд Шейх Хасина өнгөрсөн арванхоёрдугаар сард Юнусыг “Grameen Bank” банкинд яг хувийн өмч шиг хандаж,

нөгөөх нь ядуучуудын “цусыг сордог” хэмээн шуудхан хэлж байсан гээд бод доо. Нобелийн шагналтныг халахын тулд байж болох бүхнээ дайчлахаа тус улсын эрх баригчид ний нуугүй илтгэж байлаа. Бангладешийн Сангийн сайд өнгөрсөн хоёрдугаар сард Юнусыг өөрийн хүсэлтээр халагдах өргөдлөө өг хэмээн ил тод шахаж, турхирч байсан ч удаатай.

Ер нь бүх зүйл 2007 оноос эхтэйг банкирын ойр дотныхон ярьдаг юм билээ. Юнус Бангладешийн Засгийн газрын тэргүүнтэй муудалцсан үеэс л энэ бүх явуулга эхэлсэн хэмээн үзэх хүн цөөнгүй. Учир юу гэвэл Мохаммад Юнус өөрийн гэсэн улс төрийн нам байгуулж, авлигатай тэмцэх бодол тээж явдгаа цухалзуулсан удаатай аж. Тийм ч болохоор төрийн эрх баригчид Юнусыг “жийчихээд”, банкинд нь бүтцийн өөрчлөлт хийж, төрийн мэдэлд авах бодолтой байгаа зарим хүн онцолж буй. Ямартай ч “Grameen Bank”-ны ТУЗ-ийн даргаар Бангладешийн Засгийн газар “өөрийн хүн” болох Музаммель Хукийг томилж амжив.

Юнусыг дэлхийн санхүүгийн ертөнцийн олон нөлөө бүхий хүн хамгаалж байгааг дурдах нь зүйтэй болов уу. Бүр Бангладеш улсад 1971 оноос хойш нийт таван тэрбум ам.долларын тусламж үзүүлсэн АНУ-ын төрийн албан

» ёсны төлөөлөгч Юнусыг шударга бусаар албан тушаалаас нь чөлөөлж буй асуудал хоёр орны харилцаанд сэв суулгаж мэдэхийг ч анхааруулж байжээ.

BBC-гийн сурвалжлагчид Бангладешийн эдийн засагчдаас энэ тухай байр суурийг нь лавлахад бараг бүгд л нэг зүйлийг тэмдэглэж байсан аж. Юнусыг халснаар “Grameen Bank”-ны тогтвортой үйл ажиллагаа алдагдаж, энэ нь улсын эдийн засаг, нийгэмд сөрөг нөлөө үзүүлж мэднэ. Ер нь Бангладешийн орон нутгийн эдийн засгийн тулгуур болж чадсан бичил зээлийн салбарт муу үр дагавар авчирж магадгүйг мэргэжлийн хүмүүс онцолжээ. Гэхдээ юмыг яаж мэдэх вэ, Юнусыг халсан ч онцын өөрчлөлт гарахгүй, нэг их аюултай зүйл болохгүй ч байж болно шүү дээ.

## Pro et Contra

Сүүлийн үед бичил зээлийн салбар Бангладеш төдийгүй бусад оронд ч шүүмжлэлд элбэг өртөж, ялангуяа төрийн эрх баригчдын зүгээс “жавтий хүртэх” болсон билээ. Бичил зээлийн зарим байгууллага хэт өндөр хүүтэй зээл өгч байгаагийн зэрэгцээ өр барагдуулах ажилдаа байж болшгүй “аймшигт” арга хэрэглэдэг гэх. “Grameen Bank”-ны амжилтыг ч хэт дээгүүр үнэлсэн төдийгүй тус банкны гаргадаг зээл ч асар өндөр хүүтэй хэмээн шүүмжлэгчид үздэг ажээ.

Бангладешийн хөрш орон болох Энэтхэгт л гэхэд өрөө төлж чадахгүйгээсээ болж Андхра-Прадеш мужийн 70 гаруй хүн амиа егүүтгэсэн байна. Үүний үр дүнд тус улсын эрх баригчид бичил зээлийн байгууллагуудыг орон нутгийн эрх баригчидтай харилцан тохиролцсоны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах тушаал буулгажээ. Гэхдээ Энэтхэгийн 26 орчим сая иргэнийг ажилтай болгосон бичил зээлийг бүрмөсөн зогсоох тухай яриа ч гараагүйг онцлох нь зүйтэй байх.

Чикагогийн их сургуулийн санхүүгийн профессор, өмнө нь Олон улсын валютын сангийн ахлах эдийн засагч байсан Рахурам Раджан тун сонирхолтой өнцгөөс

тайлбар гаргасан нь бий. Сүүлийн үед “сайн үйлс хийнгээ сайхан байх” (“do well by doing good”) гэсэн томъёололд суурилсан бизнесийн загвар дэлгэрч буйг тэрбээр онцолсон байдаг. Ийм загварын тод жишээ бол нийгмийн эмзэг бүлгийнхэнд олгох зээл гэдгийг ч тэмдэглэжээ. Түүний үзэж буйгаар энэ төрлийн “сайн бизнес”-ийг хэт дээгүүр үнэлэхэд хялбар байдаг аж. Гэвч өчүүхэн бага хэмжээний зээл авснаар ядуус жинхэнэ бизнес хийх нь бараг боломжгүйг зээл олгож байгаа эрхмүүд анзаардаггүйг Раджан шүүмжилжээ.

Гэхдээ л бичил зээл буурай хүмүүсийн хувьд олон талын ашигтай байдгийг Раджан үгүйсгэсэнгүй. Үүний тусламжтайгаар хүмүүс арвиг хямгач болдог төдийгүй аж ахуйгаа өргөжүүлэх зорилго, эрмэлзлэлтэй болдог аж. Хоёр дахь үнээ, эсвэл трактор авдаг ч юм уу. Мэдээж мөнгө өсгөнө гэдэг ядуучуудын хувьд чинээлэг хүмүүстэй харьцуулашгүй, хэцүү. Түүнчлэн хүүхдүүдээ сургах, гэнэтийн тохиолдол гарах үед зарцуулах зэрэгт бичил зээл үнэхээр тусалдаг тухай Раджан өгүүлжээ.

Энэ бүх нүдэнд харагдаж, гарт баригдах сайн талуудыг үл харгалзан олон орны улс төрчид бичил зээлийн гайхамшигийг няцааж байгаа юм. Ядуусыг “хулхидах” нь нийгмийн бусад давхаргын хүмүүсийг хуурахаас хамаагүй амар хэмээн тэд өөрсдийн үзэл бодлоо тайлбарлах. Харин бичил зээлийг

дэмжигч талынхны тайлбарыг өөрсдийн үзэл бодолдоо хэт үнэмшсэн этгээдүүд зүгээр л нэг чихээрээ оруулаад, нөгөө чихээрээ гаргачихна. Тухайлбал, энгийн банкуудыг бодвол орон нутгийн ядуустай ажилладаг бичил зээлийн байгууллагууд хамаагүй их зардал гаргадаг учир хүү өндөр байдаг гэх тайлбарыг ердөө авч хэлэлцдэггүй ажээ. Ерөнхийдөө бичил зээлийн салбар нийгэмд мэдэгдэхүйц олон сайн тал авчирсныг Раджан онцолж байгаа. Ядуусыг Засгийн газраас хараат бус болгож буй учраас л бичил зээлийг улс төрчид нэг нүдээрээ ч үзэхгүй байх талтайг тэрбээр мөн тэмдэглэжээ.

